



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 18 (351)

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- *Усны тухай*
- *Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай*

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- *Төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх, орон нутгийн өмчийн зарим эд, хөрөнгийг төрийн өмчид хүлээн авах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар  
Улаанбаатар хот

2004 он



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот

2004 оны тавдугаар сарын 10

№18 (351)

## Гарчиг

### Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

219.	Усны тухай	355
220.	Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай	368
221.	Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	368
222.	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийн нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хувь, хэмжээний тухай хуульд нэмэлт оруулах тухай	368
223.	Усны тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай	369
224.	Статистикийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	369

### Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

225.	Төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх, орон нутгийн өмчийн зарим эд хөрөнгийг төрийн өмчид хүлээн авах тухай	Дугаар 18	372
------	--	-----------	-----

### Гурав. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

226.	Төсвийн төлөвлөлтийн үе шатыг тогтоох тухай	Дугаар 73	389
227.	Дүрэм батлах тухай	Дугаар 74	390

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 4 дүгээр  
сарын 22-ны өдөр

Улаанбаатар  
хот

### УСНЫ ТУХАЙ НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

#### Нийтлэг үндэслэл

#### 1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь ус, түүний сав газрыг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

#### 2 дугаар зүйл. Усны тухай хууль тогтоомж

2.1. Усны тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль<sup>1</sup>, Байгаль орчныг хамгаалах тухай хууль<sup>2</sup>, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль<sup>3</sup>, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

<sup>1</sup> Монгол Улсын Үндсэн хууль - "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1992 оны 1 дүгээрт нийтлэгдсэн.

<sup>2</sup> Байгаль орчныг хамгаалах тухай хууль - "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1995 оны 5-6 дугаарт нийтлэгдсэн.

<sup>3</sup> Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль - "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 25 дугаарт нийтлэгдсэн.

## 3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно.

3.1.1. "усны нөөц" гэж одоо ашиглаж байгаа, цаашид ашиглаж болох гадаргын болон газрын доорхи усыг;

3.1.2. "усны сав газар" гэж гадаргын ус хурах талбай, газрын доорхи ус агуулсан чулуулаг бүхий орчинг;

3.1.3. "усны сан бүхий газар" гэж нуур, цөөрөм, тойром, гол мөрөн, горхи, булаг, шанд, мөнх цас, мөсөн голын эзэлж байгаа газрыг;

3.1.4. "онцгой болон энгийн хамгаалалтын бүс" гэдэгт усны эх, ундарга, нөөцийг хомсдох, бохирдохоос хамгаалах зорилгоор тогтоосон зурвас газрыг;

3.1.5. "эрүүл ахуйн бүс" гэдэгт усны эх үүсвэрийг бохирдохоос хамгаалах зорилгоор тогтоосон зурвас газрыг;

3.1.6. "хилийн ус" гэж Монгол Улсын хилийн шугамын дагуу буюу огтлон оршиж буй гадаргын ба газрын доорхи усыг;

3.1.7. "усан сан" гэж усыг хуримтлуулан ашиглах зориулалтаар баригдсан усны барилга, байгууламж, хиймэл нуур, цөөрмийг;

3.1.8. "усны барилга байгууламж" гэж усны түрэлт болон урсацыг тохируулах, ус хадгалах, дамжуулах, хуваарилах, түгээх, ариутгах, цэвэрлэх, түүний чанарыг сайжруулах, газрын доорхи ус олборлох, усны гамшигаас хамгаалах энгийн болон инженерийн хийц бүхий барилга, байгууламжийг;

3.1.9. "услалтын систем" гэж бэлчээр, хадлан, тариаланг услах зорилгоор гадаргын болон газрын доорхи усыг хуримтлуулах, дамжуулах, хуваарилах, түгээх, илүүдэл усыг зайлуулах зориулалт бүхий усны барилга байгууламж, тоног төхөөрөмжийг багтаасан иж бүрэн цогцолборыг;

3.1.10. "ашиглаж болох боломжит нөөц" гэж сав газрын экосистемийн тэнцвэрт

байдлыг хангах нөхцөлтэйгээр тодорхой хугацаанд авч ашиглаж болох усны нөөцийн дээд хэмжээг;

3.1.11. "усны аудит" гэж усны алдагдал болон ус хэмнэх нөхцөлийг тогтоож, түүнд шаардагдах хөрөнгийг тооцох, усны хэрэглээнд үнэлгээ хийх ажиллагааг;

3.1.12. "усны менежментийн төлөвлөгөө" гэж тухайн сав газрын усны нөөцийг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээхтэй холбогдсон бодлогын баримт бичгийг;

3.1.13. "усны экологи-эдийн засгийн үнэлгээ" гэж усны нөөцийн хэмжээ, чанар, хэрэглээний ач холбогдлыг өртгөөр илэрхийлсэнийг;

3.1.14. "ус ашиглагч" гэж ашиг олох зорилгоор үйлдвэрлэл, үйлчилгээндээ ус, усан орчинг ашигладаг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг;

3.1.15. "ус хэрэглэгч" гэж ашиг олох зорилгогүйгээр унд, ахуйн хэрэглээ болон мал аж ахуй, газар тариаланд ус, усан орчинг ашигладаг хэрэглэгчийг.

## 4 дүгээр зүйл. Усны нөөц

4.1. Монгол Улсын усны нөөцийн сан нь улсын хилийн доторхи гадаргын болон газрын доорхи усны нөөцөөс бүрдэнэ.

4.2. Усны нөөц нь экологи-эдийн засгийн үнэлгээтэй байна.

## 5 дугаар зүйл. Усны эрэл, хайгуул, судалгаа

5.1. Усны нөөц, түүнээс ашиглаж болох боломжит нөөцийн хэмжээг эрэл, хайгуул, судалгаагаар тогтооно.

5.2. Усны нөөц бүрэлдэн бий болох, хувьсан өөрчлөгдөх зүй тогтлыг үндэслэн усны нөөц, түүнээс ашиглаж болох боломжит нөөцийн хэмжээг тогтоох эрэл, хайгуулын ажлыг улсын төсвийн хөрөнгөөр усны менежментийн төлөвлөгөөний дагуу гүйцэтгэнэ.

5.3. Усны эрэл, хайгуул, судалгаа явуулах шийдвэрийг дараахь этгээд гаргана:

5.3.1.эдийн засгийн бүс, усны сав газрын гидрогеологийн болон гидрологийн судалгаа, улсын зэрэглэлтэй хот, бусад хот тосгон, суурин газрын усан хангамж, малын бэлчээр, хадлан, тариаланг усжуулах усны эх үүсвэрийн эрэл, хайгуул, судалгаа явуулах шийдвэрийг Засгийн газар;

5.3.2.иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах усны эх үүсвэрийн эрэл, хайгуул, судалгаа явуулах шийдвэрийг аймаг, нийслэлийн байгаль хамгаалах албаны дүгнэлтийг үндэслэн сум, дүүргийн Засаг дарга.

5.4.Усны эрэл, хайгуул, судалгааны ажлыг дараахь эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

5.4.1.энэ хуулийн 5.3.1-д заасан үйл ажиллагааг улсын төсвийн хөрөнгөөр, 5.3.2-д заасан үйл ажиллагааг захиалагчийн хөрөнгөөр тус тус гүйцэтгэнэ.

5.5.Энэ хуулийн 5.3.1-д заасан хөрөнгөөр явуулах усны эрэл, хайгуул, судалгааны ажлын гүйцэтгэлийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын тухай хуульд<sup>1</sup> заасны дагуу сонгон шалгаруулна.

5.6.Усны эрэл, хайгуул, судалгаа явуулсан байгууллага хайгуул, судалгааны ажлын дүнг баталгаажуулан, мэдээ, тайланг улсын усны мэдээллийн санд хүлээлгэн өгөх үүрэгтэй.

## 6 дугаар зүйл. Усны хяналт-шинжилгээний сүлжээ

6.1.Усны хяналт-шинжилгээний сүлжээ нь усны нөөц, чанарын өөрчлөлт, бохирдлын түвшинг тогтоох байнгын ажиллагаатай өртөө, ажиглалтын цооногоос бүрдэнэ.

6.2.Усны хяналт-шинжилгээний өртөө, харуулын тоо, байршил, шинжилгээний төрөл, арга зүйг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага баталж, мэргэжлийн удирдлагаар хангана.

6.3.Усны хяналт-шинжилгээний сүлжээг тоноглох, багаж хэрэгслээр хангах, сүлжээг

ажиллуулах зардлыг улсын төсвийн болон аж ахуйн нэгж, байгууллагын хөрөнгөөр тус тус санхүүжүүлнэ.

## 7 дугаар зүйл. Усны мэдээллийн сан ба кадастр

7.1.Улсын усны мэдээллийн сан нь аймаг, нийслэлийн гадаргын ба газрын доорхи усны нийт ба ашиглалтын нөөц, чанар, өөрчлөлт, хяналт шинжилгээний мэдээлэл, ус ашиглалт болон бохир ус зайлуулахтай холбогдсон мэдээ, хайгуул, судалгааны тайлан, усны барилга байгууламжийн үзүүлэлт зэрэг мэдээ, мэдээллээс бүрдэнэ.

7.2.Улсын усны кадастр нь усны нөөцийн байршил, хил хязгаар, эзлэх талбай, төлөв байдлын үзүүлэлтүүд, экологи-эдийн засгийн үнэлгээ, ус хэрэглэгч, ашиглагчийн тухай мэдээлэл, ашиглалтын горим, ашигласан усны хэмжээ, чанар болон усны улсын мэдээллийн сангаас бүрдэнэ.

7.3.Усны мэдээллийн сан болон улсын усны кадастрыг бүрдүүлэх үзүүлэлт, хөтлөх журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

## 8 дугаар зүйл. Усны тоо бүртгэл

8.1.Усны эх үүсвэрийн тоо, нөөц, чанар, ашигласан болон хаягдал усны хэмжээ, бүртгэлийг аймаг, нийслэл, сум, дүүргийн хэмжээнд тухайн шатны Засаг даргын шийдвэрээр жил бүр орон нутгийн төсвийн хөрөнгөөр, улсын хэмжээнд 4 жил тутам улсын төсвийн хөрөнгөөр холбогдох мэргэжлийн байгууллага явуулж, улсын усны мэдээллийн санд оруулна.

8.2.Усны тоо бүртгэл явуулах журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

8.3.Ус ашиглагч, хэрэглэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага усны тоо бүртгэлтэй холбогдсон мэдээг эрх бүхий байгууллагад гарган өгөх үүрэгтэй.

<sup>1</sup> Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын тухай хууль - Төрийн мэдээлэл эмэгтэгийн 2000 оны 17 дугаарт нийлэгдсэн.

**ХОЁРДУГААР БҮЛЭГ****Усны харилцааны талаархи төрийн байгууллагын бүрэн эрх****9 дүгээр зүйл. Улсын Их Хурлын бүрэн эрх**

9.1.Улсын Их Хурал усны харилцааны талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

9.1.1.усны талаархи төрийн бодлогыг тодорхойлох;

9.1.2.усны нөөц ашигласны төлбөрийн хувь, хэмжээг тогтоох;

9.1.3.томоохон гол, мөрний урсацын тохируулга хийх, шилжүүлэх асуудлыг шийдвэрлэх;

9.1.4.хил дамжсан гол мөрөн, нуурын асуудлаар гадаад орнуудтай байгуулсан гэрээ, хэлэлцээрийг соёрхон батлах, цуцлах.

**10 дугаар зүйл. Засгийн газрын бүрэн эрх**

10.1.Засгийн газар усны харилцааны талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

10.1.1.усны талаархи төрийн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулж, хангах;

10.1.2.улсын усны менежментийн төлөөлөгөөг батлах;

10.1.3.усны нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, усжуулах арга хэмжээний зардлыг тухайн жилийн төсөвт тусгах;

10.1.4.усны экологи, эдийн засгийн үнэлгээг батлах;

10.1.5.хүн амыг эрүүл, ахуйн шаардлагад нийцсэн ундны усаар хангах хөтөлбөр батлах;

10.1.6.эрчим хүч үйлдвэрлэх зорилгоор /сл./ мөрний усыг ашиглах асуудлыг шийдвэрлэх;

10.1.7.хуульд заасан бусад бүрэн эрх.

**11 дүгээр зүйл. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх**

11.1. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага усны харилцааны асуудлаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ

11.1.1. усны эрэл, хайгуул, судалгааны ажлын тайланг баталгаажуулж, ашиглаж болох боломжит нөөцийг батлах;

11.1.2.энэ хуулийн 10.1.2-т заасан төлөвлөгөөний төслийг Засгийн газарт оруулах;

11.1.3.хууль тогтоомжид нийцүүлэн ус ашиглалт, хамгаалалт, усны орчин нөхөн сэргээх, уст цэг, усны барилга байгууламжийг ашиглах, эзэмших талаархи дүрэм, журам, аргачлал, заавар зэргийг холбогдох төрийн захиргааны төв байгууллагатай хамтран баталж, мөрдүүлэх;

11.1.4.усны нөөцийн төлөв байдал, чанарыг тодорхойлох үнэлгээ өгөх, нөөцийн өөрчлөлт, хадгалалт, түгээлтийг хянан дүгнэх үүрэг бүхий хяналт-шинжилгээний сүлжээ ажиллуулах;

11.1.5.улсын усны мэдээллийн сан, кадастр, бүрдүүлэх ажлын хэрэгжилтэд хяналт тавих;

11.1.6.усны нөөц байгалийн жамаараа нөхөн сэргээх, цэвэрших чадвар буурсан тохиолдолд мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах усыг хуваарилах, хязгаарлах, ус, түүний орчин нөхөн сэргээх зорилгоор ус ашиглахыг тодорхой хугацаагаар хориглох;

11.1.7.хүн амыг эрүүл, ахуйн шаардлагад нийцсэн усаар хангах хөтөлбөрийн хэрэгжилтийг холбогдох төрийн захиргааны төв байгууллагатай хамтран зохион байгуулах;

11.1.8.усны эрэл, хайгуул хийх мэргэжлийн байгууллагын эрх олгох, цуцлах;

11.1.9.байгаль-экологийн тэнцвэрт байдлыг хангах үүднээс усны нөөцийн менежментийн бодлого, зохицуулалтаар хангах;

11.1.10.хилийн усны хамтарсан өртөө, харуулын сүлжээ байгуулах, үер болон бусад нөлөөллөөс урьдчилан сэргийлэх талаар хөрш орнуудтай гэрээ, хэлэлцээр байгуулах;

11.1.11. усны нөөцийн судалгааны шинжлэх-ухаан, техникийн нэгдсэн бодлого боловсруулж, батлуулан хэрэгжүүлэх;

11.1.12. энэ хуулийн 5.3.1-д заасан хайгуул, судалгааны ажилд шаардагдах улсын төсвийн хөрөнгийг төлөвлөх, хуваарилах, биелэлтийг дүгнэн, гүйцэтгэгчийг санхүүжүүлэх;

11.1.13. энэ хуулийн 5.3.1-д заасан хайгуул, судалгааны ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах.

## **12 дугаар зүйл. Усны асуудал эрхэлсэн Засгийн газрын эрх бүхий байгууллагын бүрэн эрх**

12.1. Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний эрхлэх асуудлын хүрээнд усны асуудал эрхэлсэн Засгийн газрын эрх бүхий байгууллага ажиллана.

12.2. Усны асуудал эрхэлсэн Засгийн газрын эрх бүхий байгууллага усны харилцааны асуудлаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

12.2.1. усны нөөцийг нэгдмэлээр ашиглах, хамгаалах, түүний орчныг нөхөн сэргээх менежментийн төлөвлөгөөг боловсруулах;

12.2.2. усны эрэл, хайгуул, зураг төсөл, эрдэм шинжилгээ, судалгааны төлөвлөгөө боловсруулах;

12.2.3. усны нөөцийг хэмнэх, эргүүлж ашиглах даалгавар, хяналтын тоог ус ашиглагч болон гол, мөрний сав газраар тогтоон баталж, мөрдүүлэх;

12.2.4. усны экологи-эдийн засгийн үнэлгээг боловсруулах;

12.2.5. химийн бодис хэрэглэдэг үйлдвэр, үйлчилгээний газрын хаягдал усыг цэвэршүүлэх техникийн нөхцөл, стандартыг дэвшилт технологи, шинжлэх ухааны ололтод тулгуурлан боловсруулж, батлуулах;

12.2.6. усны сав газрын зөвлөл, усны мэргэжлийн байгууллага, аймаг, нийслэлийн байгаль орчны албыг мэргэжлийн удирдлагаар хангах;

12.2.7. усны сав газрын хэмжээнд усны экологийн үнэлгээ хийх ажлыг зохион байгуулах;

12.2.8. голын голдирлыг түр буюу хэсэгчлэн өөрчлөх, усны урсацын тохируулга хийх, усны сан бүхий газрын ашиглалтын төсөлд мэргэжлийн дүгнэлт гаргах;

12.2.9. усны нөөцийн өөрчлөлтөд хяналт, шинжилгээ хийх, усны мэдээллийн сан ба улсын усны кадастрыг хөтлөх, усны төлөв байдалтай холбогдолтой мэдээллээр иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг хангах;

12.2.10. үйлдвэрлэлийн хаягдал усыг дахин ашиглах техникийн нөхцөл боловсруулж, мөрдүүлэх;

12.2.11. энэ хуулийн 5.3.1, 5.3.2-д заасан хайгуул, судалгааны ажлын явцад хяналт тавьж, тайлан гүйцэтгэлийг баталгаажуулах;

12.2.12. бэлчээр, хадлан, тариаланг усжуулах инженерийн хийцтэй услалтын систем барих ажлын хайгуул, судалгаа, зураг төсөлд мэргэжлийн дүгнэлт хийж, байгаль орчин, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

12.2.13. хуульд заасан бусад бүрэн эрх.

12.4. Аймаг, нийслэлийн байгаль орчны алба нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

12.4.1. усны тухай хууль тогтоомжийн биелэлтийн явцад хяналт тавьж, үр дүнг аймаг, нийслэлийн Засаг дарга, усны асуудал эрхэлсэн Засгийн газрын байгууллагад тайлагнах;

12.4.2. аймаг, нийслэлийн усны мэдээллийн санг бүрдүүлж, мэдээг усны асуудал эрхэлсэн Засгийн газрын байгууллагад өгөх;

12.4.3. усны нөөцийг ашиглах, усны орчинг нөхөн сэргээх, хамгаалах үйл ажиллагаанд хяналт тавих;

12.4.4. ус ашиглах зорилгоор цооног өрөмдөх зөвшөөрөл олгох эсэх талаар зохих шатны Засаг даргад санал оруулах;

12.4.5. усны тооллогыг нутаг, дэвсгэрийнхээ



хэмжээнд зохион байгуулах.

12.5. Сум, дүүргийн байгаль хамгаалагч усны харилцааны талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

12.5.1. сум, дүүргийн Засаг даргын шийдвэрийг үндэслэн ус ашиглагчтай гэрээ байгуулан эрхийн бичиг олгож, усны мэдээллийн санд бүртгүүлнэ;

12.5.2. усны нөөц ашигласны төлбөрийг зохих хууль тогтоомжийн дагуу ногдуулж, гүйцэтгэлийг хангах.

### 13 дугаар зүйл. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх

13.1. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

13.1.1. усны тухай хууль тогтоомжийн хэрэгжилт, гаргасан шийдвэрийнхээ биелэлтэд хяналт тавих, энэ талаар Засаг даргын тайланг хэлэлцэж, дүгнэлт өгөх;

13.1.2. усны нөөцийг зохистой ашиглах, хамгаалах, усны орчинг нөхөн сэргээх, усны хөнөөлөөс урьдчилан сэргийлэх талаар сав газрын зөвлөл, Засаг даргаас оруулсан дүгнэлт, хөтөлбөрийг хэлэлцэж, батлах;

13.1.3. Засаг даргын саналыг үндэслэн гадаргын усыг орон нутгийн хамгаалалтад авах, хамгаалалтын бүсийн заагийг тогтоох;

13.1.4. хуульд заасан бусад эрх.

### 14 дүгээр зүйл. Аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрх

14.1. Аймаг, нийслэлийн Засаг дарга дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

14.1.1. ус хуримтлуулах, нөхөн сэргээх, зохистой ашиглах, чанарыг нь хамгаалах, усны хөнөөлөөс урьдчилан сэргийлэх, уршгийг арилгах арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн хэмжээг тодорхойлж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулах,

14.1.2. аймгийн төв, нийслэлд хөрсний усны түвшин доошилж хомсдохоос сэргийлэх, үерийн аюулаас хамгаалах арга хэмжээг орон нутгийн төсвийн хөрөнгөөр гүйцэтгүүлэх;

14.1.3. улсын зэрэглэлтэй хотын төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрийн эрэл, хайгуул, судалгааны захиалга гаргаж, байгаль орчны болон дэд бүтцийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад оруулах;

14.1.4. ус, усны орчинг ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх, усны барилга, байгууламжийг барихтай холбогдсон үйл ажиллагааг удирдах;

14.1.5. хуульд заасан бусад бүрэн эрх.

### 15 дугаар зүйл. Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх

15.1. Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

15.1.1. нутаг, дэвсгэртээ усны тухай хууль тогтоомж, гаргасан шийдвэрийнхээ биелэлтэд хяналт тавих, энэ талаархи Засаг даргын тайланг хэлэлцэж, дүгнэлт өгөх;

15.1.2. энэ хуулийн 14.1.1-т заасан хөтөлбөрийг нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын төсвийг баталж, түүний биелэлтэд хяналт тавих;

15.1.3. усны барилга, байгууламжийг өмчлөгч, эзэмшигчтэй зөвшилцсөний үндсэн дээр усны үйлчилгээний хөлсийг тогтоох;

15.1.4. хуульд заасан бусад бүрэн эрх.

### 16 дугаар зүйл. Сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрх

16.1. Сум, дүүргийн Засаг дарга дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

16.1.1. нутаг, дэвсгэртээ ус хуримтлуулах, нөхөн сэргээх, зохистой ашиглах, чанарыг нь хамгаалах, усны хөнөөлөөс урьдчилан сэргийлэх, уршгийг арилгах арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг төлөвлөж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулан хэрэгжилтийг хангах;

16.1.2.усыг үйлдвэрлэлийн зориулалтаар зөвшөөрөлгүй ашигласан, дур мэдэн цооног гаргасан үйл ажиллагааг таслан зогсоох;

16.1.3.мэргэжлийн байгууллагын саналыг үндэслэн нутаг дэвсгэртээ бохир ус зайлуулах цэг тогтоох;

16.1.4.усны нөөц хомсдох, гол, горхи, нуур, булаг, шанд, худгийн ус ширгэх, бохирдох тохиолдолд тухайн эх үүсвэрээс ус ашиглахыг зогсоох, тэдгээрийг нөхөн сэргээх, ойжуулах, ургамалжуулах, байгальд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх талаар шийдвэр гаргах;

16.1.5.нутаг дэвсгэр дахь усны эх үүсвэр, усан сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүс тогтоож, тэмдэгжүүлэх;

16.1.6.усны нөөцийг хомсдох, бохирдохоос хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх ажлыг сурталчлах;

16.1.7.ус ашиглах зорилгоор цооног өрөмдөх тухай иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийг хүлээн авч, ажлын 14 хоногт багтаан шийдвэрлэх;

16.1.8.усны асуудал эрхэлсэн Засгийн газрын эрх бүхий байгууллага, аймаг, нийслэлийн байгаль орчны алба, байгаль хамгаалагчийн дүгнэлтийг үндэслэн ус ашиглуулах шийдвэр гаргах.

16.1.9.хуульд заасан бусад бүрэн эрх.

## **17 дугаар зүйл. Баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын бүрэн эрх**

17.1.Баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

17.1.1.нутаг, дэвсгэртээ усны тухай хууль тогтоомжийг хэрхэн хэрэгжүүлж байгаа тухай баг, хорооны Засаг даргын мэдээллийг сонсох;

17.1.2.багийн нутаг, дэвсгэрт байгаа худаг, усан сан, усалтын системийн ашиглалт, эзэмшилийг зохицуулах, бэлчээр, хадлан, тариаланг усжуулах зорилгоор худаг гаргах, хөв,

усан сан, усалтын систем байгуулах талаар Засаг даргын саналыг хэлэлцэн шийдвэрлэх;

17.1.3.хуульд заасан бусад бүрэн эрх.

## **18 дугаар зүйл. Баг, хорооны Засаг даргын бүрэн эрх**

18.1.Баг, хорооны Засаг дарга дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

18.1.1.усны нөөцийг хомсдох, бохирдохоос хамгаалах, зохистой ашиглах, усны орчинг нөхөн сэргээх тухай хууль тогтоомж, эрх бүхий байгууллагын шийдвэрийн биелэлтийг нутаг, дэвсгэртээ зохион байгуулж, хангах;

18.1.2.гол, горхи, булаг, шандын эхийг тохижуулах, мод суулгац тарих, ургамалжуулах, undаргыг нэмэгдүүлэх, бохирдохоос хамгаалах арга хэмжээнд иргэдийг татан оролцуулах;

18.1.3.нутаг, дэвсгэртээ байгаа уст цэгийн ашиглалт, хамгаалалт, эзэмшилтэд хяналт тавих;

18.1.4.усны онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг сахиулах;

18.1.5.хуульд заасан бусад эрх.

## **19 дүгээр зүйл. Сав газрын зөвлөл**

19.1.Усны нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, зохистой ашиглах талаархи нутаг, дэвсгэрийн усны менежментэд нутгийн иргэдийг оролцуулах зорилгоор гол, мөрний сав газрын зөвлөл /цаашид "сав газрын зөвлөл" гэх/ байгуулан ажиллуулна.

19.2.Сав газрын зөвлөлийн дарга, бүрэлдэхүүнийг дараахь эрх бүхий этгээдүүд томилж, чөлөөлнө:

19.2.1.хоёр буюу түүнээс дээш аймаг дамжин урсдаг гол, мөрний сав газрын зөвлөлийг тухайн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн саналыг үндэслэн байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн;

19.2.2.нэг аймгийн хоёр буюу түүнээс дээш сум дамжин урсдаг гол, мөрний сав газрын зөвлөлийг аймаг, нийслэлийн иргэдийн





Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчид;

19.2.3. тухайн сум дотор байгаа гол, мөрний сав газрын зөвлөлийг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчид.

19.3. Сав газрын зөвлөлийн бүрэн эрхийн хугацаа 4 жил байх ба ажлын үр дүнг харгалзан улируулан томилж болно.

19.4. Сав газрын зөвлөл нь дарга, нарийн бичгийн дарга, 5-15 гишүүний бүрэлдэхүүнтэй байх ба түүнд тухайн нутаг, дэвсгэрийн засаг захиргаа, байгаль орчны алба, хөдөө аж ахуй, аж үйлдвэр, төрийн бус байгууллага, иргэд, эрдэмтэн, судлаачид, байгаль хамгаалагч, мэргэжлийн хяналтын алба, усны мэргэжлийн байгууллагын төлөөлөл орсон байна.

19.5. Сав газрын зөвлөлийн шийдвэр нь дүгнэлт, тогтоолын хэлбэртэй байна.

19.6. Сав газрын зөвлөл нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

19.6.1. ус ашиглагч нь гэрээ болон энэ хуулийн 24 дүгээр зүйлд заасан үүргээ бүрэн гүйцэд хангаж байгаа эсэхэд дүгнэлт гаргах;

19.6.2. сав газрын усны нөөцийг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулан, биелэлтэд хяналт тавих;

19.6.3. ус ашиглагч этгээд байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгээр хүлээсэн нөхөн сэргээх үйл ажиллагаагаа бүрэн гүйцэд биелүүлж байгаа эсэхийг хянах;

19.6.4. усны нөөцийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэм бүрэн гүйцэд хангагдаж байгаа эсэхийг хянах;

19.6.5. усны эх, ундаргыг ойжуулах, хамгаалалтын хашаа, хайс татаж, тохижуулах ажлыг нутгийн иргэдийн дэмжлэг, санаачлага, мэргэжлийн байгууллагын хүчээр зохион байгуулахад оролцох;

19.6.6. энэ хуулийн 24 дүгээр зүйлд заасан үүргээ зохих ёсоор биелүүлээгүй этгээдийн ус

ашиглах эрхийг 14 хүртэл хоногоор түдгэлзүүлэн зогсоох, буруутай үйл ажиллагааг арилгуулах саналыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавих;

19.6.7. усны барилга, байгууламжийн зураг, төсөл, усны нөөцөд сөрөг нөлөөтэй нь мэргэжлийн байгууллагын дүгнэлтээр батлагдсан тохиолдолд түүнийг барьж байгуулах ажлыг түдгэлзүүлэх тухай санал гаргах;

19.6.8. усыг зориулалтын дагуу ашиглах, усны орчинг нөхөн сэргээх, хамгаалах талаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад мэргэжлийн туслалцаа үзүүлэх;

19.6.9. энэ хуулийн 19.6.6-д заасан эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас өгсөн үүргийг биелүүлээгүй этгээдийн ус ашиглах эрхийг бүрмөсөн цуцлах тухай дүгнэлт гарган зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлэх ба сав газрын зөвлөлийн дүгнэлтийг хүлээн авсан иргэдийн Төлөөлөгчдийн Хурал ажлын 7 хоногт багтаан хэлэлцэж, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээ авах үүргийг холбогдох Засаг даргад өгнө.

19.6.10. сав газрын зөвлөлийн дүрмийг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

## **20 дугаар зүйл. Усны мэргэжлийн байгууллага**

20.1. Усны эрэл, хайгуул, судалгаа явуулах, цооног өрөмдөх, усны барилга, байгууламжийн зураг, төсөл боловсруулах, түүнийг барих, тоноглох, ус хэмнэх технологи нэвтрүүлэх, усны шинжилгээ, аудит хийх ажлыг усны мэргэжлийн байгууллага гүйцэтгэнэ.

20.2. Усны мэргэжлийн байгууллагын үйл ажиллагааны чиглэл, гүйцэтгэх үүргийг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

20.3. Усны мэргэжлийн байгууллагын эрхийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага 5 жилийн хугацаагаар олгох бөгөөд үүргээ зохих ёсоор гүйцэтгэсэн тохиолдолд эрхийг нь 5 жил тутам сунгана.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ

### Ус хэрэглэх, ашиглах

#### 21 дүгээр зүйл. Ус ашиглах зориулалт

21.1. Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, гадаад улсын хуулийн этгээд, гадаадын иргэн, харъяалалгүй хүн тодорхой зориулалт, хугацаа, болзол, гэрээний үндсэн дээр хууль тогтоомжийн дагуу ус ашиглах эрхтэй байна.

21.2. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг ус ашиглах, хэрэглэх зориулалтаас хамааруулан дараахь байдлаар ангилна:

21.2.1. ус хэрэглэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага;

21.2.2. ус ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага;

21.3. Рашаан, эрдэс усны нөөцийг эмчилгээний зориулалтаар ашиглахтай холбогдсон харилцааг тусгай хуулиар зохицуулна.

21.4. Хилийн усны ашиглалт, хамгаалалтын асуудлыг олон улсын гэрээ, хэлэлцээрээр зохицуулна.

#### 22 дугаар зүйл. Ус хэрэглэгч

22.1. Ус хэрэглэгчид газрын доорхи ус ашиглалтын цоонгог өрөмдөх зөвшөөрлийг сум, дүүргийн Засаг дарга олгоно.

22.2. Ус хэрэглэгч нь чанарын шаардлага хангасан усаар хангагдах эрхтэй.

#### 23 дугаар зүйл. Ус ашиглагч

23.1. Гэрээ байгуулж, зөвшөөрөл авснаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын ус ашиглах эрх үүснэ.

23.2. Ус ашиглах гэрээг 20 хүртэл жилээр байгуулж, энэ хуулийн 24 дүгээр зүйлд заасан үүргээ бүрэн биелүүлж ирсэн ашиглагчийн ус ашиглах эрхийг тухай бүрд 5 хүртэл жилээр сунгана.

23.3. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын газар эзэмших эрх нь өөрийн эзэмшлийн газар

дахь ус ашиглах эрхийг төлөөлөхгүй.

23.4. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага усны эх үүсвэрийг гэрээний үндсэн дээр хамтран ашиглаж болно.

#### 24 дүгээр зүйл. Ус ашиглуулахад тавигдах шаардлага

24.1. Ус ашиглахаар хүсэлт гаргагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага дараахь шаардлагыг хангасан байна. Үүнд:

24.1.1. ус ашиглалтын явцад ялгарах бохир усаа стандартын түвшинд хүртэл цэвэршүүлэх барилга байгууламжтай байх;

24.1.2. хаягдал усыг дахин ашиглах, хэмнэлттэй зарцуулах технологитой байх;

24.1.3. усны нөөц ашигласны төлбөрийг бүрэн гүйцэд төлөх;

24.1.4. ус авах цэгт тоолуур байрлуулж, баталгаажуулах;

24.1.5. ус ашиглагч, хэрэглэгч нь ашигласан усны үйлчилгээний хэлсвэр төлөх.

24.2. Улсын зэрэглэлтэй хотын төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэр, шугам сүлжээнээс үйлдвэрлэлийн зориулалттай усны эх үүсвэр, шугам сүлжээг тусгаарлана.

24.3. Биологийн нөөц хамгаалах байгууламжгүй болон газрын хөрсийг намагжих, давсжих, эвдрэхэд хүргэхээр усны барилга байгууламж, усан сан, далан, суваг, нуур, цөөрөм байгуулж, ашиглахгүй байх.

24.4. Уул уурхайн олборлолтод ус ашиглах аж ахуйн нэгж, байгууллага ашигт малтмал баяжуулах усаа голын эрэг, голдирлыг үл хөндөн шахуурга, яндан хоолойгоор дамжуулан авах.

#### 25 дугаар зүйл. Ус ашиглах хүсэлт гаргах

25.1. Энэ хуулийн 24 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага ус ашиглах хүсэлтээ сум, дүүргийн Засаг даргад гаргана.

25.2. Ус ашиглах хүсэлтэд дараахь зүйлийг тусгана:

25.2.1 ашиглах усны эх үүсвэр, түүний байршилг харуулсан зураг;

25.2.2 усны нөөц, чанарын үнэлгээ;

25.2.3 хоногт ашиглах усны хэмжээ;

25.2.4 барилга, байгууламжийн зураг, төсөл;

25.2.5 үйлдвэрлэлийн хүчин чадал, техник, эдийн засгийн үзүүлэлт;

25.2.6 байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ.

## 26 дугаар зүйл. Ус ашиглуулах дүгнэлт гаргах

26.1. Хоногт 100 шоо метрээс дээш ус ашиглуулах дүгнэлтийг усны асуудал эрхэлсэн Засгийн газрын эрх бүхий байгууллага, 50-100 шоо метр хүртэл хэмжээний усыг ашиглуулах дүгнэлтийг аймаг, нийслэлийн байгаль орчны алба, 50 шоометр хүртэл хэмжээний усыг ашиглуулах болон гар аргаар худаг гаргах, хөв, цөөрөм байгуулах, суваг, шуудуу татах дүгнэлтийг байгаль хамгаалагч тус тус гаргана.

26.2. Энэ хуулийн 26.1-д заасан этгээд ус ашиглах тухай хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 15 өдрийн дотор дүгнэлт гаргана.

26.3 Ус ашиглах гэрээ байгуулсан этгээдэд ус ашиглах эрхийн бичиг олгож, усны мэдээллийн санд бүртгэнэ.

26.4. Энэ хуулийн 24 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангаагүй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад ус ашиглуулахыг хориглоно.

## 27 дугаар зүйл. Ус ашиглах гэрээ

27.1. Сум, дүүргийн байгаль хамгаалагч энэ хуулийн 16.1.8 дахь заалтыг үндэслэн ус ашиглагчтай гэрээ байгуулна.

27.2. Ус ашиглах гэрээнд дараахь зүйлийг тусгана:

27.2.1 ус ашиглуулах тухай сум, дүүргийн Засаг даргын шийдвэр;

27.2.2 ус ашиглах зориулалт, хоногт ашиглах усны хэмжээ;

27.2.3 усны эх үүсвэрийн байршил, барилга байгууламжийн зураг, төсөл;

27.2.4 хаях бохир усны хэмжээ, цэвэршүүлэх болон ус хэмнэх технологи, цэвэршилтийн түвшин;

27.2.5 усны төлөв байдал, чанар, найрлага;

27.2.6 ашиглах усны 1 шоо метрт ногдох нөөц ашигласны төлбөр;

27.2.7 усны эх үүсвэрийг хамгаалах, усны нөөц хомсдох, бохирдохоос сэргийлэх арга хэмжээ, түүнд зарцуулах хөрөнгийн хэмжээ;

27.2.8 гэрээ байгуулагч талуудын эрх, үүрэг;

27.2.9 шаардлагатай бусад зүйл.

## 28 дугаар зүйл. Ус ашиглах гэрээг цуцлах

28.1 Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай байгуулсан ус ашиглах гэрээг дараахь тохиолдолд зөвшөөрөл олгогчийн санаачлагаар хугацаанаас нь өмнө цуцална.

28.1.1 гэрээнд заасан үүргээ бүрэн гүйцэд биелүүлээгүй;

28.1.2 Байгаль хамгаалах тухай болон Усны тухай хууль тогтоомж зөрчсөн;

28.1.3 ус ашигласны төлбөрөө тогтоосон хугацаанд нь төлөөгүй;

28.1.4 усны эх үүсвэрийг бохирдуулсан;

28.1.5 ус ашиглагч нь тоолуур болон тохиргооны тоног төхөөрөмжөө суурилуулаагүй буюу ашигласан усны тооцоог хуурамчаар тооцсон;

28.1.6 сав газрын зөвлөлийн дүгнэлтээр.

## 29 дүгээр зүйл. Ус ашиглах эрхийн бичиг

29.1 Гэрээ байгуулж, эрхийн бичиг авсанаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын ус ашиглах эрх үүснэ.

29.2.Ус ашиглах зөвшөөрөл бүрийг усны мэдээллийн санд бүртгэнэ.

29.3.Ус ашиглах эрхийн бичгийн загварыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

### 30 дугаар зүйл . Ус ашигласны болон бохирдуулсаны төлбөр

30.1.Ус ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь ус ашигласны төлбөр төлнө.

30.2.Ус ашигласны төлбөрийн дээд, доод хэмжээ, төлбөрөөс чөлөөлөх, хөнгөлөх нөхцөлийг хуулиар тогтооно.

30.3.Ус бохирдуулж байгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага ус бохирдуулсаны нөхөн төлбөр төлнө.

30.4.Ус бохирдуулсаны нөхөн төлбөрийн хэмжээг хуулиар тогтооно.

### ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

#### Усны нөөц, чанарыг хамгаалах, усны орчинг нөхөн сэргээх

#### 31 дүгээр зүйл. Усны нөөц, чанарыг хамгаалах

31.1.Ус ашиглагч нь экологийн тэнцлийг хангахад шаардагдах хэмжээний нөөцийг байгальд заавал үлдээх үүрэг хүлээнэ.

31.2.Усны эх, ундаргад онцгой хамгаалалтын бүс тогтооно.

31.2.1.онцгой хамгаалалтын бүсэд барилга, байгууламж барих, газар хагалах, тэсэлгээ хийх, ашигт малтмал хайх, олборлох, зэгс, шагшурга, мод огтлох, элс, хайрга, чулуу авах, эмийн болон хүнс, техникийн зориулалттай ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар түүж бэлтгэх, мал угаах болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэх цэг байгуулахыг хориглоно.

31.3.Усны сан бүхий газрын эргээс 200 метрээс доошгүй зайд энгийн хамгаалалтын бүс, 100 метрээс доошгүй зайд эрүүл ахуйн бүс тогтооно.

31.4.Усны сан бүхий газар, усны эх

үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг байгаль орчны болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.

31.5.Мөрөн, гол, усны эх үүсвэр, усны сав газрыг улсын болон орон нутгийн тусгай хамгаалалтад авах асуудлыг Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулиар зохицуулна.

31.6.Улсын стандартад тохирохгүй технологи бүхий үйлдвэр, үйлчилгээний газарт ус ашиглуулахыг хориглоно.

31.7.Гол, мөрний урсацын байгалийн үндсэн голдирлыг нийт уртын дагууд өөрчлөх, голдирол дотор ашигт малтмал угаах, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэргүйгээр олборлохыг хориглоно.

31.8.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага ашиглаж дууссан цооногоо битүүмжлэн, сум, дүүргийн Засаг даргад хүлээлгэж өгнө.

#### 32 дугаар зүйл.

#### Ган,цөлжилт,хуурайшилтын үед усны нөөцийг зохистой ашиглах, хамгаалах

32.1.Ган, цөлжилт, хуурайшилтын үеийн тэнцвэр хангах зориулалтаар бороо, цас, үерийн усыг хуримтлуулах, далан, хаалт, хиймэл нуур, цөөрөм барьж, байгуулах ажлын талаархи тухайн нутгийн иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын үүсгэл санаачилгыг дэмжиж, бүх шатны Засаг дарга зохион байгуулан гүйцэтгэнэ.

32.2.Тухайн жилийн ган, цөлжилт, хуурайшилтын зэрэглэлийг аймаг, нийслэлийн Засаг дарга, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран тогтооно.

32.3.Ган, цөлжилт, хуурайшилтын зэрэглэл тогтоох болон энэ үед мөрдөх усны нөөцийн менежментийн талаархи журмыг Засгийн газар тогтооно.

#### 33 дугаар зүйл. Усны нөөцийг хэмнэх, хомсдохоос хамгаалах

33.1.Усыг хэмнэлттэй ашиглах зорилгоор ус ашиглагч бүр усны тоолууртай байх үүрэг хүлээнэ.

33.2. Усны нөөцийн байгалийн жамаар нөхөн сэргэх, цэвэрших чадвар буурсан тохиолдолд мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн үйлдвэрлэлийн зориулалтаар ус ашиглахыг зогсоож, усны орчинг нөхөн сэргээх арга хэмжээг сум, дүүргийн Засаг дарга ус ашиглагч байгууллагатай хамтран авч хэрэгжүүлнэ.

33.3. Хonoгт 50 шоо метрээс их ус ашиглагч ус хэмнэлттэй ашиглах технологи нэвтрүүлэх, бохир ус цэвэрлэх технологийн горимыг мөрдүүлэх үүрэг бүхий усны хэрэглээ хариуцсан менежертэй байна.

### 34 дүгээр зүйл. Усыг бохирдохоос хамгаалах

34.1. Усны нөөцийн сан бүхий газарт цацраг идэвхит, халдвар тараах болон химийн хорт бодисын хаягдал хадгалах, устгах, хог хаягдал, бохирдуулах бодис, үйлдвэрлэлийн бохир ус хаяхыг хориглоно.

34.2. Ус ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь ахуйн бохир ус зайлуулах цэгээ эрүүл мэндийн болон байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний тогтоосон журмын дагуу ус тусгаарлагчаар доторлож, тохижуулсан байна.

### 35 дугаар зүйл. Усыг хамгаалах, нөхөн сэргээх ажлыг урамшуулах

35.1. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухайн шатны Засаг даргын саналыг үндэслэн ус ашиглагчдад дараахь хөнгөлөлт, урамшуулалыг үзүүлж болно.

35.1.1. усыг хамгаалах, зохистой ашиглах, усны орчныг тохижуулах талаархи иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын санаачлага, үйл ажиллагааг урамшуулах;

35.1.2. өөрийн хүч, хөрөнгөөр цас, борооны ус хуримтлуулж, нуур, цөөрөм байгуулсан, худаг гаргасан, хуучин усралтын систем, уст цэгийг засч, тохижуулан тоногдсон иргэн, аж ахуйн нэгж, байгууллага тухайн байгууламжийг давуу эрхээр эзэмшинэ;

35.1.3. усыг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулж, технологийн процесст ялгарсан усаа шаардлагын хэмжээнд хүртэл цэвэршүүлсэн,

дахин ашигласан, Байгаль орчин, хүний эрүүл мэндэд ивээлтэй технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгжид ус ашиглах давуу эрх олгоно;

35.1.4. усны нөөц, чанарыг хамгаалах арга хэмжээг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлсэн, байгаль орчинд ивээлтэй, хэмнэлттэй технологи хэрэглэж байгаа ус ашиглагчийг урамшуулна.

35.2. Энэ хуулийн 35.1.1, 35.1.2, 35.1.3-т заасан урамшууллыг олгох журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

35.3. Усны нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг улс, орон нутгийн төсөв, байгаль хамгаалах сан, аж ахуйн, нэгж, байгууллагын өөрийн хөрөнгө, гадаадын зээл, тусламжаар санхүүжүүлнэ.

## ТАВДУГААР БҮЛЭГ

### Усны барилга байгууламж

#### 36 дугаар зүйл. Усны барилга байгууламж

36.1. Усны барилга, байгууламжийн зураг, төсөл боловсруулах, барих ажлыг зөвхөн эрх бүхий мэргэжлийн байгууллага гүйцэтгэнэ.

36.2. Энэ хуулийн 36.8-д зааснаас бусад улсын чанартай усны барилга байгууламж барих шийдвэрийг байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, аймаг, нийслэлийн Засаг дарга, усны асуудал эрхэлсэн Засгийн газрын эрх бүхий байгууллагын саналыг үндэслэн дэд бүтцийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гаргана.

36.3. Усны барилга, байгууламжийг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад гэрээгээр эзэмшүүлж, ашиглуулж болно.

36.4. Усны барилга, байгууламж эзэмших, ашиглах эрхийг 20 хүртэл жилийн хугацаатайгаар олгох бөгөөд нэг удаад 5 жилээр сунгана.

36.5. Усны барилга, байгууламж эзэмшигч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага бусдын усны хэрэгцээг гэрээний үндсэн дээр хангах үүрэгтэй бөгөөд гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд сум, дүүргийн Засаг дарга тухайн иргэн, аж ахуйн



нэгж, байгуулагатай байгуулсан гэрээг цуцалж болно.

36.5. Зохих зөвшөөрлийн дагуу иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өөрийн хөрөнгөөр барьж байгуулсан, сэргээн засварласан усны барилга, байгууламж нь тэдгээрийн өмчлөлд байж болох бөгөөд харин усны нөөц нь нийтийн ашиглалтад байна.

36.7. Хүн амын төвлөрсөн ус хангамж, ариутгах татуурга, усны нөөцөд тохируулга хийх, хуваарилах зориулалт бүхий толгойн барилга, байгууламж төрийн өмчид байна.

36.8. Успалтын систем барих, шинэчлэх, засварлах шийдвэрийг байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, аймаг, нийслэлийн Засаг даргын саналыг үндэслэн хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гаргана.

36.9. Усны барилга, байгууламжийг өмчлөгч, эзэмшигч нь иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийн дагуу гэрээний үндсэн дээр усаар хангана.

36.10. Усны аливаа барилга, байгууламж нь паспорттай байна.

## ЗУРГААДУГААР БҮЛЭГ

### Хариуцлага хүлээлгэх

#### 37 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

37.1. Усны тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээс эргүү бол хохирлыг нөхөн төлүүлж, шүүх болон улсын байцаагч дор дурдсан захиргааны шийтгэл ногдуулна:

37.1.1. усны тоо бүртгэлийн болон усны эрэл, хайгуулын судалгааны тайлан, мэдээг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хугацаанд нь гаргаж өгөөгүй бол иргэнийг 10000, аж ахуйн нэгж, байгууллагыг 80000 хүртэл төгрөгөөр торгох;

37.1.2. ус ашиглалтын болон бохир усны бүртгэлийг хугацаанд нь явуулаагүй, тайлан, мэдээг гаргаж өгөөгүй бол албан тушаалтныг 10000 хүртэл төгрөгөөр торгох;

37.1.3. энэ хуулийн 22.1, 23.1, 24.1-ийг зөрчсөн иргэнийг 20000 хүртэл төгрөгөөр торгох.

37.1.4. энэ хуулийн 31.3-ыг зөрчсөн албан тушаалтныг 20000 хүртэл төгрөгөөр торгох;

37.1.5. усыг үйлдвэрлэлийн зориулалтаар зохих гэрээ, зөвшөөрөлгүйгээр ашигласан буюу гэрээнд заасан хэмжээнээс хэтрүүлэн ашигласан бол хууль бусаар олсон орлогыг хурааж, зөрчил гаргасан иргэнийг 30000, аж ахуйн нэгж, байгууллагыг 50000-250000 хүртэл төгрөгөөр торгох;

37.1.6. ус ашигласны төлбөрийг хугацаанд нь төлөөгүй, усыг зөвшөөрөл авснаас өөр зориулалтаар ашигласан иргэнийг 30000, аж ахуйн нэгж, байгууллагыг 50000-250000 хүртэл төгрөгөөр торгох;

37.1.7. ус ашиглах зөвшөөрлийг бусдад худалдсан эсхүл бусдад шилжүүлсэн иргэнийг 30000, албан тушаалтныг 50000 хүртэл торгох;

37.1.8. усыг бохирдохоос хамгаалах шаардлагыг биелүүлээгүй, эсхүл усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг зөрчсөн иргэнийг 20000, аж ахуйн нэгж, байгууллагыг 50000-200000 хүртэл төгрөгөөр торгох;

37.1.9. энэ хуулийн 31.2.1, 31.7-д заасныг зөрчсөн иргэнийг 30000, аж ахуйн нэгж, байгууллагыг 50000-200000 хүртэл төгрөгөөр торгож, онцгой болон энгийн хамгаалалтын бүсийн газрыг нөхөн сэргээхтэй холбогдсон зардлыг нөхөн төлүүлэх.

#### 38 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

38.1. Энэ хуулийг 2004 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН  
ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ**



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр

Улаанбаатар хот

### ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд дор дурдсан агуулгатай 20 дугаар зүйлийн 5; 27 дугаар зүйлийн 11 дэх заалт тус тус нэмсүгэй.

1/ 20 дугаар зүйлийн 5 дугаар заалт

5. Мөрөн, гол, усны эх үүсвэрийг хамгаалах зорилго бүхий усны нөөц газар.

2/ 27 дугаар зүйлийн 11 дүгээр заалт

11. Усны нөөц доройтон хомсдож, бохирдох бодит аюул учирч байгаа улсын хэмжээний ач холбогдол бүхий том гол, сав газрыг улсын тусгай

хамгаалалтад авах асуудлыг зохих шатанд тавьж шийдвэрлүүлэх.

**2 дугаар зүйл.** 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "өөрчлөх" гэсний дараа "голын усыг бохирдуулах" гэж нэмсүгэй.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Усны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН  
ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр

Улаанбаатар хот

### ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 4.1.2-ын "аргачлал" гэсний дараа "Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батлах" гэж нэмсүгэй.

өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 12.2-ын 13.5-д гэснийг 31.4-д гэж, 12.4.2-ын 13.4 гэснийг 31.3-д гэж, 12.4.4-ийн 13.5-д гэснийг 31.4-д гэж, 12.8-ийн 15.1-д гэснийг 34.1-д гэж тус тус

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Усны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН  
ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр

Улаанбаатар хот

### БАЙГАЛИЙН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ОРЛОГООС БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, БАЙГАЛИЙН НӨӨЦИЙГ НӨХӨН СЭРГЭЭХ АРГА ХЭМЖЭЭНД ЗАРЦУУЛАХ ХӨРӨНГИЙН ХУВЬ, ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хувь, хэмжээний тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "газрын төлбөрийн орлогын 20 ба түүнээс дээш" гэсний дараа "ус, рашаан ашигласны төлбөрийн орлогын 35 ба түүнээс дээш", "үндсэн чиглэлд газар" гэсний дараа "ус," гэж тус тус нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Усны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН  
ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2004 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр

Улаанбаатар хот

**УСНЫ ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Угсын Их Хурлаас 1995 оны 4 дүгээр сарын 13-ны өдөр баталсан Усны тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Усны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА**

**Ж. БЯМБАДОРЖ****МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2004 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр

Улаанбаатар хот

**СТАТИСТИКИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Статистикийн тухай хуулийн 4, 6, 12, 16, 18, 19, 22, 23 дугаар зүйлд дараахь хэсэг, заалт нэмсүгэй:

1/ 4 дүгээр зүйлийн 7 дахь заалт:

"7/ статистикийн мэдээллийг бага зардлаар, мэдээлэгчид ачаалал багатай арга, хэлбэрээр цуглуулах."

2/ 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтын "з":

"з/ бүтээмжийн үзүүлэлтүүд."

3/ 12 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 2, 4, 21, 22 дахь заалт:

"2/ албан ёсны статистикийн үзүүлэлтийг тооцох, тооллого, судалгаа явуулах талаар ойрын зорилтыг тодорхойлсон хөтөлбөрийг боловсруулж, Улсын Их Хурлаар батлуулах;

4/ захиргааны статистикийн мэдээллийг албан ёсны статистикийн мэдээлэлтэй давхардуулахгүй байх, арга зүйн нэгдмэл байдлыг хангах зорилгоор хянах, захиргааны статистикийн мэдээллийн үзүүлэлт, аргачлал, зааврыг баглах, зөвшөөрөх, мэдээллийн хамралт үнэн зөв байдалд үнэлэлт өгөх;

21/ статистикийн мэдээллийн хэрэглэгч нь албан ёсны статистикийн мэдээллийн дүнг өөрчлөн, олон нийтэд буруу ташаа мэдээлэх тохиолдолд албан ёсны тайлбар хийж, залруулах;

22/ албан ёсны статистикийн үзүүлэлтийн зэрэгцүүлэх суурь үнийг батлах."

4/16 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 8 дахь заалт:

"8/ өмчийн бүх төрлийн аж ахуйн нэгж, байгууллагаас өгсөн мэдээ, тайлан нь дутуу, алдаатай бол холбогдох этгээдээс тайлбар гаргуулан авах, анхан шатны бүртгэлтэй тулгаж, магадлах."

5/ 16 дугаар зүйлийн 5, 6 дахь хэсэг:

"5. Статистикийн улсын байцаагч нь түүнийг томилсон эрх бүхий албан тушаалтнаас олгосон албаны болон хувийн дугаар бүхий үнэмлэх, тэмдэг, түүнчлэн шаардах хуудас, акт, торгуулийн хуудас хэрэглэнэ.

6. Статистикийн улсын байцаагч нь Төрийн албаны тухай<sup>1</sup> хуульд зааснаас гадна дараахь баталгаагаар хангагдана:

1/ статистикийн мэдээллийн үнэн зөв, бодит байдлыг хангахтай холбогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлж явахдаа хот, суурингийн доторхи нийтийн тээврийн хэрэгсэл /таксинаас бусад/-ээр зорчсон тохиолдолд хувиас гарсан зардлыг тогтоосон журмын дагуу тухайн байгууллага нь нөхөн олгох;

2/ бүрэн эрхээ хэрэгжүүлж яваад хөдөлмөрийн чадвараа түр алдсан бол хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж, албан тушаалын цалингийн зөрүүг хөдөлмөрийн чадвараа түр алдсан хугацааны туршид, тахир дутуу болсон бол тахир дутуугийн тэтгэвэр, албан тушаалын цалингийн зөрүүг тахир дутуугийн тэтгэвэр авч байгаа хугацааны туршид тус тус авах."

<sup>1</sup> Төрийн албаны тухай - "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 28 дугаарт нийтлэгдсэн.

6/ 18 дугаар зүйлийн 4 дэх заалт:

"4/ статистикийн мэдээллийг Үндэсний статистикийн газраас баталж, зөвшөөрсөн маягтаар мэдээлэгчээс гаргуулан авах."

7/ 19 дүгээр зүйлийн 6 дахь заалт:

"6/ хуулийн этгээдийг бүртгэх байгууллага нь хуулийн этгээдийн улсын бүртгэлийн жагсаалт дахь шаардлагатай мэдээлэл, түүнд орсон өөрчлөлтийг Үндэсний статистикийн газарт тухай бүрт мэдээлэх."

8/ 22 дугаар зүйлийн 6, 7 дахь хэсэг:

"6. Статистикийн төв, орон нутгийн байгууллага нь хувь хүн, хуулийн этгээдийн мэдээллийн нууцыг чанд хадгалж, мэдээллийг улс, бүс нутаг, аймаг, нийслэл, сум, дүүрэг, салбарын түвшинд нэгдсэн дүн гаргах, статистикийн үзүүлэлтийг тооцоход ашиглана."

7. Тооллого, түүвэр судалгаанд хамрагдсан хувь хүн, хуулийн этгээдийн анхдагч мэдээлэлд боловсруулалт хийсний дараа хэрэглэгчид ашиглуулж болно. Анхдагч мэдээлэлд боловсруулалт хийж, хэрэглэгчид ашиглуулахтай холбогдсон журмыг нууцын тухай хууль тогтоомжид нийцүүлэн Үндэсний статистикийн газрын дарга батална."

9/ Төслийн 23 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

"3. Статистикийн мэдээг удаа дараа тасалж, хожимдуулсан, санаатайгаар буруу мэдээлсэн аж ахуйн нэгж, байгууллагыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлэх замаар бизнесийн нэр хүндэд нөлөөлж болно."

**2 дугаар зүйл.** Статистикийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "мэдээллээр төлбөртэй үйлчилгээ явуулах," гэсний өмнө " статистикийн мэдээллийн арга зүйг боловсронгуй болгож, шинжлэх ухааны үндэслэлийг сайжруулах, статистикийн мэдээлэлд дүн шинжилгээ хийх, хөгжлийн хэтийн төлвийг тодорхойлох болон" гэж, 18 дугаар зүйлийн гарчгийн "Яам," гэсний дараа "Монголбанк," гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.** Статистикийн тухай хуулийн дараахь зүйл, хэсэг, заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ "7 дугаар зүйл. Тооллого, судалгаа явуулах

1. Үндэсний статистикийн газар дараахь тооллого, судалгааг явуулна:

а/ хүн ам, орон сууцны улсын тооллогыг 10-аас илүүгүй жил тутам;

б/ салбар хоорондын тэнцэл, нөөц ашиглалтын хүснэгтийг 5 жил тутам;

в/ мал, тэжээвэр амьтдын тооллогыг жил тутам;

г/ ерхийн аж ахуйн орлого, зарлагын судалгааг улирал тутам;

д/ хүн амын амьжиргааны түвшний түүвэр судалгааг 3 жил тутам;

е/ хүн амын нөхөн үржихүйн эрүүл мэндийн түүвэр судалгааг 5 жил тутам;

ё/ хүн амын ажил эрхлэлтийн түүвэр судалгааг улирал тутам;

ж/ хүүхэд хөгжил судалгааг 4 жил тутам;

з/ аж ахуйн нэгжийн тооллогыг 5 жил тутам;

и/ хашаа, худаг, тэжээлийн тооллогыг 3 жил тутам;

й/ цаг ашиглалтын түүвэр судалгааг 4 жил тутам улирлаар.

2. Зайлшгүй шаардлагаар энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хугацааг өөрчлөх, энэ хуульд зааснаас өөр тооллого, судалгаа явуулах асуудлыг Засгийн газар, эсхүл Үндэсний статистикийн газрын саналыг үндэслэн Улсын Их Хурал шийдвэрлэнэ.

3. Тооллого, судалгааны зардлыг Үндэсний статистикийн газрын тухайн жилийн төсөвт тусгана.

4. Үндэсний статистикийн газар нь тухайн жилд хийгдэх тооллого, түүвэр судалгааг Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусган хэрэгжүүлнэ.

5. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан тооллого явуулах хугацааны товгыг Засгийн газар, түүвэр болон иж бүрэн судалгааныхыг Үндэсний статистикийн газар тогтооно."

2/ "11 дүгээр зүйл. Статистикийн байгууллагын тогтолцоо

1. Статистикийн байгууллага нь улс, бүс нутаг, аймаг, нийслэлийн эдийн засаг, хүн ам, нийгэм, байгаль орчны талаарх статистикийн мэдээллээр төр, иргэн, аж ахуйн нэгж, байгуулагад адил тэгш үйлчилдэг төрийн байгууллага мөн.

2. Монгол Улсын статистикийн байгууллагын тогтолцоо нь албан ёсны статистикийн үйл ажиллагааг хараат бус, бие даасан байдлаар улс, орон нутгийн хэмжээнд төвлөрүүлэн эрхэлдэг Үндэсний статистикийн газар, аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын дэргэдэх статистикийн газар, хэлтсээс бүрдэнэ. Суманд

статистикийн үйл ажиллагааг сумын Засаг даргын Тамгын газрын уг ажлыг хариуцсан ажилтан, баг, хороонд тэдгээрийн Засаг дарга эрхлэн гүйцэтгэнэ.

3. Үндэсний статистикийн газар, аймаг, нийслэл, дүүргийн статистикийн газар, хэлтсийн болон сумын статистикийн асуудал хариуцсан ажилтан нь төрийн захиргааны албан тушаалтан байна.

4. Үндэсний статистикийн газар, аймаг, нийслэл, дүүргийн статистикийн газар, хэлтсийн үйл ажиллагааг улсын төсвөөс санхүүжүүлнэ. Төсөв нь статистикийн үйл ажиллагааг хараат бусаар хэрэгжүүлэх шаардлагыг хангасан байна. Статистикийн үйл ажиллагааг сум, баг, хороонд эрхлэн явуулахтай холбогдон гарах зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.

5. Үндэсний статистикийн газар үйл ажиллагаагаа Улсын Их Хуралд жил бүр тайлагнана.

6. Яам, Засгийн газрын агентлаг, төрийн бусад байгууллага, нутгийн захиргааны байгууллага чиг үүргийнхээ дагуу статистикийн үйл ажиллагааг эрхэлнэ."

3/ 3 дугаар зүйлийн 5,8 дахь заалт:

"5/ "албан ёсны статистикийн мэдээлэл" гэж Үндэсний статистикийн газраас баталсан аргачлал, үзүүлэлтээр энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан эдийн засаг, хун ам, нийгэм, байгаль орчны холбогдолтой үзүүлэлтээр гэргасан мэдээлэл, статистикийн үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан мэдээллийг;

8/ "захиргааны статистикийн мэдээлэл" гэж Үндэсний статистикийн газраас баталсан, зөвшөөрсөн аргачлал, үзүүлэлтээр яам, Засгийн газрын агентлаг, төрийн бусад байгууллага, нутгийн захиргааны байгууллагын хэрэгцээнд зориулж цуглуулсан мэдээллийг"

4/ 12 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 11 дэх заалт:

"11/ салбарын хэмжээний мэргэжлийн боловсон хүчний чадавхи, техникийн технологи, программ хангамжийн хүчин чадлыг сайжруулах асуудлыг нэгдсэн бодлого, төлөвлөгөөтэйгөөр хэрэгжүүлэх."

5/ 14 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг:

"1. Үндэсний статистикийн газарт албан ёсны статистикийн үйл ажиллагааг явуулахад туслах, арга зүйн нэгдмэл байдлыг хангах асуудлаар зөвлөх чиг үүрэгтэй Улсын Их Хурал,

Засгийн газар, эрдэм шинжилгээний байгууллага болон хэрэглэгчийн төлөөлөлтэй зөвлөл ажиллана.

3. Зөвлөл нь 7 хүний бүрэлдэхүүнтэй байна. Зөвлөлийн 3 гишүүнийг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо, 3 гишүүнийг Засгийн газар санал болгож, Улсын Их Хурал томилно. Үндэсний статистикийн газрын зөвлөлийн гишүүд нь орон тооны бус байна.

4 дүгээр зүйл. Статистикийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "албан ёсны бус" гэснийг "захиргааны" гэж; 12 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 17 дахь заалтын "аймаг, нийслэлийн статистикийн хэлтсийн дарга, дүүргийн тасгийн дарга" гэснийг "аймаг, нийслэл, дүүргийн статистикийн газар, хэлтсийн дарга" гэж; 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтын "аймаг, нийслэлийн статистикийн хэлтэс, дүүргийн статистикийн тасгийн даргыг" гэснийг "аймаг, нийслэл, дүүргийн статистикийн газар, хэлтсийн даргыг" гэж; мөн зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалтын "Улсын Их Хурлын чуулган, Байнгын хороо, Засгийн газрын хуралдаанд өөрийн байр суурийг илэрхийлэх" гэснийг "Улсын Их Хурлын чуулган, Байнгын хороо, Засгийн газрын хуралдаанд зөвлөх эрхтэйгээр оролцох" гэж; 19 дүгээр зүйлийн 3 дахь заалтын "албан ёсны статистикийн төвлөрсөн бус мэдээлэл" гэснийг "захиргааны статистик мэдээлэл" гэж; мөн зүйлийн 4 дэх заалтын "статистикийн төвлөрсөн бус мэдээллийн" гэснийг "захиргааны статистик мэдээллийн" гэж; 20 дугаар зүйлийн 3 дахь заалтын "албан ёсны статистик мэдээллийг" гэснийг "захиргааны статистик мэдээллийг" гэж; 12 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн "2" гэсэн заалтын дугаарыг "3" гэж; мөн хэсгийн "3-18" хүртэлх заалтын дугаарыг "5-20" гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл. Статистикийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтын "н" гэсэн дэд заалтын "бүтээмж" гэснийг; 9 дүгээр зүйлийн 2 дахь заалтын "аргачлалаар" гэснийг дараах "албан ёсны" гэснийг; 12 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалтын "зөвшөөрөх" гэснийг; 19 дүгээр зүйлийн 1 дэх заалтын "төвлөрсөн" гэснийг тус тус хассугай.

6 дугаар зүйл. Статистикийн тухай хуулийн 8 дугаар зүйл, 5 дугаар зүйлийн 2, 4 дэх хэсэг, 3 дугаар зүйлийн 6, 7 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцугай.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН  
ДЭД ДАРГА

Ж.БЯМБАДОРЖ





## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2004 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр

Дугаар 18

Улаанбаатар хот

Төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх, орон нутгийн өмчийн зэриг эд хөрөнгийн төрийн өмчид хүлээн авах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, 77 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

дугаар хавсралтад заасан эд хөрөнгийг төрийн өмчид хүлээн авахыг Засгийн газарт зөвшөөрсүгэй.

1. Төрийн өмчөөс орон нутгийн өмчид шилжүүлэх эд хөрөнгийн жагсаалтыг 1 дүгээр хавсралт ёсоор баталсугай.

2. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийг үндэслэн 2

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН  
ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

Монгол Улсын Их Хурлын 2004 оны  
18 дугаар тогтоолын  
1 дүгээр хавсралт

### ТӨРИЙН ӨМЧӨӨС АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ӨМЧИД ШИЛЖҮҮЛЭХ ЭД ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

#### 1. Архангай аймаг

##### Үл хөдлөх ба хөдлөх үндсэн хөрөнгө

№	Сумын нэр	Эд хөрөнгийн нэр	Нийт хөрөнгийн дүн /мян.төг/
1	Эрдэнэбулган	Өрхийн эмнэлгийн барилга	22 242.80
2	Эрдэнэбулган	Өрхийн эмнэлгийн болон аймгийн нэгдсэн эмнэлгийн оношлогоо эмчилгээний тоног төхөөрөмж, мотоцикл, компьютер, багаж	93 985.90
3	Тариат	Сум дундын эмнэлгийн оношлогоо эмчилгээний тоног төхөөрөмж	14 717.50
4	Эрдэнэмандал	Сум дундын эмнэлгийн оношлогоо эмчилгээний тоног төхөөрөмж	14 717.50
5	Чулуут	Багийн эмчийн мотоцикл	3 180.00
6	Ихтамир	Багийн эмчийн мотоцикл	3 180.00
	<b>ДҮН</b>		<b>152 023.70</b>

#### 2. Баян-Өлгий аймаг

##### Үл хөдлөх ба хөдлөх үндсэн хөрөнгө

№	Сумын нэр	Эд хөрөнгийн нэр	Нийт хөрөнгийн дүн /мян.төг/
1	Өлгий	Өрхийн эмнэлгийн барилга	22 500.00
2	Өлгий	Өрхийн эмнэлгийн болон аймгийн нэгдсэн эмнэлгийн компьютер оношлогоо эмчилгээний, сургалтын багаж, тоног төхөөрөмж, зүрхний цахилгаан бичлэгийн аппарат	27 385.50
3	Ногооннуур	Сум дундын эмнэлгийн оношлогоо эмчилгээний тоног төхөөрөмж, багийн эмчийн мотоцикл	16 307.50
4	Бугат	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
5	Булган	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
6	Дэлүүн	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
	<b>ДҮН</b>		<b>70 963.00</b>

### 3. Баянхонгор аймаг

Үл хөдлөх ба хөдлөх үндсэн хөрөнгө

№	Сумын нэр	Эд хөрөнгийн нэр	Нийт хөрөнгийн дүн /мян.төг/
1	Баянхонгор	Өрхийн эмнэлгийн барилга	24 301.30
2	Баянхонгор	Өрхийн эмнэлгийн болон оношлогоо эмчилгээний багаж төхөөрөмж, мотоцикл, компьютер, зүрхний цахилгаан бичлэгийн аппарат, сургалтын тоног төхөөрөмж	79 252.50
3	Баацагаан	Сум дундын эмнэлгийн оношлогоо эмчилгээний тоног төхөөрөмж	14 717.50
4	Бөмбөгөр	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
5	Жинст	Багийн эмчийн мотоцикл	3 180.00
6	Баянцагаан	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
7	Галуут	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
	<b>ДҮН</b>		<b>126 221.30</b>

### 4. Булган аймаг

Үл хөдлөх ба хөдлөх үндсэн хөрөнгө

№	Сумын нэр	Эд хөрөнгийн нэр	Нийт хөрөнгийн дүн /мян.төг/
1	Булган	Өрхийн эмнэлгийн барилга	19 907.90
2	Булган	Өрхийн эмнэлгийн болон аймгийн эрүүл мэндийн газар, нэгдсэн эмнэлгийн оношлогоо эмчилгээний багаж, сургалтын тоног төхөөрөмж, мотоцикл, компьютер, эмнэлгийн зүрхний цахилгаан бичлэгийн аппарат	21 616.80
3	Хутаг-Өндөр	Сум дундын эмнэлгийн оношлогоо эмчилгээний тоног төхөөрөмж, багийн эмчийн мотоцикл	16 307.50
4	Тэшиг	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
5	Гурванбулаг	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
	<b>ДҮН</b>		<b>61 012.20</b>

**5. Говь-Алтай аймаг**  
 Үл хөдлөх ба хөдлөх үндсэн хөрөнгө

№	Сумын нэр	Эд хөрөнгийн нэр	Нийт хөрөнгийн дүн /мян.төг/
1	Цээл	Малын үржлийн албаны Цээл суман дахь тэжээлийн агуулахын чулуун барилга	1 200.00
2	Есөнбулаг	Өрхийн эмнэлгийн барилга	23 106.20
3	Есөнбулаг	Өрхийн эмнэлгийн болон оношлогоо эмчилгээний багаж төхөөрөмж, мотоцикл, компьютер, зүрхний цахилгаан бичлэгийн аппарат, сургалтын тоног төхөөрөмж	25 296.10
4	Төгрөг	Сум дундын эмнэлгийн оношлогоо эмчилгээний тоног төхөөрөмж	14 717.50
5	Алтай	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
6	Хөхморьт	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
7	Бугат	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
	<b>ДҮН</b>		<b>69 089.80</b>

**6. Говьсүмбэр аймаг**  
 Үл хөдлөх ба хөдлөх үндсэн хөрөнгө

№	Сумын нэр	Эд хөрөнгийн нэр	Нийт хөрөнгийн дүн /мян.төг/
1	Сүмбэр	Өрхийн эмнэлгийн барилга	20 585.50
2	Сүмбэр	Өрхийн эмнэлгийн болон оношлогоо эмчилгээний багаж төхөөрөмж, мотоцикл, компьютер, зүрхний цахилгаан бичлэгийн аппарат, сургалтын тоног төхөөрөмж	22 826.80
	<b>ДҮН</b>		<b>43 412.30</b>

**7. Дархан-Уул аймаг**  
 Үл хөдлөх ба хөдлөх үндсэн хөрөнгө

№	Сумын нэр	Эд хөрөнгийн нэр	Нийт хөрөнгийн дүн /мян.төг/
1	Дархан	Өрхийн эмнэлгийн барилга	22 453.00
2	Дархан	Өрхийн эмнэлгийн болон оношлогоо эмчилгээний багаж төхөөрөмж, мотоцикл, компьютер, зүрхний цахилгаан бичлэгийн аппарат, сургалтын тоног төхөөрөмж, түргэн тусламжийн автомашин	156 713.00
3	Шарын гол	Өрхийн эмнэлгийн оношлогоо эмчилгээний тоног төхөөрөмж, өрхийн эмчийн мотоцикл, компьютер	7 566.20
	<b>ДҮН</b>		<b>186 732.20</b>

**8. Дундговь аймаг**  
 Үл хөдлөх ба хөдлөх үндсэн хөрөнгө

№	Сумын нэр	Эд хөрөнгийн нэр	Нийт хөрөнгийн дүн /мян.төг/
1	Мандалговь	Өрхийн эмнэлгийн барилга	21 435.00
2	Мандалговь	Өрхийн эмнэлгийн болон оношлогоо эмчилгээний багаж төхөөрөмж, мотоцикл, компьютер, зурхний цахилгаан бичлэгийн аппарат, сургалтын тоног төхөөрөмж	71 893.80
3	Эрдэнэдалай	Сум дундын эмнэлгийн оношлогоо эмчилгээний тоног төхөөрөмж, хувилгагч машин, багийн эмчийн мотоцикл	16 307.50
4	Луус	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
5	Өлзийт	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
	<b>ДҮН</b>		<b>112 816.30</b>

**9. Дорноговь аймаг**  
 Үл хөдлөх ба хөдлөх үндсэн хөрөнгө

№	Сумын нэр	Эд хөрөнгийн нэр	Нийт хөрөнгийн дүн /мян.төг/
1	Сайншанд	Өрхийн эмнэлгийн барилга	21 811.20
2	Сайншанд	Өрхийн эмнэлгийн болон аймгийн нэгдсэн эмнэлгийн оношлогоо эмчилгээний багаж төхөөрөмж, мотоцикл, компьютер, зурхний цахилгаан бичлэгийн аппарат, сургалтын тоног төхөөрөмж, түргэн тусламжийн машин	227 563.70
3	Эрдэнэ	Сумын эмнэлгийн барилга	76 998.90
4	Эрдэнэ	Сумын эмнэлгийн тоног төхөөрөмж, багийн эмчийн мотоцикл	11 691.50
5	Хөвсгөл	Сумын эмнэлгийн барилга	79 360.30
6	Хөвсгөл	Сумын эмнэлгийн тоног төхөөрөмж, багийн эмчийн мотоцикл	10 101.50
7	Сайхандулаан	Сумын эмнэлгийн барилга	68 637.00
8	Сайхандулаан	Сумын эмнэлгийн тоног төхөөрөмж, багийн эмчийн мотоцикл	11 691.50
9	Дэлгэрэх	Сумын эмнэлгийн барилга	73 717.40
10	Дэлгэрэх	Сумын эмнэлгийн тоног төхөөрөмж, багийн эмчийн мотоцикл	8 511.50
11	Замын үүд	Сум дундын эмнэлгийн оношлогоо эмчилгээний тоног төхөөрөмж	51 764.10
12	Айраг	Сумын эмнэлгийн тоног төхөөрөмж, багийн эмчийн мотоцикл	10 101.50
13	Мандах	Сумын эмнэлгийн тоног төхөөрөмж, багийн эмчийн мотоцикл	10 101.50
14	Хатанбулаг	Сумын эмнэлгийн тоног төхөөрөмж, багийн эмчийн мотоцикл	11 691.50
15	Алтанширээ	Сумын эмнэлгийн тоног төхөөрөмж, багийн эмчийн мотоцикл	10 101.50
16	Улаанбадрах	Багийн эмчийн мотоцикл	3 180.00



17	Их хэт	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
18	Өргөн	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
19	Даланжаргалан	Багийн эмчийн мотоцикл	3 180.00
<b>ДҮН</b>			<b>693 384.60</b>

**10. Дорнод аймаг**

Үл хөдлөх ба хөдлөх үндсэн хөрөнгө

№	Сумын нэр	Эд хөрөнгийн нэр	Нийт хөрөнгийн дүн /мян.төг/
1	Хэрлэн	Өрхийн эмнэлгийн барилга	23 800.00
2	Хэрлэн	Өрхийн эмнэлгийн болон аймгийн нэгдсэн эмнэлгийн оношлогоо эмчилгээний багаж төхөөрөмж, мотоцикл, компьютер, зүрхний цахилгаан бичлэгийн аппарат, сургалтын тоног төхөөрөмж, түргэн тусламжийн машин, биохимийн болон иммунологийн анализатор	35 169.60
3	Дашбалбар	Сум дундын эмнэлгийн оношлогоо эмчилгээний тоног төхөөрөмж	14 717.50
4	Цагаан Овоо	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
5	Чойбалсан	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
<b>ДҮН</b>			<b>76 867.10</b>

**11. Завхан аймаг**

Үл хөдлөх ба хөдлөх үндсэн хөрөнгө

№	Сумын нэр	Эд хөрөнгийн нэр	Нийт хөрөнгийн дүн /мян.төг/
1	Асгат	Журамт компани	2 953.20
2	Улиастай	Өрхийн эмнэлгийн барилга	25 500.00
3	Улиастай	Өрхийн эмнэлгийн болон аймгийн нэгдсэн эмнэлгийн оношлогоо эмчилгээний багаж төхөөрөмж, мотоцикл, компьютер, зүрхний цахилгаан бичлэгийн аппарат, сургалтын тоног төхөөрөмж, түргэн тусламжийн автомашин	108 664.50
4	Тосонцэнгэл	Сум дундын болон өрхийн эмнэлгийн оношлогоо эмчилгээний тоног төхөөрөмж, компьютер, багийн эмийн мотоцикл	23 666.20
5	Яруу	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
6	Идэр	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
7	Эрдэнэхайрхан	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
<b>ДҮН</b>			<b>165 553.90</b>



**12. Орхон аймаг**  
 Үл хөдлөх ба хөдлөх үндсэн хөрөнгө

№	Сумын нэр	Эд хөрөнгийн нэр	Нийт хөрөнгийн дүн /мян.төг/
1	Баян Өндөр	Өрхийн эмнэлгийн барилга	19 484.00
2	Баян Өндөр	Өрхийн эмнэлгийн болон аймгийн нэгдсэн эмнэлгийн оношлогоо эмчилгээний багаж төхөөрөмж, мотоцикл, компьютер, зүрхний цахилгаан бичлэгийн аппарат, сургалтын тоног төхөөрөмж, түргэн тусламжийн автомашин	176 699.90
<b>ДҮН</b>			<b>196 183.90</b>

**13. Өвөрхангай аймаг**  
 Үл хөдлөх ба хөдлөх үндсэн хөрөнгө

№	Сумын нэр	Эд хөрөнгийн нэр	Нийт хөрөнгийн дүн /мян.төг/
1	Арвайхээр	Өрхийн эмнэлгийн барилга	23 741.30
2	Арвайхээр	Өрхийн эмнэлгийн болон аймгийн нэгдсэн эмнэлгийн оношлогоо эмчилгээний багаж төхөөрөмж, мотоцикл, компьютер, зүрхний цахилгаан бичлэгийн аппарат, сургалтын тоног төхөөрөмж, түргэн тусламжийн машин, биохимийн болон иммунологийн анализатор	23 924.10
3	Хархорин	Сум дундын болон өрхийн эмнэлгийн оношлогоо эмчилгээний тоног төхөөрөмж, компьютер, багийн эмчийн мотоцикл	23 666.20
4	Хужирт	Өрхийн эмнэлгийн оношлогоо эмчилгээний багаж төхөөрөмж, компьютер, багийн эмчийн мотоцикл	5 269.40
5	Өлзийт	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
<b>ДҮН</b>			<b>78 191.00</b>

**14. Өмнөговь аймаг**  
 Үл хөдлөх ба хөдлөх үндсэн хөрөнгө

№	Сумын нэр	Эд хөрөнгийн нэр	Нийт хөрөнгийн дүн /мян.төг/
1	Даланзадгад	Өрхийн эмнэлгийн барилга	27 881.80
2	Даланзадгад	Өрхийн эмнэлгийн болон аймгийн нэгдсэн эмнэлгийн оношлогоо эмчилгээний багаж төхөөрөмж, мотоцикл, компьютер, зүрхний цахилгаан бичлэгийн аппарат, сургалтын тоног төхөөрөмж	71 893.80
3	Ноён	Сум дундын эмнэлгийн оношлогоо эмчилгээний тоног төхөөрөмж	14 717.50
4	Сэврэй	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
5	Мандал Овоо	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
6	Цогтцэций	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
<b>ДҮН</b>			<b>119 263.10</b>

**15. Сэлэнгэ аймаг**

Үл хөдлөх ба хөдлөх үндсэн хөрөнгө

№	Сумын нэр	Эд хөрөнгийн нэр	Нийт хөрөнгийн дүн /мян.төг/
1	Сүхбаатар	Өрхийн эмнэлгийн барилга	21 215.80
2	Сүхбаатар	Өрхийн эмнэлгийн болон аймгийн нэгдсэн эмнэлгийн оношлогоо эмчилгээний багаж төхөөрөмж, мотоцикл, компьютер, зүрхний цахилгаан бичлэгийн аппарат, сургалтын тоног төхөөрөмж	287 712.50
3	Мандал	Сум дундын болон өрхийн эмнэлгийн оношлогоо эмчилгээний тоног төхөөрөмж, компьютер	29 434.90
4	Сайхан	Өрхийн эмнэлгийн оношлогоо эмчилгээний багаж төхөөрөмж, компьютер	7 358.70
5	Алтанбулаг	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
6	Шаамар	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
7	Хүдэр	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
8	Жавхлант	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
	<b>ДҮН</b>		<b>352 081.90</b>

**16. Сүхбаатар аймаг**

Үл хөдлөх ба хөдлөх үндсэн хөрөнгө

№	Сумын нэр	Эд хөрөнгийн нэр	Нийт хөрөнгийн дүн /мян.төг/
1	Баруун-Урт	Аймгийн шүүхийн хуучин барилга	483.40
2	Баруун Урт	Өрхийн эмнэлгийн барилга	23 420.00
3	Баруун Урт	Өрхийн эмнэлгийн болон аймгийн нэгдсэн эмнэлгийн оношлогоо эмчилгээний багаж төхөөрөмж, мотоцикл, компьютер, зүрхний цахилгаан бичлэгийн аппарат, сургалтын тоног төхөөрөмж	71 893.80
4	Онгон	Сум дундын эмнэлгийн оношлогоо эмчилгээний тоног төхөөрөмж	14 717.50
5	Асгат	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
6	Баяндэлгэр	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
	<b>ДҮН</b>		<b>113 694.70</b>

**17. Төв аймаг**

Үл хөдлөх ба хөдлөх үндсэн хөрөнгө

№	Сумын нэр	Эд хөрөнгийн нэр	Нийт хөрөнгийн дүн /мян.төг/
1	Зуунмод	Өрхийн эмнэлгийн барилга	19 800.00
2	Зуунмод	Өрхийн эмнэлгийн болон аймгийн нэгдсэн эмнэлгийн оношлогоо эмчилгээний багаж төхөөрөмж, мотоцикл, компьютер, зүрхний цахилгаан бичлэгийн аппарат, сургалтын тоног төхөөрөмж, түргэн тусламжийн автомашин	88 270.30

3	Алтанбулаг	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
4	Баянцагаан	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
5	Дэлгэрхаан	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
	<b>ДҮН</b>		<b>112 840.30</b>

**18. Увс аймаг**

Үл хөдлөх ба хөдлөх үндсэн хөрөнгө

№	Сумын нэр	Эд хөрөнгийн нэр	Нийт хөрөнгийн дүн /мян.төг/
1	Улаангом	Өрхийн эмнэлгийн барилга	24 518.70
2	Улаангом	Өрхийн эмнэлгийн болон аймгийн нэгдсэн эмнэлгийн оношлогоо эмчилгээний багаж төхөөрөмж, мотоцикл, компьютер, зүрхний цахилгаан бичлэгийн аппарат, сургалтын тоног төхөөрөмж, түргэн тусламжийн автомашин	119 243.00
3	Баруунтуруун	Сум дундын эмнэлгийн оношлогоо эмчилгээний тоног төхөөрөмж	14 717.50
	<b>ДҮН</b>		<b>158 479.20</b>

**19. Ховд аймаг**

А. Цогцолбороор шилжүүлэх эд хөрөнгө

№	Сумын нэр	Байгууллагын нэр	Нийт хөрөнгийн дүн /мян.төг/
1	Жаргалант	Тэжээлийн фондын төв ТӨҮГ	68 010.70
	<b>ДҮН</b>		<b>68 010.70</b>

Б. Үл хөдлөх ба хөдлөх үндсэн хөрөнгө

№	Сумын нэр	Эд хөрөнгийн нэр	Нийт хөрөнгийн дүн /мян.төг/
1	Жаргалант	Гаалийн газрын барилгын цогцолбор, дагалдах байгууламж, хөдлөх үндсэн хөрөнгө	156 800.00
2	Жаргалант	Өрхийн эмнэлгийн барилга	25 627.50
3	Жаргалант	Өрхийн эмнэлгийн мотоцикл, компьютер, зүрхний цахилгаан бичлэгийн аппарат, сургалтын тоног төхөөрөмж, түргэн тусламжийн автомашин	46 359.00
4	Булган	Сумын эмнэлгийн барилга	165 428.80
5	Булган	Сум дундын болон өрхийн эмнэлгийн оношлогоо эмчилгээний тоног төхөөрөмж, компьютер, багийн эмчийн мотоцикл	57 033.50
6	Манхан	Сумын эмнэлгийн барилга	85 149.20
7	Манхан	Сум дундын эмнэлгийн оношлогоо эмчилгээний тоног төхөөрөмж, багийн эмчийн мотоцикл	53 354.10
8	Алтай	Сумын эмнэлгийн тоног төхөөрөмж, багийн эмчийн мотоцикл	8 511.50

9	Дарви	Сумын эмнэлгийн тоног төхөөрөмж, багийн эмчийн мотоцикл	8 511.50
10	Дөргөн	Сумын эмнэлгийн тоног төхөөрөмж, багийн эмчийн мотоцикл	8 511.50
11	Мест	Сумын эмнэлгийн тоног төхөөрөмж, багийн эмчийн мотоцикл	11 691.50
12	Мөнххайрхан	Сумын эмнэлгийн тоног төхөөрөмж, багийн эмчийн мотоцикл	8 511.50
13	Цэцэг	Сумын эмнэлгийн тоног төхөөрөмж, багийн эмчийн мотоцикл	8 511.50
14	Үенч	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
15	Зэрэг	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
16	Дуут	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
17	Ховд	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
18	Мянгад	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
19	Чандмань	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
20	Эрдэнэбүрэн	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
21	Буянт	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
22	Бугат	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
23	Рашаант	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
	<b>Дүн</b>		<b>659 901.10</b>
	<b>Ховд аймгийн дүн</b>		<b>727 911.80</b>

**20. Хөвсгөл аймаг**

Үл хөдлөх ба хөдлөх үндсэн хөрөнгө

№	Сумын нэр	Эд хөрөнгийн нэр	Нийт хөрөнгийн дүн /мян.төг/
1	Мөрөн	Стандартчилал хэмжил зүйн төвийн конторын барилга	39 855.00
2	Мөрөн	Өрхийн эмнэлгийн болон аймгийн нэгдсэн эмнэлгийн барилга	1 023 824.00
3	Мөрөн	Өрхийн эмнэлгийн болон аймгийн нэгдсэн эмнэлгийн оношлогоо эмчилгээний багаж төхөөрөмж, мотоцикл, компьютер, зүрхний цахилгаан бичлэгийн аппарат, сургалтын тоног төхөөрөмж, түргэн тусламжийн автомашин, аймгийн Эрүүл мэндийн газрын нөөцөд мотоцикл	440 416.70
4	Шинэ-Идэр	Сумын эмнэлгийн барилга	64 414.00
5	Шинэ-Идэр	Сум дундын эмнэлгийн оношлогоо эмчилгээний тоног төхөөрөмж, багийн эмчийн мотоцикл	52 863.60
6	Улаан-Уул	Сумын эмнэлгийн барилга	171 045.50

7	Улаан-Уул	Сум дундын эмнэлгийн оношлогоо эмчилгээний тоног төхөөрөмж, багийн эмчийн мотоцикл	52 863.60
8	Ринчинлхүмбэ	Сумын эмнэлгийн барилга	82 649.90
9	Ринчинлхүмбэ	Сум дундын эмнэлгийн оношлогоо эмчилгээний тоног төхөөрөмж, багийн эмчийн мотоцикл	8 348.00
10	Алаг-Эрдэнэ /Хатгал тосгон/	Сумын эмнэлгийн барилга	65 767.70
11	Алаг-Эрдэнэ /Хатгал тосгон/	Сум дундын эмнэлгийн оношлогоо эмчилгээний тоног төхөөрөмж, багийн эмчийн мотоцикл	8 348.00
12	Арбулаг	Сум дундын эмнэлгийн оношлогоо эмчилгээний тоног төхөөрөмж, багийн эмчийн мотоцикл	8 348.00
13	Тариалан	Сум дундын эмнэлгийн оношлогоо эмчилгээний тоног төхөөрөмж, багийн эмчийн мотоцикл	8 348.00
14	Цагаан-Уул	Сум дундын эмнэлгийн оношлогоо эмчилгээний тоног төхөөрөмж, багийн эмчийн мотоцикл	8 348.00
15	Цагаан-Үүр	Сум дундын эмнэлгийн оношлогоо эмчилгээний тоног төхөөрөмж, багийн эмчийн мотоцикл	8 348.00
16	Алаг-Эрдэнэ	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
17	Баянзүрх	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
18	Бүрэнтогтох	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
19	Галт	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
20	Жаргалант	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
21	Их-Уул	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
22	Тосонцэнгэл	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
23	Төмөрбулаг	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
24	Чандмань-Өндөр	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
25	Цагааннуур	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
26	Цэцэрлэг	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
27	Рашаант	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
28	Ханх	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
29	Эрдэнэбулган	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
30	Түнэл	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
	<b>ДҮН</b>		<b>2 067 638.00</b>

**21. Хэнтий аймаг**
**Үл хөдлөх ба хөдлөх үндсэн хөрөнгө**

№	Сумын нэр	Эд хөрөнгийн нэр	Нийт хөрөнгийн дүн /мян.төг/
1	Хэрлэн	Өрхийн эмнэлгийн барилга	23 000.00
2	Хэрлэн	Өрхийн эмнэлгийн болон аймгийн нэгдсэн эмнэлгийн оношлогоо эмчилгээний багаж төхөөрөмж, мотоцикл, компьютер, зурхний цахилгаан бичлэгийн аппарат, сургалтын тоног төхөөрөмж	73 483.80



3	Бэрх тосгон	Сум дундын эмнэлгийн оношлогоо эмчилгээний тоног төхөөрөмж	14 717.60
4	Дэлгэрхаан	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
5	Цэнхэрмандал	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
6	Баян-Овоо	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
<b>ДҮН</b>			<b>115 971.40</b>
<b>АЙМГИЙН НИЙТ ДҮН</b>			<b>5 868 342.40</b>

**22. Улаанбаатар хот**

Үл хөдлөх ба хөдлөх үндсэн хөрөнгө

№	Дүүргийн нэр	Эд хөрөнгийн нэр	Нийт хөрөнгийн дүн /мян.төг/
1	Баянзүрх	II хорооны өрхийн эмнэлгийн барилга	23 577.90
2	Баянзүрх	V хорооны өрхийн эмнэлгийн барилга	24 529.00
3	Баянзүрх	VIII хорооны өрхийн эмнэлгийн барилга	21 257.30
4	Баянзүрх	IX хорооны өрхийн эмнэлгийн барилга	22 759.00
5	Баянзүрх	X хорооны өрхийн эмнэлгийн барилга	24 579.00
6	Баянзүрх	XIII хорооны өрхийн эмнэлгийн барилга	23 347.30
7	Баянзүрх	XIV хорооны өрхийн эмнэлгийн барилга	22 879.00
8	Баянзүрх	XVII хорооны өрхийн эмнэлгийн барилга	22 879.00
9	Баянзүрх	XIX хорооны өрхийн эмнэлгийн барилга	22 759.00
10	Баянзүрх	XX хорооны өрхийн эмнэлгийн барилга	21 364.80
11	Баянзүрх	Өрхийн эмнэлгийн оношлогоо, эмчилгээний багаж төхөөрөмж / 22 иж бүрдэл/	50 530.70
12	Баянзүрх	Өрхийн эмнэлгийн мотоцикл /4ш/	6 360.00
13	Баянзүрх	Өрхийн эмнэлгийн компьютер / 22 иж бүрдэл/	30 415.00
14	Баянзүрх	Өрхийн эмнэлгийн зүрхний цахилгаан бичлэгийн аппарат /3 ш/	8 364.30
15	Баянзүрх	Дүүргийн нэгдсэн эмнэлэгт түргэн тусламжийн автомашин	17 027.20
16	Баянзүрх	Дүүргийн эрүүл мэндийн нэгдэлд сургалтын техник хэрэгсэл /1 иж бүрдэл/	1 372.00
17	Сүхбаатар	VI хорооны өрхийн эмнэлгийн барилга	20 000.00
18	Сүхбаатар	IX хорооны өрхийн эмнэлгийн барилга	19 800.00
19	Сүхбаатар	XVI хорооны өрхийн эмнэлгийн барилга	8 300.00
20	Сүхбаатар	Өрхийн эмнэлгийн оношлогоо, эмчилгээний багаж төхөөрөмж /18 иж бүрдэл/	41 343.30
21	Сүхбаатар	Өрхийн эмнэлгийн мотоцикл /2ш/	3 180.00
22	Сүхбаатар	Өрхийн эмнэлгийн компьютер / 17 иж бүрдэл/	23 502.50
23	Сүхбаатар	Өрхийн эмнэлгийн зүрхний цахилгаан бичлэгийн аппарат /3 ш/	8 364.30
24	Сүхбаатар	Дүүргийн нэгдсэн эмнэлэгт түргэн тусламжийн автомашин	17 027.20
25	Сүхбаатар	Дүүргийн эрүүл мэндийн нэгдэлд сургалтын техник хэрэгсэл /1 иж бүрдэл/	1 372.00

26	Сүхбаатар	Нийслэлийн түргэн тусламжийн төвд автомашин /бш/	102 163.20
27	Хан-Уул	IV хорооны өрхийн эмнэлгийн барилга	23 383.80
28	Хан-Уул	V хорооны өрхийн эмнэлгийн барилга	23 424.50
29	Хан-Уул	VI хорооны өрхийн эмнэлгийн барилга	21 943.40
30	Хан-Уул	VII хорооны өрхийн эмнэлгийн барилга	21 868.70
31	Хан-Уул	VIII хорооны өрхийн эмнэлгийн барилга	23 933.80
32	Хан-Уул	IX хорооны өрхийн эмнэлгийн барилга	22 996.50
33	Хан-Уул	X хорооны өрхийн эмнэлгийн барилга	24 546.90
34	Хан-Уул	XI хорооны өрхийн эмнэлгийн барилга	22 996.50
35	Хан-Уул	XII хорооны өрхийн эмнэлгийн барилга	22 899.00
36	Хан-Уул	Өрхийн эмнэлгийн оношлогоо, эмчилгээний багаж төхөөрөмж /12 иж бүрдэл/	27 562.20
37	Хан-Уул	Өрхийн эмнэлгийн мотоцикл /2ш/	3 180.00
38	Хан-Уул	Өрхийн эмнэлгийн компьютер /12 иж бүрдэл/	16 590.00
39	Хан-Уул	Өрхийн эмнэлгийн зүрхний цахилгаан бичлэгийн аппарат /2ш/	5 576.20
40	Хан-Уул	Дүүргийн нэгдсэн эмнэлэгт түргэн тусламжийн автомашин	17 027.00
41	Хан-Уул	Дүүргийн нэгдсэн эмнэлэгт оношлогоо, эмчилгээний тоног төхөөрөмж /1 иж бүрдэл/	30 249.60
42	Хан-Уул	Дүүргийн эрүүл мэндийн нэгдэлд сургалтын техник хэрэгсэл /1 иж бүрдэл/	1 372.00
43	Чингэлтэй	VIII хорооны өрхийн эмнэлгийн барилга	20 892.80
44	Чингэлтэй	IX хорооны өрхийн эмнэлгийн барилга	24 546.90
45	Чингэлтэй	X хорооны өрхийн эмнэлгийн барилга	20 892.80
46	Чингэлтэй	XII хорооны өрхийн эмнэлгийн барилга	22 825.60
47	Чингэлтэй	XIII хорооны өрхийн эмнэлгийн барилга	22 834.10
48	Чингэлтэй	XIV хорооны өрхийн эмнэлгийн барилга	21 895.50
49	Чингэлтэй	XVII хорооны өрхийн эмнэлгийн барилга	22 367.30
50	Чингэлтэй	Өрхийн эмнэлгийн оношлогоо, эмчилгээний багаж төхөөрөмж /17 иж бүрдэл/	39 046.50
51	Чингэлтэй	Өрхийн эмнэлгийн мотоцикл	1 590.00
52	Чингэлтэй	Өрхийн эмнэлгийн компьютер/17 иж бүрдэл/	23 502.0
53	Чингэлтэй	Өрхийн эмнэлгийн зүрхний цахилгаан бичлэгийн аппарат /3 ш/	8 364.30
54	Чингэлтэй	Дүүргийн нэгдсэн эмнэлэгт түргэн тусламжийн автомашин	17 027.20
55	Чингэлтэй	Дүүргийн эрүүл мэндийн нэгдэлд сургалтын техник хэрэгсэл /1 иж бүрдэл/	1 372.00
56	Чингэлтэй	Нийслэлийн эрүүл мэндийн газарт сургалтын тоног төхөөрөмж, тавилга, техник хэрэгсэл /1 иж бүрдэл/	12 317.90
57	Чингэлтэй	Нийслэлийн эрүүл мэндийн газарт микроавтобус	10 675.10

58	Баянгол	IV хорооны өрхийн эмнэлгийн барилга	23 378.30
59	Баянгол	IX хорооны өрхийн эмнэлгийн барилга	23 558.50
60	Баянгол	X хорооны өрхийн эмнэлгийн барилга	23 558.50
61	Баянгол	XI хорооны өрхийн эмнэлгийн барилга	23 378.30
62	Баянгол	XVII хорооны өрхийн эмнэлгийн барилга	22 068.10
63	Баянгол	Өрхийн эмнэлгийн оношлогоо, эмчилгээний багаж төхөөрөмж /21 иж бүрдэл/	48 233.90
64	Баянгол	Өрхийн эмнэлгийн мотоцикл	1 590.00
65	Баянгол	Өрхийн эмнэлгийн компьютер /21 иж бүрдэл/	29 032.50
66	Баянгол	Өрхийн эмнэлгийн зүрхний цахилгаан бичлэгийн аппарат 2ш	5 576.20
67	Баянгол	Дүүргийн нэгдсэн эмнэлэгт түргэн тусламжийн автомашин	17 027.20
68	Баянгол	Дүүргийн эрүүл мэндийн нэгдэлд сургалтын техник хэрэгсэл /1 иж бүрдэл/	1 372.00
69	Сонгинохайрхан	I хорооны өрхийн эмнэлгийн барилга	24 546.90
70	Сонгинохайрхан	II хорооны өрхийн эмнэлгийн барилга	19 519.80
71	Сонгинохайрхан	III хорооны өрхийн эмнэлгийн барилга	23 348.00
72	Сонгинохайрхан	IV хорооны өрхийн эмнэлгийн барилга	23 276.00
73	Сонгинохайрхан	V хорооны өрхийн эмнэлгийн барилга	24 546.90
74	Сонгинохайрхан	VI хорооны өрхийн эмнэлгийн барилга	20 990.30
75	Сонгинохайрхан	VI хорооны өрхийн эмнэлгийн барилга	20 990.30
76	Сонгинохайрхан	VII хорооны өрхийн эмнэлгийн барилга	20 433.60
77	Сонгинохайрхан	VIII хорооны өрхийн эмнэлгийн барилга	20 433.60
78	Сонгинохайрхан	IX хорооны өрхийн эмнэлгийн барилга	22 991.60
79	Сонгинохайрхан	IX хорооны өрхийн эмнэлгийн барилга	22 991.60
80	Сонгинохайрхан	X хорооны өрхийн эмнэлгийн барилга	18 906.60
81	Сонгинохайрхан	XI хорооны өрхийн эмнэлгийн барилга	17 957.40
82	Сонгинохайрхан	Өрхийн эмнэлгийн оношлогоо, эмчилгээний багаж төхөөрөмж /22 иж бүрдэл/	50 530.70
83	Сонгинохайрхан	Өрхийн эмнэлгийн мотоцикл	1 590.00
84	Сонгинохайрхан	Өрхийн эмнэлгийн компьютер /22 иж бүрдэл/	30 415.00
85	Сонгинохайрхан	Өрхийн эмнэлгийн зүрхний цахилгаан бичлэгийн аппарат /2ш/	5 576.20
86	Сонгинохайрхан	Дүүргийн нэгдсэн эмнэлэгт түргэн тусламжийн автомашин	17 027.20
87	Сонгинохайрхан	Дүүргийн нэгдсэн эмнэлэгт шүдний эмчилгээний машин	12 826.70
88	Сонгинохайрхан	Дүүргийн эрүүл мэндийн нэгдэлд сургалтын техник хэрэгсэл /1 иж бүрдэл/	1 372.00
89	Налайх	III хорооны өрхийн эмнэлгийн барилга	24 492.90
90	Налайх	IV хорооны өрхийн эмнэлгийн барилга	24 491.90
91	Налайх	Өрхийн эмнэлгийн оношлогоо, эмчилгээний багаж төхөөрөмж /4 иж бүрдэл/	9 187.40

92	Налайх	Өрхийн эмнэлгийн мотоцикл	1 590.00
93	Налайх	Өрхийн эмнэлгийн компьютер /4 иж бүрдэл/	5 530.00
94	Налайх	Өрхийн эмнэлгийн зүрхний цахилгаан бичлэгийн аппарат	2 788.10
95	Налайх	Дүүргийн эрүүл мэндийн нэгдэлд сургалтын техник хэрэгсэл /1 иж бүрдэл/	1 372.00
96	Багануур	Өрхийн эмнэлгийн оношлогоо, эмчилгээний багаж төхөөрөмж /4 иж бүрдэл/	9 187.40
97	Багануур	Өрхийн эмнэлгийн мотоцикл	1 590.00
98	Багануур	Өрхийн эмнэлгийн компьютер /4 иж бүрдэл/	5 530.00
99	Багануур	Өрхийн эмнэлгийн зүрхний цахилгаан бичлэгийн аппарат	2 788.10
100	Багануур	Дүүргийн эрүүл мэндийн нэгдэлд сургалтын техник хэрэгсэл /1 иж бүрдэл/	1 372.00
<b>Нийслэлийн дүн</b>			<b>1 877 717.50</b>
<b>НИЙТ ДҮН</b>			<b>7 746 059.90</b>

Монгол Улсын Их Хурлын 2004 оны  
18 дугаар тогтоолын 2-р хэвсрэлт

АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ШИЙДВЭРИЙГ ҮНДЭСЛЭН ОРОН НУТГИЙН ӨМЧӨӨС ТӨРИЙН  
ӨМЧИД ШИЛЖҮҮЛЭН АВАХ ЭД ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

**1. Архангай аймаг**

Үл хөдлөх ба хөдлөх үндсэн хөрөнгө

№	Сумын нэр	Эд хөрөнгийн нэр	Нийт хөрөнгийн дүн /мян.төг/
1	Өндөр-Улаан	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам /0.4кВ- 3,9 км/	9 750.00
2	Тариат	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам /0.4кВ- 5,3 км/	13 250.00
3	Жаргалант	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам /0.4кВ- 3,2 км/	8 000.00
4	Цэцэрлэг	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам /0.4кВ- 3,2 км/	8 000.00
<b>Дүн</b>			<b>39 000.00</b>

**2. Булган аймаг**

Үл хөдлөх ба хөдлөх үндсэн хөрөнгө

№	Сумын нэр	Эд хөрөнгийн нэр	Нийт хөрөнгийн дүн /мян.төг/
1	Тэшиг	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам /0.4кВ- 2,3 км/	5 750.00
2	Бугат	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам /0.4кВ- 1,5 км/	3 750.00
3	Сэлэнгэ	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам /0.4кВ- 8,5 км/	21 250.00
4	Сайхан /Сайхан-Овоо тосгон/	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам /0.4кВ- 6,7 км/	16 750.00
<b>Дүн</b>			<b>47 500.00</b>

**3. Дорноговь**

Үл хөдлөх ба хөдлөх үндсэн хөрөнгө

№	Сумын нэр *	Эд хөрөнгийн нэр	Нийт хөрөнгийн дүн /мян.төг/
1	Алтанширээ	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам /0.4кВ-4,1 км/	10 250.00
2	Айраг	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам /0.4кВ-3,5 км/, /10 кВ-1,5 км/ дэд станц-1	18 325.30
3	Замын-Үүд	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам /0.4 кВ-5,85 км/, дэд станц, тоног төхөөрөмж-1 ком	19 689.20
<b>Дүн</b>			<b>48 264.50</b>

**4. Дорнод аймаг**

Үл хөдлөх ба хөдлөх үндсэн хөрөнгө

№	Сумын нэр	Эд хөрөнгийн нэр	Нийт хөрөнгийн дүн /мян.төг/
1	Чойбалсан	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам /0.4 кВ- 6 км/, /10кВ-2,3 км/, 35/10 дэд станц, подстанц-4	27 764.80
2	Баянтүмэн	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам /0.4кВ- 1,9 км/, /10кВ-2,8 км/, дэд станц-1	25 105.60
3	Булган	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам /0.4кВ-5 км/, 10кВ-1.2 км/, дэд станц 35/10 -1	20 849.40
<b>Дүн</b>			<b>73 719.80</b>

**5. Дундговь аймаг**

Үл хөдлөх ба хөдлөх үндсэн хөрөнгө

№	Сумын нэр	Эд хөрөнгийн нэр	Нийт хөрөнгийн дүн /мян.төг/
1	Говь-Угтаал	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам /0.4кВ-10 км/	25 000.00
2	Гурвансайхан	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам /0.4кВ-16,2 км/	40 500.00
3	Хулд	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам /0.4кВ-6,8 км/	17 000.00
4	Луус	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам /0.4кВ-8 км/	20 000.00
5	Цагаандэлгэр	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам /0.4кВ-8,5 км/	21 250.00
6	Дэрэн	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам /0.4кВ-8 км/	20 000.00
7	Дэлгэрцогт	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам /0.4кВ-10,3 км/	25 750.00
8	Сайхан-Овоо	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам /0.4кВ-7 км/	17 500.00
9	Сайнцагаан /Тэвшийн говь тосгон/	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам /0.4кВ-3 км/	7 500.00



10	Дэлгэрхангай	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах сугам /0.4кВ-8,5 км/	21 250.00
11	Эрдэнэдалай	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах сугам /0.4кВ-10,8 км/	27 000.00
	<b>Дүн</b>		<b>242 750.00</b>

### 6. Өвөрхангай аймаг

Үл хөдлөх ба хөдлөх үндсэн хөрөнгө

№	Сумын нэр	Эд хөрөнгийн нэр	Нийт хөрөнгийн дүн /мян.төг/
1	Сант	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах сугам /0.4кВ-1,6 км/	4 000.00
	<b>Дүн</b>		<b>4 000.00</b>

### 7. Өмнөговь аймаг

Үл хөдлөх ба хөдлөх үндсэн хөрөнгө

№	Сумын нэр	Эд хөрөнгийн нэр	Нийт хөрөнгийн дүн /мян.төг/
1	Баяндалай	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах сугам /0.4кВ-3,7 км/ /110 ш мод/	9 250.00
2	Хүрмэн	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах сугам /0.4кВ- 9 км/ /138 ш мод/	22 500.00
3	Булган	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах сугам /0.4кВ- 2,8 км/	7 000.00
4	Ханхонгор	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах сугам /0.4кВ-20,9 км/ /113 ш мод/	52 250.00
	<b>Дүн</b>		<b>91 000.00</b>

### 8. Сүхбаатар аймаг

Үл хөдлөх ба хөдлөх үндсэн хөрөнгө

№	Сумын нэр	Эд хөрөнгийн нэр	Нийт хөрөнгийн дүн /мян.төг/
1	Баруун-Урт	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах сугам, дэд өртөө	119 000.00
2	Халзан	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах сугам, дэд өртөө	10 500.00
3	Асгат	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах сугам, дэд өртөө	6 250.00
4	Сүхбаатар	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах сугам, дэд өртөө	8 000.00
5	Түмэнцогт	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах сугам, дэд өртөө	14 500.00
6	Уулбаян	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах сугам, дэд өртөө	11 250.00
	<b>Дүн</b>		<b>169 500.00</b>

**9. Сэлэнгэ аймаг**

Үл хөдлөх ба хөдлөх үндсэн хөрөнгө

№	Сумын нэр	Эд хөрөнгийн нэр	Нийт хөрөнгийн дүн /мян.төг/
1	Баруунбүрэн	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам /0.4кВ- 2.9 км/	7 250.00
	<b>Дүн</b>		<b>7 250.00</b>

**10. Төв аймаг**

Үл хөдлөх ба хөдлөх үндсэн хөрөнгө

№	Сум, дүүргийн нэр	Эд хөрөнгийн нэр	Нийт хөрөнгийн дүн /мян.төг/
1	Дэлгэрхаан	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам /0.4кВ-3,6 км/	9000.00
2	Бүрэн	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам /0.4кВ-7 км/	17 500.00
	<b>Дүн</b>		<b>26 500.00</b>

**11. Увс аймаг**

Үл хөдлөх ба хөдлөх үндсэн хөрөнгө

№	Сумын нэр	Эд хөрөнгийн нэр	Нийт хөрөнгийн дүн /мян.төг/
1	Наранбулаг	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам /0.4кВ-2 км/, /10квт-63 км/, тоног төхөөрөмж	377000.00
2	Өмнөговь	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам /0.4кВ-61,5 км/, /10 квт-5 км/, тоног төхөөрөмж	43722.8
3	Өлгий	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам /0.4кВ-18 км/, /10квт-3 км/, тоног төхөөрөмж	20500.0
4	Түргэн	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам /0.4кВ-3 км/, /10 квт-22,6 км, тоног төхөөрөмж	95500.0
5	Сагил	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам /0.4кВ-12 км/	3000.0
6	Давст	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам/0.4кВ-15,5 км/, /10 квт-5,2 км/, тоног төхөөрөмж	128000.0
7	Тариалан	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам /0.4кВ-2 км/, /10 квт-5,2 км/, тоног төхөөрөмж	4500.0
	<b>Дүн</b>		<b>672 222.80</b>

**12. Хөвсгөл аймаг**

Үл хөдлөх ба хөдлөх үндсэн хөрөнгө

№	Сумын нэр	Эд хөрөнгийн нэр	Нийт хөрөнгийн дүн /мян.төг/
1	Рашаант	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам /0.4кВ-4,2км/	10 500.00
2	Тариалан	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам /0.4кВ- 2,4 км/	11 430.00
3	Их-Уул	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам /0.4кВ- 1,6 км/	4 000.00
	<b>Дүн</b>		<b>25 930.00</b>
	<b>НИЙТ ДҮН</b>		<b>1 447 637.10</b>



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 3 дугаар сарын 31-ний өдөр

Дугаар 73

Улаанбаатар хот

**Төсвийн төлөвлөлтийн үе шатыг тогтоох тухай**

Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь.

эдийн засгийн сайд Ч.Улаан, төсвийн жил бүрийн болон дунд хугацааны төсөл, үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөөгөө тогтоосон хугацаанд нь иж бүрэн, чанартай боловсруулан эрх бүхий холбогдох байгууллагуудад хүргүүлж байхыг төсвийн ерөнхийлэн захирагчид, төсвийн байгууллагын ерөнхий менежерүүдэд тус тус үүрэг болгосугай.

1. Монгол Улсын төсвийн төлөвлөлт, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, хэлэлцэх, батлагдсан төсвийг төсвийн ерөнхийлэн захирагч нарт хуваарилан хүргүүлэхтэй холбогдсон төсвийн төлөвлөлтийн үе шат, түүнийг хэрэгжүүлэх хугацааны хуваарийг хавсралт ёсоор баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**Н.ЭНХБАЯР**

2. Энэхүү тогтоолд заасан төсвийн төлөвлөлтийн үе шатыг төсвийн байгууллагуудын үйл ажиллагаанд мөрдүүлж ажиллахыг Санхүү,

**САНХҮҮ, ЭДИЙН  
ЗАСГИЙН САЙД**

**Ч.УЛААН**

— Засгийн газрын 2004 оны  
73 дугаар тогтоолын хавсралт

### ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТИЙН ҮЕ ШАТУУД, ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА

д/д	Үйл ажиллагааны үе шатууд	Хэрэгжүүлэх хугацаа
1	Дунд хугацаанд баримтлах төсөв, санхүүгийн үндсэн үзүүлэлтийн хязгаарыг төсвийн ерөнхийлэн захирагч нарт хүргүүлэх	Ш сарын 1-ний дотор
2	Төсвийн ерөнхийлэн захирагчдаас ирэх 3 жилд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө болон түүнтэй уялдсан төсвийн төсөл, саналаа Санхүү, эдийн засгийн яаманд ирүүлэх	Ш сарын 20-ны дотор
3	Санхүү, эдийн засгийн яамнаас төсвийн ерөнхийлэн захирагч тус бүртэй үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөө, төсвийн талаар санал солилцох	IY сарын 10-ны дотор
4	Дунд хугацааны төсвийн хүрээний баримт бичгийн төсөл, холбогдох тооцоог эцэслэн боловсруулж Засгийн газарт хүргүүлэх	IY сарын 20-ны дотор
5	Дунд хугацааны төсвийн хүрээний баримт бичгийн төсөл, дунд хугацаанд баримтлах эдийн засаг, санхүүгийн үндсэн зорилтын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэр гаргуулах	IY сарын 30-ны дотор
6	Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төсөл, Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх	Y сарын 1-ний дотор
7	Улсын Их Хурлаас хэлэлцэн зөвшөөрсөн Төсвийн хүрээний мэдэгдэлд тусгагдсан үзүүлэлтийг холбогдох төсвийн ерөнхийлэн захирагчдад хүргүүлэх	YI сарын 10-ны дотор
8	Төсвийн байгууллагын менежерүүд дараа жилийн төсөв, үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөөний саналаа төсвийн ерөнхийлэн захирагчдад хүргүүлэх	YI сарын 1-ний дотор
9	Төсвийн ерөнхийлэн захирагчид дараагийн жилд зарцуулах төсвийн төсөл, үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөөний саналыг Санхүү, эдийн засгийн яаманд хүргүүлэх	YII сарын 15-ны дотор

10	Төсвийн ерөнхийлэн захирагчдаас ирүүлсэн төсвийн саналыг Санхүү, эдийн засгийн яамны холбогдох газар, хэлтээс судлан үзэж төсвийн ерөнхийлэн захирагчтай зөвшилцөх	IX сарын 1-ний дотор
11	Төсвийн төсөл, дунд хугацаанд баримтлах эдийн засаг, санхүүгийн үндсэн зорилтын төслийг эцэслэн боловсруулж Засгийн газарт хүргүүлэх	IX сарын 15-ны дотор
12	Ирэх оны төсвийн төсөл, дунд хугацаанд баримтлах эдийн засаг, санхүүгийн үндсэн зорилтын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх	IX сарын 30-ны дотор
13	Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн болон улсын төсвийн төсөл, төсвийн ерөнхийлэн захирагч бүрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн төслийг Улсын И. Хуралд өргөн мэдүүлэх	X сарын 1-ний дотор
14	Улсын Их Хурлаас батлагдсан төсвийг төсвийн ерөнхийлэн захирагч нарт дэлгэрэнгүй үзүүлэлтээр хүргүүлэх	XП сарын 10-ны дотор
15	Төсвийн ерөнхийлэн захирагчдаас аймаг, нийслэлийн Засаг дарга нар болон Ерөнхий менежерүүдтэй бүтээгдэхүүн нийлүүлэлтийн болон үр дүнгийн гэрээ байгуулах	XП сарын 25-ны дотор
16	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас батлагдсан аймаг, нийслэлийн төсвийг дэлгэрэнгүй үзүүлэлтээр Санхүү, эдийн засгийн яаманд хүргүүлэх	I сарын 15-ны дотор
17	Төсвийн ерөнхийлэн захирагчид тухайн жилийн төсвийн багцынхаа сар, улирлын санхүүжилтийн хуваарийг баталж Санхүү, эдийн засгийн яаманд хүргүүлэх	I сарын 5-ны дотор
18	Санхүү, эдийн засгийн сайдын тушаалаар батлагдсан тухайн жилийн төсвийн сар, улирлын санхүүжилтийн хуваарийг төсвийн ерөнхийлэн захирагч нарт хүргүүлэх	I сарын 20-ны дотор

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр

Дугаар 74

Улаанбаатар хот

Дүрэм батлах тухай

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрэм"-ийг хавсралт ёсоор баталсугай.

2. "Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрэм"-ийг 2004 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр тогтоосугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Дүрэм батлах тухай" Засгийн газрын 1996 оны 9 дүгээр сарын 21-ний өдрийн 239 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**
**Н.ЭНХБАЯР**
**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД  
ХЭРГИЙН САЙД**
**Ц.НЯМДОРЖ**

Засгийн газрын 2004 оны  
74 дүгээр тогтоолын хавсралт

## МОНГОЛ УЛСЫН ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ ДҮРЭМ

### 1. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ дүрмийн зорилго нь Монгол Улсын нутаг дэвсгэрт замын хөдөлгөөний нэгдсэн журам тогтооход оршино. Замын хөдөлгөөнтэй холбоотой бусад хэм хэмжээний актууд нь энэ дүрмийн заалт шаардлагууд дээр үндэслэгдсэн, түүнтэй зөрчилдөхгүй байвал зохино.

1.2. Механикжсан тээврийн хэрэгслийг дор дурдсанаар ангилна:

A - мотоцикл;

B - жолоочоос гадна B-аас илүүгүй хүний суудалтай, бүх жин нь 3500 кг-аас хэтрэхгүй автомашин (бүх жин нь 750 кг-аас ихгүй чиргүүлтэй);

C - бүх жин нь 3500 кг-аас их ачааны автомашин (5000 кг-аас ихгүй даацтай чиргүүлтэй);

D - жолоочоос гадна 8-аас илүү хүний суудалтай, хүн тээвэрлэхэд зориулсан автомашин (бүх жин нь 750 кг-аас ихгүй чиргүүлтэй);

E - "B", "D" ангиллын автомашин 750 кг-аас дээш бүх жинтэй чиргүүлтэй, "C" ангиллын автомашин 5000 кг-аас их даацтай чиргүүлтэй бүрэлдэхүүн;

Механизм - трактор, өөрөө явдаг машин механизм, тэдгээрийн чиргүүл буюу ажлын тоног төхөөрөмжтэй бүрэлдэхүүн.

1.3 "D" ангиллын тээврийн хэрэгслийг 21-ээс, бусад ангиллын тээврийн хэрэгслийг 18-аас дээш насны хүн жолоодно.

1.4 Энэ дүрэмд байгаа дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

"Аюултай ачаа" - тээвэрлэлтийн үед хүний амь бие, эрүүл мэнд, байгаль орчинд хор хөнөөл тарих, эд материалын хохирол учруулж болзошгүй элдэв бодис, түүгээр хийсэн эд зүйл, үйлдвэрийн хаягдал, аж ахуйн зориулалт бүхий бусад зүйл;

"Бодит жин" - тээврийн хэрэгслийн тухайн үеийн жин. Чирэгдэж яваа тээврийн хэрэгслийн жинг бодит жинд оролцуулан тооцно;

"Бүх жин" - тээврийн хэрэгслийн техникийн тодорхойлолтоор тогтоосон өөрийн болон ачаа, жолооч, зорчигчийн нийт эвшөөрөгдөх дээд жин. Чиргүүл нь тухайн тээврийн хэрэгслийн бүтцэд хамаарагдах бол бүх жинг чирэгч, чиргүүл хоёрын бүх жингийн нийлбэрээр тооцно;

"Гарц" - ойролцоох зогсоол, шатахуун түгээгүүр, үйлдвэр, албан байгууллага, хашаа, хороолол зэрэг рүү орох, тэдгээрээс гарахад зориулагдсан зорчих хэсэг замтай огтлолцсон бэлчир;

"Гол зам" - уулзварт нийлсэн хучилттай болон шороон замын хучилттай нь буюу энэ дүрмийн 1 дүгээр хавсралтын 3.1, 3.3.а,б,в, 5.1 тэмдэг (цаашид зөвхөн тэмдэг, тэмдэглэлийн дугаарыг зааж бичнэ) бүхий зам;

"Гүйцэж түрүүлэх" - явж байгаа эгнээнээсээ гарч урдаа яваа нэг буюу хэд хэдэн тээврийн хэрэгслийг гүйцэж үйлдэл;

"Давуу эрх" - бусад замын хөдөлгөөнд оролцогчоос хөдөлгөөнөө урьтан хийх эрх;

"Ердийн хөсөг" - уналга, ачлагдаж ашиглаж байгаа мал, амьтан буюу түүнд хөллөсөн хэрэгсэл (хөсөг);

"Жолооч" - тээврийн хэрэгслийг жолоодож яваа хүн. Жолоодлогын дадлага хийлгэж яваа багш, замаар ердийн хөсөг унаж, хөтөлж яваа хүнийг жолоочид хамааруулж ойлгоно;

"Зайлшгүй зогсолт" - жолооч, зорчигчийн биеийн байдал, тээж яваа ачаа, байгалийн үзэгдэл, зам дээр саад бий болсон зэргээс аюул учирч

болзошгүй үед, түүнчлэн техникийн эвдрэлээс шалтгаалан тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг зогсоох үйлдэл;

"Зам" - тээврийн хэрэгслээр зорчиход зориулсан зурвас газар. Зорчих хэсэг болон түүний хажуугийн хөвөө, таримал зүлэг, явган хүний зам, тусгаарлах зурвас зэмд хамаарна;

"Зам тавьж огох" - замын хөдөлгөөнд оролцогч нь давуу эрх бүхий хөдөлгөөнд оролцогчийн хөдөлгөөний хурд болон чигийг өөрчлөхөд нөлөөлөхгүйн тулд хөдөлгөөнөө эхлэхгүй буюу үргэлжлүүлэхгүй байх үйлдэл;

"Зам тээврийн осол" - зам дээр тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс үүдэн хүний амь бие, эрүүл мэнд хохирох, тээврийн хэрэгсэл болон замын байгууламж эвдэрч гэмтэх, ачаа болон бусад эд материалын хохирол учрах явдал;

"Замын хөдөлгөөн" - нийтийн хэрэгцээний зам дээрх явганаар болон тээврийн хэрэгслээр хүн ба ачаа шилжих үйл ажиллагаа;

"Замын хөдөлгөөнд оролцогч" - замаар яваа жолооч, явган зорчигч болон тээврийн хэрэгслээр зорчих;

"Зорчих хэсэг" - тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд зориулсан замын хэсэг. Зам нь тусгаарлах зурвасаар зааглагдсан хэд хэдэн зорчих хэсэгтэй байж болно;

"Зохицуулагч" - замын хөдөлгөөнийг зохицуулах, хяналт тавих эрх, үүрэг бүхий этгээд;

"Механикжсан тээврийн хэрэгсэл" - мопедоос бусад хөдөлгүүрээр тоноглогдсон бүх төрлийн тээврийн хэрэгсэл;

"Мопед" - 50 см<sup>3</sup>-ээс илүүгүй ажлын багтаамжтай хөдөлгүүр бүхий хоёр буюу гурван дугуйтай, техникийн хурд нь цагт 50 км-ээс ихгүй тээврийн хэрэгсэл;

"Мотоцикль" - шаахайтай буюу шаахайгүй хоёр дугуйтай механикжсан тээврийн хэрэгсэл. Энд өөрийн жин нь 400 кг-аас хэтрэхгүй гурав буюу дөрвөн дугуйтай механикжсан тээврийн хэрэгсэл мөн хамаарна;

"Суурин газар" - 5.3, 5.5 тэмдгээр тэмдэглэгдсэн, хүн ам төвлөрч суурьшсан нутаг дэвсгэр;

"Төмөр замын гарам" - төмөр замтай нэг түвшинд огтлолцсон замын бэлчир;

"Тусгаарлах зурвас" - зэргэлдээ зорчих хэсгүүдийг зааглахад зориулагдаж хийгдсэн, зогсоол болон хөдөлгөөнд зориулагдаагүй замын хэсэг;

"Тууш зам" - 5.1 тэмдгээр тэмдэглэгдсэн зам;

"Тээврийн хэрэгсэл" - хүн ба ачаа, суурилагдсан тоног төхөөрөмжийг замаар тээвэрлэхэд зориулсан хэрэгсэл;

"Тээврийн хэрэгслээр зорчигч" - тээврийн хэрэгсэл дээр буюу түүний бүхээг дотор байгаа жолоочоос бусад хүн;



**"Түр зогсолт"** –тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг 5 минутаас илүүгүй хугацаагаар зогсоох үйлдэл. Зорчигчдыг буулгах, суулгах буюу ачаа ачих, буулгахад үүнээс илүү хугацаагаар зогсоох үйлдэл нь түр зогсолтод хамаарна;

**"Удаан зогсолт"** -зорчигчдыг буулгах, суулгах буюу ачаа ачих, буулгахад бусад тохиолдолд 5 минутаас дээш хугацаагаар тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг зогсоох үйлдэл;

**"Унадаг дугуй"** -унаж яваа хүний булчингийн хүчээр явдаг (тахир дутуу хүний тэргэнцрээс бусад) тээврийн хэрэгсэл;

**"Уулзвар"** -замууд нэг түвшинд огтлолцсон бэлчир (зорчих хэсгийн захын дугуйрч байгаа эхлэлийг түүний эсрэг тал руу шулуун холбож хязгаарлахад үүсэх талбай);

**"Үзэгдэлт хангалтгүй үе"** -байгалийн үзэгдэл (мөхөн, шуурга гэх мэт) болон замд тоос боссоноос буюу бүрэнхий үед 300 метрийн дотор зам харагдахгүй болсон үед;

**"Харанхуй үе"** -үдшийн бүрийгээс үүрийн гэгээ орох хүртэлх хугацаа;

**"Хүүхдийг зохион байгуулалттайгаар тээвэрлэх"** -сургуулийн болон сургуулийн өмнөх насны хоёр буюу түүнээс олон хүүхдийг механикжсан тээврийн хэрэгслээр тусгайлан тээвэрлэх үйл ажиллагаа. Үүнд чиглэлийн тээврийн хэрэгслээр хүүхэд тээвэрлэхийг хамааруулахгүй;

**"Цуваа"** -ойрын гэрлээг асааж зохион байгуулалттай цуварч яваа гурав буюу түүнээс олон механикжсан тээврийн хэрэгсэл. Цувааг тусгай дуут болон гэрлэн дохиогоор тоноглогсон тээврийн хэрэгсэл хамгаалан явж болно;

**"Чиглэлийн тээврийн хэрэгсэл"** -тогтоосон буудал бүхий чиглэлийн дагуу хүн тээвэрлэх зориулалтаар нийтийн үйлчилгээнд ашиглагдаж байгаа тээврийн хэрэгсэл (автобус, троллейбус, чиглэлийн такси);

**"Чиргүүл"** -механикжсан тээврийн хэрэгслээр чирэхэд зориулсан тээврийн хэрэгсэл;

**"Эгнээ"** -автомашинь хөдөлгөөнийг нэг эгнээгээр явуулах боломж бүхий өргөнтэй, тэмдэглэлтэй буюу тэмдэглэлгүй зорчих хэсгийн дагуух зурвас;

**"Явган зорчигч"** -замаар явган яваа (зам дээр ажил, үүрэг гүйцэтгэж байгаагаас бусад) хүн. Жагсаалаар яваа болон тахир дутуу хүний тэргэнцэртэй, мөн тэрэг түрж, чарга чирч, мотоцикл, мопед, унадаг дугуйг хөтөлж замаар яваа хүмүүсийг явган зорчигчид хамааруулна;

**"Явган хүний гарц"** -явган зорчигч зам хөндлөн гарахад зориулсан, 5.16.а,б тэмдэг буюу 7.13.а,б тэмдэглэлтэй, зорчих хэсгийн хөндлөн зурвас. Тэмдэглэлгүй гарцын өргөнийг 5.16.а ба 5.16.б тэмдгүүдийн хоорондох зайгаар тодорхойлно;

**"Явган хүний гарам"** -зорчих хэсэгтэй нэг түвшинд огтлолцоогүй, 5.17.а,б,в,г тэмдэг

тавигдсан, явган зорчигч зам хөндлөн гарахад зориулсан гарц;

**"Явган хүний зам"** -зорчих хэсэгтэй хиллэсэн буюу түүнээс таримал зүлэг, хөвөөгөөр зааглагдсан явган зорчигчийн хөдөлгөөнд зориулсан замын хэсэг.

**1.5.** Замын хөдөлгөөнд оролцогч нь бусдад аюул, хохирол учруулахгүй, хөдөлгөөнд саад, бэрхшээл, осолтой байдал бий болгохгүйгээр зорчино

**1.6.** Замын тэмдэг, хөдөлгөөн зохицуулах зориулалт бүхий техник хэрэгслийг эвдэж гэмтээх, халхлах, байрлалыг дур мэдэн өөрчлөх, байрлуулах, авч хаях, хөдөлгөөнд саад болох зүйл зам дээр тавих, орчих, замын хучилтыг бохирдуулах, эвдэхийг хориглоно.

**1.7.** Замын хөдөлгөөнд оролцогч нь энэ дүрмийн өөрт хамаарах заалт, шаардлагыг мэддэг, сахин биелүүлдэг байвал зохино.

**1.8.** Замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

## 2. Жолоочийн үүрэг

**2.1.** Механикжсан тээврийн хэрэгслийн жолооч дараахь бичиг баримтыг биедээ авч явна:

- а/ тухайн тээврийн хэрэгслийн ангилалд тохирох Монгол Улсын үндэсний буюу олон улсын жолоодох эрхийн үнэмлэх;
- б/ тээврийн хэрэгслийн гэрчилгээ;
- в/ шаардлагатай тохиолдолд ачааны баримт бичиг.

**2.2.** Монгол Улсын нутаг дэвсгэр дээр олон улсын хөдөлгөөнд оролцож байгаа механикжсан тээврийн хэрэгслийн жолооч дор дурдсан үүрэг хүлээнэ:

а/ замын хөдөлгөөний тухай олон улсын Конвенцид нийцэх жолоодох эрхийн үнэмлэх, тээврийн хэрэгслийн гэрчилгээтэй байх;

б/ тээврийн хэрэгсэл нь бүртгэгдсэн улсынхаа ялгах тэмдэг, дугаартай байхаас гадна Монгол Улсын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын улсын хяналтын алба (цаашид "Замын цагдаагийн алба" гэх)-нд тэмдэглүүлсэн байх.

**2.3.** Жолооч дор дурдсан үүрэг хүлээнэ:

а/хөдөлгөөнд оролцохын өмнө буюу замд явахдаа энэ дүрмийн 2 дугаар хэвсрэлтэд заасан зөрчилгүй байхаар тээврийн хэрэгслийнхээ бүрэн бүтэн байдлыг хангах;

Тээврийн хэрэгслийн ажлын тоормосны систем, жолооны механизм ажиллахгүй болсон, чиргүүлийн холбоос эвдэрсэн, харанхуй буюу үзэгдэлт хангалтгүй үед зөв талын хол, ойрын болон ар талын оврын гэрлүүд асахгүй болсон, цас, бороо орж

байгаа үед жолоочийн талын шил эрчуур ажиллахгүй бол хөдөлгөөнөө үргэлжлүүлэхийг хориглоно.

Хөдөлгөөнд оролцож явах үед тээврийн хэрэгсэлд дээр дурдсанаас бусад гэмтэл (энэ дүрмийн 2 дугаар хавсралтад заасан) тохиолдол түүнийг засах, хэрэв бололцоогүй бол аюулгүй байдлыг хангаж аль ойр байгаа зогсоол (гарааш) буюу засварын газарт очно; б/хамгаалах бүсээр тоноглогдсон автомашин жолоодохдоо хамгаалах бүс хэрэглэх, хамгаалах бүс хэрэглээгүй зорчигч тээвэрлэхгүй байх;

*Тайлбар:* Энэ заалт нь жолоодлогын дадлага хийгээж яваа багш, үүрэг гүйцэтгэж явах шуурхай албаны автомашины жолооч, зорчигчид хамаарахгүй.

в/мотоцикл жолоодохдоо хамгаалах малгай өмсөх, хамгаалах малгай өмсөөгүй зорчигч тээвэрлэхгүй байх;

г/согтууруулах ундаа, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл хэрэгслэсэн эсэхийг цагдаагийн ажилтны шаардлагаар зохин журмын дагуу шалгуулах;

д/зам тээврийн осолд нэрвэгдсэн хүнд эмнэлгийн анхны тусламж үзүүлэх, түүнийг эмнэлэгт яаралтай хүргэх;

е/зам тээврийн осол буюу техникийн саатлаар замд зогссон жолоочийн дохиогоор зогсож, бололцоотой тусламж үзүүлэх;

ж/замын хөдөлгөөнд аюул учруулж болзошгүй элдэв саад гарсан тохиолдолд түүнийг арилгах, хэрэв бололцоогүй буюу зам тээврийн осол гарсан бол энэ тухай хөдөлгөөнд оролцогчдоо урьдчилан анхааруулж аль ойр байгаа цагдаагийн байгууллагад яаралтай мэдэгдэх;

з/гэмт хэрэг, үйлдвэрлэлийн осол, гал түймэр гарсан, байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул тохиолдсон, нийтийн эмх замбараагүй байдал үүссэн газарт хүрэлцэн очих, гэмт этгээдийг мөрдөн хөөх, амь нас, эрүүл мэндэд нь ноцтой хохирол учирч болох гэмтэлтэй хүмүүсийг эмнэлэгт, гэмт этгээдийг цагдаагийн байгууллагад хүргэхэд тээврийн хэрэгслээрээ үйлчлэх;

*Тайлбар:* Дээр дурдсан ажилд тээврийн хэрэгсэл хэрэглэсэн албан тушаалтан явсан зай, хугацаа, өөрийн овог нэр, албан тушаал, үнэмлэхийн дугаараа тэмдэглэж албан ёсны баримт бичиж өгнө. Үүнийг үндэслэн гарсан шууд зардлыг цагдаагийн байгууллага төлнө.

и/цагдаагийн алба хаагч, замын цагдаагийн туслах ажилтан, авто тээврийн буюу байгаль орчны хяналтын улсын байцаагчийн

дохиогоор зогсож энэ дүрмийн 2.1-д заасан баримт бичгийг шалгуулах;

*Тайлбар:* Жолооч дээрх тохиолдолд шалгагчийн албаны үнэмлэхийг үзэж танилцах эрхтэй.

к/тусгай дуут болон гэрэл дохио ажиллуулсан (шар өнгийн дохио ажиллуулж яваагаас бусад) автомашин, мотоцикл буюу тэдгээрээр хамгаалуулж яваа тээврийн хэрэгсэл ойртон ирж яваа үед тухайн зорчигч хэсэг (уулзвар, гарц) дээр зай тавьж өгөн зогсож өнгөрүүлэх.

**2.4.** Улаан, хөх, ногоон өнгийн тусгай дуут болон гэрэл дохио ажиллуулан хойшлуулшгүй албан үүрэг гүйцэтгэж яваа жолооч хөдөлгөөний аюулгүй байдлыг бүрэн хангасан нөхцөлд бусад оролцогчоос дараа эрхтэй байх бөгөөд энэ дүрмийн 5 дугаар бүлэг (зохицуулагчийн дохионоос бусад), 6 дугаар бүлгийн 1 дүгээр зүйл, 7-14, 16, 17 дугаар бүлэг болон 1 дүгээр хавсралтын заалтыг мөрдөхгүй байж болно. Энэхүү эрх нь дээрх тээврийн хэрэгслээр хамгаалуулж яваа тээврийн хэрэгслийн жолоочид мөн адил хамаарна.

Харин шар өнгийн тусгай гэрэл дохио ажиллуулан зам, байгууламжийн засвар үйлчилгээний ажил гүйцэтгэж яваа жолооч хөдөлгөөний аюулгүй байдлыг бүрэн хангасан нөхцөлд энэ дүрмийн 8.5-8.9, 17.1 болон 1 дүгээр хавсралтын тэмдэг (2.11-2.14, 2.20, 3.2, 3.4-3.6 тэмдгүүдээс бусад), тэмдэглэлийн заалтыг мөрдөхгүй байж болно. Шар өнгийн тусгай гэрэл дохио нь давуу эрх олгохгүй.

*Тайлбар:* Тусгай дуут болон гэрэл дохиогоор тоногдсон автомашины жолооч нь тухайн ангиллын тээврийн хэрэгслийг гурваас дээш жил жолоодож дадлагажсан хүн байвал зохино.

**2.5.** Зам тээврийн осолд холбогдсон жолооч дор дурдсан үүрэг хүлээнэ:

а/тээврийн хэрэгслээ нэн даруй зогсоож, ослын дохионы гэрлээ асаах ба ослын зогсолтын тэмдгийг энэ дүрмийн 6.3-т заасан шаардлагын дагуу тавьж, тээврийн хэрэгсэл болон осолд холбогдол бүхий эд юмсыг байрнаас нь хөдөлгөхгүй байх;

б/зам тээврийн осолд нэрвэгдсэн хүнд эмнэлгийн анхны тусламж үзүүлж, түргэн тусламж дуудах, хэрэв бололцоогүй бол уг хүнийг ойр байгаа эмнэлгийн байгууллагад аль тааралдсан тээврийн хэрэгслээр хүргүүлэх буюу зайлшгүй тохиолдолд өөрийн жолоодож яваа тээврийн хэрэгслээр хүргэж, эмнэлгийн ажилтанд өөрийн овог нэр, тээврийн хэрэгслийн марк, улсын дугаар, гэрчилгээг үзүүлж тэмдэглүүлээд уг газартаа буцаж ирэх;

в/зам тээврийн ослын тухай цагдаагийн байгууллага (ажилтан)-д мэдэгдэж, түүнийг

үзсэн хүмүүсийн овог нэр, хаягийг мэдэж аваад осолд холбогдол бүхий эд мөрийн баримтын зүйлийг хамгаалан цагдаагийн байгууллагын ажилтанг иртэл хүлээж;

г/осолд холбогдсон тээврийн хэрэгсэл нь бусад тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хаасны улмаас зорчих хэсгийг чөлөөлөх мөн осолд нэрвэгдсэн хүнийг эмнэлгийн байгууллагад уг тээврийн хэрэгслээр хүргэх зайлшгүй тохиолдолд хөндлөнгийн хоёроос доошгүй гэрчийг байлцуулан осолд холбогдол бүхий эд мөрийн баримт, тухайн тээврийн хэрэгслийн ул мөрийн байрлалыг тодорхой тэмдэглэсний дараа байрнаас нь хөдөлгөж болно;

д/шаардлагагүй тохиолдолд тээврийн хэрэгсэл жолоодох ур чадвар, замын хөдөлгөөний дүрмийн мэдлэгээ цагдаагийн албаны эрх бүхий албан тушаалтны шаардлагаар шалгуулах.

**2.6.** Хэрэв зам тээврийн ослын улмаас хүний амь бие, эрүүл мэнд хохироогүй бол осолд холбогдсон жолооч нар өөр хоорондоо зөвшилцөн, ослын бүдүүвч зургийг үйлдэж гарын цсэг зураад, аль ойр байгаа Замын цагдаагийн алба (цагдаагийн байгууллага)-д бүртгүүлж болно.

**2.7.** Жолоочид дор дурдсан зүйлийг хориглоно: а/согууруулах ундаа, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл хэрэглэсэн, мөн хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж чадахааргүй өвчтэй буюу ядарсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодох;

б/тухайн тээврийн хэрэгслийн ангилалд тохирох жолоодох эрхийн үнэмлэхгүй (жолоодлогын дадлага хийхээс бусад тохиолдолд) буюу түүнчлэн согууруулах ундаа, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл хэрэглэсэн, мөн хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж чадахааргүй өвчтэй буюу ядарсан хүнд жолоогоо шилжүүлэх;

в/зам тээврийн ослын дараа шинжилгээ авах, эсвэл шаардлагагүй гэж эрх бүхий этгээд шийдвэр гаргах хүртэл согууруулах ундаа, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл хэрэглэх;

г/гарны оролцоогүйгээр ашиглах боломжгүй телефон утсыг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний үед хэрэглэх;

д/тээврийн хэрэгсэлд тусгай дуут болон гэрлэн дохио дур мэдэн тавих;

е/тээврийн хэрэгслээр зорчих хэсгийн хашлага давах, явган хүний зам буюу хөвөөгөөр явах, батлагдсан замаас гарч шинэ зам гаргах, байгаль орчин, газрын хөрс, хадлан, тариалангийн талбай, ой модыг гэмтээх, гол мөрөн, нуур, булаг, хиймэл усан байгууламжийг бохирдуулах;

ж/зам хөндлөн буюу гүүрээр тууварлан гаргаж байгаа мал, ердийн хөсгийг үргээх; з/цуваанд яваа тээврийн хэрэгслүүдийн буюу жагсаалаар яваа хүмүүсийн дундуур нэвтрэн гарах, тэдний хооронд байр эзлэх.

### 3. Явган зорчигчийн үүрэг

**3.1.** Явган зорчигч нь явган хүний замаар, ийм зам байхгүй бол зорчих хэсгийн хажуугийн хөвөөгөөр явна.

Явган хүний зам, хөвөө байхгүй буюу түүгээр явах боломжгүй тохиолдолд явган зорчигч нь унадаг дугуйн зам эсвэл зорчих хэсгийн захаар (тусгаарлах зураастай замд зорчих хэсгийн гадна талын захаар) явна. Түүнчлэн тэрэг турсан, чарга чирсэн, овор ихтэй ачаа барьсан буюу жагсаалаар яваа, мөн тахир дутуу хүний тэргэнцэртэй хүмүүс явган хүний зам, хөвөөгөөр явахад бусад явган зорчигчдод саад болохоор байвал зорчих хэсгийн захаар явж болно.

Суурин газрын гаднахь замд явган зорчигч зорчих хэсгээр явах тохиолдолд тээврийн хэрэгслийн хөдөлгөөний чигийн тэрэг турсан, чарга чирсэн, овор ихтэй ачаа барьсан буюу жагсаалаар яваа, мөн тахир дутуу хүний тэргэнцэртэй хүмүүс явган зорчигчдод саад болохоор байвал зорчих хэсгийн захаар явж болно.

**3.2.** Жагсаалаар яваа хүмүүс зорчих хэсгээр явах тохиолдолд дөрвөөс илүүгүйгээр зэрэгцэж хөдөлгөөний чигийн дагуу баруун гар талаар явна. Жагсаалын зуун гар талын захын урд болон ард өдрийн цагт улаан дарцаг, харанхуй буюу үзэгдэлт хангалтгүй үед урд нь цагаан, ард нь улаан гэрэл (эсвэл гэрэл ойлгуур) барьсан хүн хамгаалж явна.

**3.3.** Сургуулийн өмнөх насны хүүхдийг харгалзах хүнгүйгээр замын хөдөлгөөнд оролцуулахыг хориглох бөгөөд харгалзаж яваа хүн хүүхдийг хөтөлж (тэвэрч) явна.

Хүүхдийн жагсаалыг зөвхөн явган хүний замаар, явган хүний зам байхгүй бол зорчих хэсгийн хажуугийн хөвөөгөөр хоёроос илүүгүйгээр зэрэгцүүлж зөвхөн өдрийн цагаар явуулахыг зөвшөөрөх бөгөөд урд болон ард нь насанд хүрсэн хүн харгалзаж явна.

**3.4.** Явган зорчигч нь явган хүний гарц буюу гармаар зам хөндлөн гарна. Хэрэв үзэгдэх хүрээнд явган хүний гарц ба гарам байхгүй бол замын дагуу хоёр тийш сайн харагдах саадгүй хэсгээр, ойртон ирж яваа тээврийн хэрэгслийг өнгөрүүлэн эгц хөндлөн гарна.

**3.5.** Хөдөлгөөн зохицуулж байгаа үед зам хөндлөн гарахдаа явган зорчигчид зориулсан гэрлэн дохио (ийм гэрлэн дохио байхгүй бол зэрэгцээ хөдөлгөөний тээврийн хэрэгсэлд зориулсан гэрлэн дохио) буюу зохицуулагчийн

зөвшөөрсөн дохиогоор зорчих хэсэгт орно. Хэрэв зорчих хэсгийг хөндлөн гарч амжаагүй байхад дохио өөрчлөгдвөл энэ дүрмийн 5.2-т заасныг баримтална.

**3.6.** Зам дээр үзэгдэлт халхалсан саад, тээврийн хэрэгсэл зогсож байх үед тэр хэсгээр зам хөндлөн гарахдаа тээврийн хэрэгсэл ойртон ирж байгаа эсэхийг магадлан мэдсэн байвал зохино.

**3.7.** Замын аль ч хэсэгт тусгай дуут болон гэрэл дохио (шар гэрэл дохионоос бусад) ажиллуулсан тээврийн хэрэгслийг урьдчилан өнгөрүүлнэ.

**3.8.** Чиглэлийн тээврийн хэрэгслээр зорчих хүмүүс зориулсан талбай дээр, ийм талбай байхгүй бол зорчих хэсгийн хашлаганы гадна талд хүлээх бөгөөд тээврийн хэрэгслийг бүрэн гүйцэд зогссон үед зорчих хэсэг рүү орохыг зөвшөөрнө. Тээврийн хэрэгслээс буусны дараа зорчих хэсгийг нэн даруй чөлөөлнө.

**3.9.** Явган зорчигчид дор дурдсан зүйлийг хориглоно:

а/явган хүний гарцтай ба гарамтай (үзэгдэх хүрээнд) хэсгийн гарцгүй, гарамгүй хэсгээр зам хөндлөн гарах;

б/аюулгүй байдлыг хангахаас бусад шалтгаанаар зорчих хэсэг дээр зогсох, саатах, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд санаатайгаар саад хийх;

в/ойртон ирж яваа тээврийн хэрэгслийн урдуур гэнэт гүйх;

г/өөрийгөө хянаж, жолоодох чадваргүй үедээ зорчих хэсгээр явах.

#### 4. Тээврийн хэрэгслээр зорчигчийн үүрэг

**4.1.** Тээврийн хэрэгслээр зорчигч дараахь үүргийг хүлээнэ:

а/хамгаалах бүсээр тоноглогдсон автомашинаар зорчихдоо хамгаалах бүс хэрэглэх, мотоциклоор зорчихдоо хамгаалах малгай өмсөх;

б/тээврийн хэрэгслийг бүрэн гүйцэд зогссоны дараа явган хүний зам (эсвэл хөвөө) тал руу буюу ар тал руу бууж тэр талаас сууна. Хэрэв ийм боломжгүй бол аюулгүй байдлыг хангаж, бусдын хөдөлгөөнд саад хийхгүйгээр зорчих хэсэг тал руу бууж, тэр талаас суухыг зөвшөөрнө.

**4.2.** Тээврийн хэрэгслээр зорчигчид дор дурдсан зүйлийг хориглоно:

а/хөдөлгөөний үед тээврийн хэрэгслийн хүн тээхэд зориулаагүй хэсэг дээр буюу ачааны автомашины тэвшний хашлаганаас дээш гарсан ачаан дээр байрлаж явах, тэвшин дээр зогсох;

б/цонхоор биеэ болон бусад зүйл гаргах;

в/хөдөлгөөний үед жолоочийн анхаарлыг сарниулах, түүний үйлдэлд саад болох,

г/тээврийн хэрэгслийн явдал дунд хаалга нээх;

д/бусад хөдөлгөөнд оролцогчдод саад болохоор байвал зогсож байгаа тээврийн хэрэгслийн хаалгыг нээх.

#### 5. Замын хөдөлгөөн зохицуулах дохио

**5.1.** Хориглосон дохиогоор жолооч "Зогс-шугам" тэмдэглэл буюу 5.29 тэмдгийн өмнө зогсох бөгөөд хэрэв тийм тэмдэг, тэмдэглэл байхгүй бол тээврийн хэрэгсэл, явган зорчигчийн хөдөлгөөнд саад болохгүйгээр уулзвар буюу явган хүний гарцын өмнө зогсоно.

**5.2.** Энэ дүрмийн 5.1-д заасан зогсох газрыг зөвшөөрсөн дохиогоор нэвтрэн орсон жолооч уг дохио өөрчлөгдвөл аюулгүй байдлыг хангаж, явж байгаа чигтээ хөдөлгөөнөө үргэлжлүүлнэ. Харин уулзвар дээр жолоочийн явах чигийн өмнө "Зогс-шугам" тэмдэглэл буюу 5.29 тэмдэг бүхий гэрлэн дохио байвал түүнийг удирдлага болгоно.

Зөвшөөрсөн дохиогоор явган хүний гарц руу орсон явган зорчигч дохио өөрчлөгдвөл аюулгүйн зурвас дээр зогсож дараагийн зөвшөөрөх дохио хүлээх ба хэрэв аюулгүйн зурвасыг өнгөрсөн, эсвэл тэр нь байхгүй бол зорчих хэсгийг нэвтрэн гарахыг зөвшөөрнө.

*Тайлбар: Дээрх тохиолдолд явган зорчигч аюулгүй байдлыг хангах үүднээс хөдөлгөөний эсрэг урсгалын зааг дээр зогсож зөвшөөрөх дохиог хүлээж болно.*

**5.3.** Зохицуулагчийн дохиогоор хөдөлгөөн зохицуулж байгаа уулзварт гэрэл дохио болон дарааллын тэмдгийн заалтыг, гэрлэн дохиогоор зохицуулж байгаа бол дарааллын тэмдгийн заалтыг мөрдөхгүй.

#### Гэрлэн дохио

**5.4.** Замын хөдөлгөөн зохицуулахад улаан, шар, ногоон өнгийн гэрэл бүхий босоо буюу хэвтээ байрлалтай дохио хэрэглэнэ. Босоо байрлалтай дохионы гэрэл нь улаан, шар, ногоон өнгийн дарааллаар дээрээс доош, хэвтээ байрлалтай дохионы гэрэл нь мөн дарааллаар зүүн гар талаас баруун гар тийш байрлана.

Явган зорчигчийн хөдөлгөөнийг зохицуулахад явган хүний дүрс бүхий дээд талдаа улаан, доод талдаа ногоон өнгийн гэрэлтэй дохио хэрэглэнэ.

**5.5.** Тээврийн хэрэгслийн хөдөлгөөн зохицуулах гэрлэн дохио нь ногоон сум бүхий нэг буюу хоёр нэмэгдэл дохиотой, мөн ногоон гэрэл нь чиг заасан сумтай байж болно.

**5.6.** Гэрэл дохио нь дор дурдсан утгатай байна: а/ногоон гэрэл дохио нь хөдөлгөөнийг зөвшөөрнө, Ногоон гэрэл анивчих нь түүний



зөвшөөрсөн утгыг өөрчлөхгүй бөгөөд хориглох гэрэл асах гэж байгааг анхааруулна; б/шар гэрэл дохио нь гэрэл дохио солигдох гэж буйг анхааруулах бөгөөд энэ дүрмийн 5.2-т зааснаас бусад тохиолдолд хөдөлгөөнийг хориглоно;

в/анивчсан шар гэрэл дохио нь хөдөлгөөнийг зөвшөөрөх бөгөөд тухайн уулзвар буюу явган хүний гарц зохицуулгагүй болсныг мэдээлж болгоомжтой явахыг анхааруулна; г/улаан гэрэл дохио буюу түүний анивчих нь хөдөлгөөнийг хориглоно. Улаан гэрэл дохиотой хамт ассан шар гэрэл дохио нь хориглосон утгыг өөрчлөхгүй бөгөөд ногоон гэрэл дохио асах гэж байгааг анхааруулна.

**5.7.** Нэмэгдэл гэрэл дохио нь зөвхөн сум заасан чигийн хөдөлгөөнийг зохицуулна. Зүүн гар тийш чиг заасан сум бүхий гэрэл дохио нь зүүн гар тийш болон буцаж эргэх хөдөлгөөнийг зохицуулна.

Нэмэгдэл гэрэл дохио асаж байвал заасан чигт хөдөлгөөнийг зөвшөөрөх бөгөөд асаагүй (гэрлэн дохионы зохицуулгатай үед) бол уг чигт хөдөлгөөнийг хориглоно. Энэ тохиолдолд үндсэн гэрэл дохио нь нэмэгдэл дохионы сум зааснаас бусад чигийн хөдөлгөөнийг зохицуулна.

## Зохицуулагчийн дохио

**5.8.** Зохицуулагч биеийн байрлал, дохиурын заалтаар дохио өгнө.

**5.9.** Зохицуулагчийн хөдөлгөөн зохицуулах дохио нь дор дурдсан утгатай байна:

а/дохиурыг өргөсөн байвал энэ дүрмийн 5.2-т зааснаас бусад тохиолдолд хөдөлгөөнийг хориглоно;

б/дохиурыг цээжиндээ авсан буюу гараа алдалсан байвал зохицуулагчийн зүүн болон баруун гар талаас яваа тээврийн хэрэгсэл чигээрээ буюу баруун гар тийш нэвтрэх, явган зорчигч зам хөндлөн гарахыг зөвшөөрөх бөгөөд зохицуулагчийн ар, өвөр талаас яваа тээврийн хэрэгсэл, явган зорчигчийн хөдөлгөөнийг хориглоно;

в/дохиурыг урагш заасан байвал зохицуулагчийн зүүн гар талаас яваа тээврийн хэрэгсэл бүх чигт, өвөр талаас яваа тээврийн хэрэгсэл зөвхөн баруун гар тийш эргэхийг зөвшөөрөх бөгөөд бусад талаас (баруун гар буюу ар талаас) яваа тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хориглоно. Явган зорчигч зохицуулагчийн зөвхөн ар талаар зам хөндлөн гарахыг зөвшөөрнө.

**5.10.** Зохицуулагч нь жолооч, явган зорчигчдод хөдөлгөөний чигийг өөрчлөх, байр эзлэх, хөдөлгөөний хурдаа хасах буюу нэмэх, тойрон гарах, зогсох зэрэг үйлдэл хийхийг заасан ойлгогдохуйц дохио өгч болно.

**5.11.** Зохицуулагч дохиураа тээврийн хэрэгсэл рүү чиглүүлэн зааж дохио буюу чанга яригч хэрэгслээр шаардвал уг тээврийн хэрэгслийн жолооч заасан газарт зогсох үүрэгтэй.

**5.12.** Зохицуулагчийн шүглийн дохио буюу бүсний анивчсан шар гэрэл нь хөдөлгөөнд оролцогчдын анхаарлыг өндөржүүлэх зорилготой.

**5.13.** Зохицуулагчийн ойлгогдохуйц дохио нь гэрэл дохио, тэмдэг, тэмдэглэл түүнчлэн энэ дүрмийн бусад заалтуудаас давуу байна.

## 6. Дуут болон ослын дохио, ослын зогсолтын тэмдэг хэрэглэх

**6.1.** Дуут дохиог зөвхөн дараахь тохиолдолд хэрэглэж болно:

а/зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэхийн тулд;

б/суурин газрын гаднахь замд гүйцэж тухруулэхийн тулд бусад жолоочид анхааруулах зорилгоор.

Дуут дохио нь давуу эрх олгохгүй бөгөөд урьдчилан сэргийлэх зайлшгүй арга хэмжээ авахаас чөлөөлөхгүй.

**6.2.** Ослын дохионы гэрлийг дараахь тохиолдолд хэрэглэнэ:

а/ зам тээврийн ослын улмаас зогссон үед; б/түр зогсохыг хориглосон газарт зайлшгүй зогсолт хийсэн үед;

в/харанхуй буюу үзэгдэлт хангалтгүй үед замын гэрэлтүүлэггүй хэсэгт оврын гэрэл нь асахгүй (эсвэл байхгүй) тээврийн хэрэгслийг зогсоосон үед;

г/жолоочийн нүд гялбан зорчих баримжаа алдах үед;

д/чирэгдэж яваа (механикжсан тээврийн хэрэгсэл) үед;

е/тээврийн хэрэгсэл нь аюулгүй байдлыг алдагдуулж болзошгүй бусад тохиолдолд.

**6.3.** Ослын зогсолтын тэмдгийг бусад жолооч нарт аюул саадыг урьдчилан анхааруулах зорилгоор тээврийн хэрэгслээс суурин газарт 15 метрээс багагүй, суурин газрын гаднахь замд 30 метрээс багагүй зайд байрлуулна.

Ослын зогсолтын тэмдгийг дараахь тохиолдолд хэрэглэнэ:

а/зам тээврийн ослын улмаас зогссон үед; б/түр зогсохыг хориглосон газарт зайлшгүй зогсолт хийсэн тээврийн хэрэгслийн ослын дохионы гэрэл нь ажиллахгүй (эсвэл байхгүй) буюу уг тээврийн хэрэгсэл нь ойртон ирж яваа бусад жолооч нарт харагдахааргүй тохиолдолд;

в/харанхуй буюу үзэгдэлт хангалтгүй үед замын гэрэлтүүлэггүй хэсэгт оврын болон ослын дохионы гэрлүүд нь асахгүй (эсвэл байхгүй) тээврийн хэрэгслийг зогсоосон үед;



г/чирэгдэж яваа механикжсан тээврийн хэрэгслийн ослын дохионы гэрэл нь ажиллахгүй (эсвэл байхгүй) бол.

*Тайлбар: Энэ тохиолдолд ослын зогсоолтын тэмдгийг уг тээврийн хэрэгслийн гадна талын арын хэсэгт байрлуулна.*

## 7. Хөдөлгөөн эхлэх болон чиг өөрчлөх

**7.1.** Жолооч хөдөлгөөн эхлэх, чиг өөрчлөх (байр эзлэх, эргэх, зогсох)-ийн өмнө тэр чигт явахаа анхааруулсан дохиог эргэх чиг заадаг гэрлээр, хэрэв тэр нь ажиллахгүй буюу байхгүй бол гараар өгнө.

**7.2.** Эргэх чиг заадаг анхааруулах дохиог гараар өгөх бол бусад хөдөлгөөнд оролцогчдод уг дохио сайтар харагдахуйц байдлаар гүйцэтгэнэ. Зүүн гар тийш дохио өгөхдөө зүүн гараа чигээр нь сунгах буюу эсвэл баруун гараа тохойгоор нь нугалж өргөнө. Баруун гар тийш дохио өгөхдөө баруун гараа чигээр нь сунгах буюу эсвэл зүүн гараа тохойгоор нь нугалж өргөнө.

**7.3.** Эргэх чиг заадаг анхааруулах дохиог тодорхой үйлдэл хийхийн өмнө өгөх бөгөөд үйлдлээ хийж дуусмагц зогсоно. Харин анхааруулах дохиог гараар өгсөн бол тодорхой үйлдэл хийж эхлэхийн өмнө дуусгаж болно.

**7.4.** Тоормосны гэрэл нь уг тээврийн хэрэгсэл хурдаа хасаж байгааг анхааруулах бөгөөд хэрэв тэр нь ажиллахгүй буюу байхгүй бол жолооч тоормослохын өмнө бусад хөдөлгөөнд оролцогчдод сайтар харагдахуйц байдлаар гараа сунган дээш доош хөдөлгөнө.

**7.5.** Анхааруулах дохио нь бусад хөдөлгөөнд оролцогчдыг төвөөрдүүлэхгүй, тэдэнд буруу ойлголт төрүүлэхээргүй байвал зохино.

Анхааруулах дохио нь давуу эрх олгохгүй бөгөөд урьдчилан сэргийлэх зайлшгүй арга хэмжээ авахаас чөлөөлөхгүй.

**7.6.** Жолооч хөдөлгөөн эхлэхдээ зам, орчны байдлыг биеэр шалгаж, байр эзлэх, хөдөлгөөний чиг өөрчлөхөд бусдын хөдөлгөөнд саад учруулахгүй байх бүх нөхцөлийг хангана.

**7.7.** Жолооч гарцаар замд нийлэхдээ тэр замаар яваа тээврийн хэрэгсэл, явган зорчигчид, замаас гарахдаа явган зорчигч, унадаг дугуйнд зам тавьж өгнө.

**7.8.** Жолооч байр эзлэхийн өмнө зэрэгцээ эгнээнд чигээрээ яваа тээврийн хэрэгсэлд зам тавьж өгнө. Харин харилцан байраа солиход баруун гар талд яваа нь эхэлж байраа эзэлнэ.

**7.9.** Уулзвар, гарцаар нэвтрэх хөдөлгөөн нь зөвхөн нэг чигт зөвшөөрөгдсөнөөс бусад тохиолдолд жолооч баруун гар тийш эргэхийн өмнө хамгийн баруун, зүүн гар тийш буюу буцаж эргэхийн өмнө хөдөлгөөний тухайн чигийн хамгийн зүүн гар талын захад байр эзэлсэн байвал зохино.

Хэрэв тухайн эгнээнээс явах хөдөлгөөний чигийг тэмдэг, тэмдэглэлээр заасан байвал уг тэмдэг, тэмдэглэлийн заалтыг баримтална.

**7.10.** Жолооч баруун буюу зүүн гар тийш эргэхдээ тээврийн хэрэгслийн оврын хэмжээ болон бусад шалтгаан (ачааны онцлог, зам дээрх саад гэх мэт)-аар энэ дүрмийн 7.9-д заасан шаардлагыг биелүүлэх боломжгүй бол аюулгүй байдлыг хангаж, бусад тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг саатуулахгүйгээр уг үйлдлийг өөр эгнээнээс гүйцэтгэхийг зөвшөөрнө.

Зорчих хэсэг дээр зүүн гар талын захаас буцаж эргэх боломжгүй бол баруун гар талын эгнээ (эсвэл хөвөө)-нээс гүйцэтгэхийг зөвшөөрнө. Ингэхдээ өөдөөс буюу зэргэлдээ эгнээнд араас яваа тээврийн хэрэгсэлд зам тавьж өгнө.

**7.11.** Жолооч уулзвар, гарцаас гарахдаа эсрэг урсгалыг сөрөхгүйгээр үйлдлийг гүйцэтгэнэ. Баруун гар тийш эргэхдээ зорчих хэсгийн баруун гар талын захад аль болох ойр байдлаар нэвтрэнэ.

**7.12.** Жолооч зүүн гар тийш буюу буцаж эргэхдээ (уулзвар нэвтрэх тохиолдлоос гадна) өөдөөс чигээрээ яваа болон баруун гар тийш эргэх тээврийн хэрэгсэлд зам тавьж өгнө.

**7.13.** Хөдөлгөөний дараалал нь энэ дүрмийн бусад заалтуудад тусгагдаагүй газарт жолооч баруун гар талаас ойртон ирж яваа тээврийн хэрэгсэлд зам тавьж өгнө.

**7.14.** Зам нь хурд хасах эгнээтэй бол жолооч эргэх үйлдэл хийхийн өмнө тэр эгнээнд орсны дараа тээврийн хэрэгслийн хурдыг хасна. Харин хурд авах эгнээгээр явж замд нийлэхдээ тухайн замаар яваа тээврийн хэрэгсэлд зам тавьж өгнө.

**7.15.** Саадыг тойрон гарахдаа өөдөөс яваа тээврийн хэрэгсэлд зам тавьж өгнө.

Бэрхшээлтэй (өгсүүр буюу ганга жалгатай) замын нарийссан хэсэгт тээврийн хэрэгслүүд зөрж өнгөрөх боломжгүй бол аль ганга жалгатай талд яваа тээврийн хэрэгсэлд, ганга жалгагүй бол өгсөж яваа тээврийн хэрэгсэлд зам тавьж өгнө.

**7.16.** Буцаж эргэхийг хориглох тохиолдол:  
 а/явган хүний гарц дээр;  
 б/төмөр замын гарам дээр;  
 в/гүүрэн дээр болон замд;  
 г/хонгил дотор;  
 д/үзэгдэлт замын дагуу аль нэг чигт 100 метрийн дотор хязгаарлагдмал газар;  
 е/чиглэлийн тээврийн хэрэгслийн буудал болон таксийн зогсоол дээр.

**7.17.** Бусдын хөдөлгөөнд саад учруулахваргүй газарт, аюулгүй байдлыг хангасан нөхцөлд ухрах үйлдэл хийхийг зөвшөөрнө. Шаардлагатай тохиолдолд ухрах үйлдлийг бусдын тусламжтайгаар гүйцэтгэх бөгөөд жолооч аюулгүй байдлыг хангах үүргээс чөлөөлөгдөхгүй.

**7.18.** Уулавар, гарц дээр буюу энэ дүрмийн 7.16-д заасан буцаж эргэхийг хориглосон бүх газарт ухрах үйлдлийг хориглоно.

## 8. Тээврийн хэрэгсэл байрлан явах

**8.1.** Эгнээний тогт зорчих хэсэг дээрх тэмдэглэл буюу 5.10.а,б, 5.11.а,б тэмдгээр тодорхойлно. Хэрэв адгээр тэмдэг, тэмдэглэл байхгүй бол зорчих хэсгийн өргөн, автомашины өргөний хэмжээ, тэдгээрийн хажуугийн зайг харгалзан эгнээний тоог тодорхойлох бөгөөд эсрэг хөдөлгөөнтэй бол тухайн зорчих хэсгийн өргөний зүүн гар тал дахь тэн хагасыг эсрэг хөдөлгөөнд зориулагдсанд тооцно.

**8.2.** Эсрэг хөдөлгөөнтэй хоёр эгнээгээр зорчдог замд гүйцэж түрүүлэх буюу тойрон гарахаас бусад тохиолдолд эсрэг урсгал сөрөхийг хориглоно.

**8.3.** Хөдөлгөөний эгнээ нь тэмдэглэлээр тодорхойлогдсон гурван эгнээгээр зорчдог замын дунд эгнээ сөрөг хөдөлгөөнтэй бол уг эгнээнд зөвхөн гүйцэж түрүүлэх, тойрон гарах, зүүн гар тийш буюу буцаж эргэхийн тулд орохыг зөвшөөрөх бөгөөд түүний зүүн гар талын эгнээнд урсгал сөрөхийг хориглоно.

**8.4.** Эсрэг хөдөлгөөнтэй дөрөв буюу түүнээс олон эгнээгээр зорчдог замд эсрэг урсгал сөрөхийг хориглоно.

**8.5.** Суурин газрын гаднахь-зам буюу 5.1, 5.5 тэмдэг тавигдсан замд тээврийн хэрэгсэл зорчих хэсгийн баруун гар талын захад аль болох ойр явах бөгөөд баруун гар талын эгнээ чөлөөтэй байхад (зүүн гар тийш буюу буцаж эргэхийн тулд байр эзлэхээс бусад тохиолдолд) түүний зүүн гар талын аль ч эгнээгээр явахыг хориглоно.

**8.6.** Суурин газарт жолооч энэ дүрмийн 8.7-8.10, 23.4-т заасан шаардлагуудыг зөрчихгүйгээр аль тохиромжтой эгнээг сонгож явна. Хөдөлгөөний эрчим ихтэй (эгнээ чөлөөгүй) замд эргэх үйлдэл хийх, саадыг тойрон гарах, зогсохоос бусад тохиолдолд эгнээ байр өөрчлөхийг хориглоно.

**8.7.** Нэг чигт гурав буюу түүнээс олон эгнээгээр зорчдог замын тухайн нигийн хамгийн зүүн гар талын эгнээнд зөвхөн гүйцэж түрүүлэх, зүүн гар тийш болон буцаж эргэхийн тулд, мөн хөдөлгөөний эрчим ихтэй (бусад эгнээнүүд чөлөөгүй) үед байр эзлэхийг зөвшөөрнө. Харин бүх жин нь 3.5 тонноос их ачааны автомашин зөвхөн зүүн гар тийш буюу буцаж эргэхийн тулд байр эзлэхээс бусад тохиолдолд уг эгнээнд орохыг хориглоно.

Дээрх зам нь нэг чигийн хөдөлгөөнтэй бол түр зогсохын тулд хамгийн зүүн гар талын эгнээнд орохыг зөвшөөрнө.

**8.8.** Трактор, өөрөө явдаг машин механизм болон цагт 40 км-ээс илүүгүй хурдтай явах тээврийн хэрэгсэл гүйцэж түрүүлэх, тойрон гарах, зүүн гар тийш буюу буцаж эргэхийн тулд байр эзлэхээс

бусад тохиолдолд зорчих хэсгийн хамгийн баруун гар талын эгнээгээр явна.

**8.9.** Тууш замд бүх жин нь 3.5 тонноос их ачааны автомашин зорчих хэсгийн баруун гар талын нэг буюу хоёр дахь эгнээгээр явна.

**8.10.** Троллейбусны жолооч өмнөх троллейбус шугамнаас салаагүй байхад зэрэгцээ эгнээнд орохыг хориглоно.

**8.11.** Жолооч нь урдаа яваа тээврийн хэрэгсэл зогсоход түүнийг мөргөхгүй, хажуу дахь тээврийн хэрэгслийг шүргэхгүй байх хэмжээний хоорондын болон хажуугийн зайг хөдөлгөөний хурднаас хамааруулан сонгож явна.

## 9. Тээврийн хэрэгслийн хурд

**9.1.** Жолооч хөдөлгөөний эрчим, тээврийн хэрэгслийн онцлог байдал, тээж яваа ачаа, замын болон цаг агаарын нөхцөл, хөдөлгөөний дагуу үзэгдэлтэй харгалзан тээврийн хэрэгслийн хурдыг энэ дүрэмд тогтоосон хязгаараас хэтрүүлэхгүйгээр сонгож явна.

**9.2.** Жолооч хөдөлгөөнд аюул, саад бий болохыг мэдсэн үед тээврийн хэрэгслийн хурдыг хасаж, зайлшгүй тохиолдолд зогсоох арга хэмжээ авна.

**9.3.** Тээврийн хэрэгслийн хурдыг суурин газарт цагт 60 км, суурин газрын гаднахь замд цагт 80 км, тууш замд цагт 100 км-ээс хэтрүүлэхгүйгээр сонгож явна. Харин дараахь тохиолдолд тээврийн хэрэгслийн хурдыг дор дурдсанаас хэтрүүлэхгүйгээр сонгож явбал зохино:

а/механикжсан тээврийн хэрэгслийг чирэх үед цагт 40 км;

б/хүүхдийг зохион байгуулалттайгаар тээвэрлэх үед цагт 50 км;

в/суурин газарт автобусаар буюу ачааны автомашины тэвшинд хүн тээвэрлэх үед цагт 50 км;

г/суурин газрын гаднахь зам болон тууш замд автобусаар буюу ачааны автомашины тэвшинд хүн тээвэрлэх үед цагт 70 км;

д/тууш замд мотоцикл, чиргүүлтэй суудлын автомашин, хүн тээвэрлээгүй автобус буюу бүх жин нь 3.5 тонноос их ачааны автомашин цагт 80 км;

е/хорооллын дотор цагт 20 км.

**9.4.** Жолоочид дор дурдсан зүйлийг хориглоно: а/тээврийн хэрэгслийн техникийн тодорхойлолтоор тогтоосон дээд хурдыг хэтрүүлэх;

б/Хурдны хязгаар таних тэмдэг бүхий тээврийн хэрэгслийн хурдыг уг тэмдэгт зааснаас хэтрүүлэх.

в/шалтгаангүйгээр хэт удаан явж бусдын хөдөлгөөнийг саатуулах;  
г/зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэхээс бусад тохиолдолд огцом тоормослох.

## 10. Гүйцэж түрүүлэх

**10.1.** Жолооч гүйцэж түрүүлэхийн өмнө дараахь нөхцөлүүдийг анхаарч мэдсэн байвал зохино:

а/уг үйлдлийг гүйцэтгэхэд хүрэлцэхүйц хэмжээний зай байгаа эсэх;

б/өөдөөс болон араас яваа тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд саад учруулж болзошгүй эсэх;

в/урд яваа тээврийн хэрэгсэл чиг өөрчлөх дохио өгсөн эсэх.

**10.2.** Гүйцэж түрүүлэх үйлдлийг хийхдээ гүйцэгдэж байгаа тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд саад учруулахагүй байвал зохино.

**10.3.** Тээврийн хэрэгслийг зөвхөн зүүн гар талаар нь гүйцэж түрүүлэхийг зөвшөөрнө. Харин зүүн гар тийш дохио өгөөд эргэх үйлдлээ эхэлсэн тээврийн хэрэгслийг баруун гар талаар нь гүйцэж түрүүлж болно.

**10.4.** Гүйцэж түрүүлэх гэж байгаагаа бусад жолооч нарт гэрэл шилжүүлэх буюу дуут дохио өгөх байдлаар (энэ дүрмийн 6.1, 15.7-д заасныг зөрчихгүйгээр) анхааруулж болно.

**10.5.** Гүйцэгдэж байгаа жолооч хурдаа нэмэх, гүйцэж түрүүлэхэд ямар нэг байдлаар саад хийхийг хориглоно.

Гүйцэж түрүүлэх нь хөдөлгөөнд аюултай байвал гүйцэгдэж байгаа жолооч зүүн гар тийш эргэх дохио өгч анхааруулна.

**10.6.** Гүйцэж түрүүлэхийг хориглох тохиолдол:

а/зохицуулдаг уулзвар дээр эсрэг урсгалыг сөрөхөөр бол;

б/зохицуулдаггүй уулзвар буюу гарц дээр (баруун гар талаар нь гүйцэж түрүүлэхийг зөвшөөрснөөс бусад тохиолдолд);

в/явган хүний гарц дээр;

г/төмөр замын гарам дээр буюу түүнд хүртэл 100 метрээс ойр зайд;

д/гүйцэж түрүүлж байгаа буюу тойрон гарч байгаа, мөн зүүн гар тийш эргэх дохио өгсөн тээврийн хэрэгслийг (баруун гар талаар нь гүйцэж түрүүлэхийг зөвшөөрснөөс бусад тохиолдолд);

е/эсрэг урсгалыг сөрөхөөр бол замын өгсүүр хэсгийн төгсгөл буюу үзэгдэлт хязгаарлагдмал хэсэгт;

ж/хөдөлгөөнд саад бэрхшээлтэй замд цуваар.

## 11. Түр буюу удаан зогсох

**11.1.** Жолооч тээврийн хэрэгслийг замын баруун гар талд зорчих хэсгийн хашлаганд шахаж, хашлагагүй замд зорчих хэсгийг чөлөөлж зогсоно. Хэрэв зорчих хэсгийг чөлөөлөх боломжгүй (хөвөөгүй) бол түүний зах руу аль болох шахаж зогсоно. Мөн энэ байдлаар нэг чигийн хөдөлгөөнтэй замын зүүн гар талд түр зогсохыг зөвшөөрнө.

**11.2.** Тээврийн хэрэгслийг зорчих хэсгийн зах (эсвэл хөвөө)-ыг дагуулан зөвхөн нэг эгнээгээр цувиулан зогсоохыг зөвшөөрнө. Харин зорчих хэсгийн өргөгдсөн талбайд цувиулахаас өөр байдлаар (бусдын хөдөлгөөнд саад учруулахгүйгээр) зогсоож болно.

**11.3.** Жолоочгүйгээр тээврийн хэрэгсэл үл хөдлөх буюу өөрөөс мөн бусад хүн хөдөлгөх боломжгүй болгох арга хэмжээ авсны дараа түүнийг орхиж явахыг зөвшөөрнө.

**11.4.** Суурин газрын гаднахь замд амрах, хонох зэргээр удаан зогсохдоо тээврийн хэрэгслийг тусгай зориулсан талбайд, эсвэл замаас зайдуу газарт зогсооно.

**11.5.** Түр зогсохыг хориглох тохиолдол:

а/уулзвар, гарц дээр буюу түүнд 20 метрээс ойр зайд (тусгаарлах зурвас буюу тэнхлэгийн үргэлжилсэн шугамтай Т-хэлбэрийн уулзвар, гарцын хөдөлгөөн огтлолцохгүй хэсэг дээр зогсохоос бусад тохиолдолд);

б/явган хүний гарц дээр буюу түүний өмнө 5 метрээс ойр зайд;

в/чиглэлийн тээврийн хэрэгслийн буудал, таксийн зогсоол дээр буюу түүнд 15 метрээс ойр зайд (тэдгээр тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд саад учруулахгүйгээр хүн буулгах, суулгахын тулд түр зогсохоос бусад тохиолдолд);

г/төмөр замын гарам дээр буюу түүнд 20 метрээс ойр зайд;

д/гүүрэн дээр болон доор;

е/хонгил дотор;

ж/эргэлэн дохио, замын тэмдэг халхлах, бусад тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хаах газарт;

з/тээврийн хэрэгсэл зогсоход түүнээс үргэлжилсэн шугам (зорчих хэсгийн захыг тэмдэглэснээс бусад) буюу зорчих хэсгийн эсрэг талын зах хүртэл 3 метрээс бага зайтай газарт;

и/үзэгдэлт замын дагуу аль нэг чигт 100 метрийн дотор хязгаарлагдмал нөхцөлд зорчих хэсэг дээр.

**11.6.** Удаан зогсохыг хориглох тохиолдол:

а/түр зогсохыг хориглосон газарт;

б/төмөр замын гарамд 100 метрээс ойр зайд.

**11.7.** Хориглосон газарт зайлшгүй зогсолт хийсэн жолооч тээврийн хэрэгслээ замын тухайн хэсгээс аль болох нэн даруй зайлуулах арга хэмжээ авбал зохино.

**11.8.** Бусдын хөдөлгөөнд саад болохоор байвал зогсож байгаа тээврийн хэрэгслийн хаалгыг нээхийг хориглоно.

## 12. Уулзвар нэвтрэх

**12.1.** Жолооч уулзвараар баруун, зүүн гар тийш эргэх үед явган хүний гарцаар зам хөндлөн гарч яваа явган зорчигч, унадаг дугуйн замаар яваа дугуйчинд зам тавьж өгнө.

**12.2.** Хөндлөн замаас яваа тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд саад учруулан тээврийн хэрэгслээ зогсоож болзошгүй түгжрэл, саатал бий болсон үед уулзвар руу орохыг хориглоно.

**12.3.** Гэрэл буюу зохицуулагчийн дохиогоор хөдөлгөөний дараалал тогтоож байгаа уулзварыг зохицуулдаг уулзвар гэнэ.

### Зохицуулдаг уулзвар нэвтрэх

**12.4.** Жолооч ногоон гэрлээр зүүн гар тийш буюу буцаж эргэхдээ уулзварт ороод өөдөөс чигээрээ яваа болон баруун гар тийш эргэх тээврийн хэрэгсэлд зам тавьж өгнө.

**12.5.** Улаан буюу шар гэрэлтэй хамт ассан нэмэгдэл дохиогоор явж буй жолооч бусад чиглэлээ яваа тээврийн хэрэгсэлд зам тавьж өгнө.

**12.6.** Зохицуулагчийн дохиогоор буцаж эргэхдээ зүүн гар талын замаас баруун гар тийш эргэж байгаа тээврийн хэрэгсэлд зам тавьж өгнө.

**12.7.** Зөвшөөрсөн гэрэл дохио асах үед жолооч нь уулзвар нэвтрэх үйлдлээ дуусгаж байгаа тээврийн хэрэгсэл, зорчих хэсгийг хөндлөн гарч амжаагүй яваа (аюулгүйн зурвастай тохиолдолд түүнийг өнгөрч яваа буюу түүнд хүрээгүй яваа) явган зорчигчид зам тавьж өгнө.

### Зохицуулдаггүй уулзвар нэвтрэх

**12.8.** Адил замын уулзварт жолооч баруун гар талаас ойртон ирсэн тээврийн хэрэгсэлд зам тавьж өгнө.

**12.9.** Гол ба туслах замын уулзварт туслах замаар яваа жолооч гол замаар яваа тээврийн хэрэгсэлд зам тавьж өгнө.

**12.10.** Жолооч зүүн гар тийш буюу буцаж эргэхдээ уулзварт ороод, адил замаар өөдөөс чигээрээ яваа болон баруун гар тийш эргэх тээврийн хэрэгсэлд зам тавьж өгнө.

**12.11.** Уулзвар дээр гол зам чигээ өөрчилсөн байвал тэр замаар яваа жолооч нар өөр хоорондоо адил замын уулзвар нэвтрэх журам баримтална.

Туслах замаар яваа жолооч нар өөр хоорондоо мөн энэ заалтыг баримтална.

**12.12.** Хөдөлгөөний дараалал тогтоосон тэмдэг байхгүй үед жолооч зорчих хэсгийн гадаргуугийн байдлыг тодорхойлж чадахгүй (харанхуй, манантай, цас орсон, бохирдсон зэргээс шалтгаалан) бол өөрийгөө туслах замаар яваад тооцно.

## 13. Явган хүний гарц нэвтрэх

**13.1.** Явган хүний зохицуулдаггүй гарц руу ойртон ирсэн жолооч хурдаа хасаж, хэрэв явган зорчигч уг гарцаар явж байвал зам тавьж өгнө.

**13.2.** Зөвшөөрсөн гэрэл дохио асах үед жолооч явган хүний гарцыг нэвтрэхдээ зорчих хэсгийг хөндлөн гарч амжаагүй яваа (аюулгүйн зурвастай тохиолдолд түүнийг өнгөрч яваа буюу түүнд хүрээгүй яваа) явган зорчигчид зам тавьж өгнө.

**13.3.** Явган хүний гарцын өмнө тээврийн хэрэгсэл зогссон буюу хурдаа хасаж байвал араас нь ирсэн жолооч түүнийг урдуугийн зам хөндлөн гарч яваа явган зорчигч байхгүйг бүрэн мэдсэнийхээ дараа хөдөлгөөнөө үргэлжлүүлнэ.

**13.4.** Жолооч замын аль ч хэсэгт хараагүй хүн (цагаан таяг барьсан)-ийг урьдчилан өнгөрүүлнэ.

**13.5.** "Хүүхэд тээвэрлэж яваа тээврийн хэрэгсэл" гэсэн таних тэмдэг бүхий тээврийн хэрэгсэл зогсож байвал ойртон ирсэн жолооч хурдаа хасаж анхаарал болгоомжтой явах шаардлагатай бөгөөд зайлшгүй шаардлага гарвал зогсож хүүхдүүдийг урьдчилан өнгөрүүлнэ.

**13.6.** Жолооч явган хүний гарц дээр тээврийн хэрэгслээ зогсоож болзошгүй саад тохиолдсон үед гарц руу орохыг хориглоно.

## 14. Төмөр замын гарам нэвтрэх

**14.1.** Жолооч төмөр замыг зөвхөн гарамтай хэсгээр нэвтрэнэ. Ингэхдээ ойртон ирсэн галт тэрэг (зүтүүр)-ийг урьдчилан өнгөрүүлбэл зохино.

**14.2.** Жолооч төмөр замын гарамд ойртон очихдоо аюулгүй байдал хангагдсан эсэхийг магадлан, дуут буюу гэрэл дохио, тэмдэг, тэмдэглэлийн заалт, хаалтын байрлал, гармын жижүүрийн заалтыг удирдлага болгоно.

**14.3.** Төмөр замын гармын хаалт хаалттай буюу хаагдаж эхэлж байвал, мөн анивчсан улаан гэрэл ассан, эсвэл дуут дохио ажиллаж байхад, түүнчлэн гармын жижүүр хориглосон дохио өгөх үед гарам руу орохыг хориглоно.

**14.4.** Төмөр замын гармаар нэвтрэх хөдөлгөөнийг хориглосон үед жолооч "Зогс-шугам" тэмдэглэл буюу 3.5 тэмдэг эсвэл гэрлэн дохионы өмнө, хэрэв эдгээр нь байхгүй бол хаалтнаас 5 метрээс багагүй зайд, хаалтгүй тохиолдолд төмөр замаас 10 метрээс багагүй зайд зогсож галт тэргийг өнгөрүүлнэ.



**14.5.** Жолоочид дор дурдсан зүйлийг хориглоно:

а/гармын хаалтыг дур мэдэн нээх буюу өөрчлөх;

б/гармыг гэмтээж болзошгүй машин механизмыг тээвэрлэхээс бусад байдлаар гаргах;

в/цагт 8 км-ээс бага хурдтай явдаг машин механизмыг төмөр замын ангийн даргын зөвшөөрөлгүйгээр гаргах;

г/гарам дээр тээврийн хэрэгслээ зогсоож болзошгүй саад тохиолдсон үед гарам руу орох.

**14.6.** Төмөр замын гарам дээр жолооч зайлшгүй зогсолт хийвэл зорчигчдыг нэн даруй буулган, ослын дохионы гэрлээ асааж, гармыг чөлөөлөх арга хэмжээ авна.

Хэрэв гармыг нэн даруй чөлөөлөх боломжгүй бол:

а/бололцоотой бол хоёр хүнийг төмөр замын дагуу гармаас хоёр тийш (ганц хүнтэй бол түүнийг замын байдал муу үзэгдэх зүг рүү) 1000 метрийн зайд явуулж галт тэргэнд зогсох дохио өгүүлнэ. Ингэхдээ тэр хүмүүст дохио өгөх журмыг зааварчилна;

б/жолооч тээврийн хэрэгслийн дэргэд үлджэ дуут дохио өгнө;

в/галт тэрэг ойртон ирж байгаа эсэхийг анхааралтай ажиглан, хэрэв ирж байвал угтан гүйж зогсох дохио өгнө.

Тайлбар: Дуут дохиог нэг урт, гурван богино хэмнэлээр, зогсох дохиог өдрийн цагт тод өнгийн сайн харагдах зүйлээр, харанхуй буюу үзэгдэлт хангалтгүй үед гэрэл буюу галаар тойруулан даллаж өгнө.

## 15. Гадна талын гэрэлтүүлэх хэрэгслийг хэрэглэх

**15.1.** Харанхуй буюу үзэгдэлт хангалтгүй үед тээврийн хэрэгслийн гадна талын гэрлийг дараахь байдлаар асааж явна:

а/замын гэрэлтүүлэггүй хэсэгт холын буюу ойрын гэрлийг асаана. Өөдөөс ирж яваа тээврийн хэрэгсэл хүртэл 150 метрээс багагүй зайд буюу жолоочийг гялбуулж болзошгүй бусад тохиолдолд холын гэрлийг ойрын гэрэлд шилжүүлнэ. Мөн өөдөөс яваа жолооч гэрлээ үе үе шилжүүлэн дохивол зайн хэмжээг үл харгалзан холын гэрлийг ойрын гэрэлд шилжүүлнэ.

Хэрэв жолоочийн нүд гялбан зорчих баримжаа алдвал ослын дохионы гэрлээ асааж, эзэлж явсан эгнээгээ өөрчлөхгүйгээр хурдаа хасах буюу зогсоно;

б/замын гэрэлтүүлэгтэй хэсэгт ойрын гэрлийг асаана;

в/чиргүүл чирч яваа үед чиргүүлийн оврын гэрлийг асаана.

**15.2.** Харанхуй буюу үзэгдэлт хангалтгүй үед замын гэрэлтүүлэггүй хэсэгт тээврийн хэрэгслийг зогсооходоо оврын гэрлийг асаана. Хэрэв тэр нь гэмтэлтэй буюу байхгүй бол тээврийн хэрэгслийг замаас гаргах бөгөөд ийм бололцоогүй үед энэ дүрмийн 6.2-ын "в", 6.3-ын "в" заалтын дагуу анхааруулах дохио хэрэглэнэ.

**15.3.** Харанхуй буюу үзэгдэлт хангалтгүй үед чиргүүл чирч явах ба зогсоходоо бүхээг дээрх "Чиргүүлтэй тээврийн хэрэгсэл" таних тэмдгийг асаана.

**15.4.** Гэрэлтүүлүүрийг суурин газрын гаднахь замд хэрэглэхийг зөвшөөрөх бөгөөд өөдөөс тээврийн хэрэгсэл гарч ирсэн үед унтрааж байвал зохино. Түүнийг суурин газарт тусгай дуут болон гэрлэн дохиогоор тоноглогдсон автомашины жолооч албан үүргээ гүйцэтгэж явахдаа шаардлагатай үед хэрэглэж болно.

**15.5.** Манангийн гэрлийг цас, бороо орж байгаа буюу өтгөн манан будантай үед дангаар нь эсвэл хол, ойрын гэрлийн хамт хэрэглэнэ.

Тайлбар: Автомашинд хоёр, мотоцикльд нэг манангийн гэрэл тавина. Манангийн гэрлийг автомашины урд талд, хоёр хажуугаас нь 400 мм-ээс дотогш, том гэрлээс өндөргүй зайд тэгш хэмтэй байрлуулна.

**15.6.** Бусад хөдөлгөөнд оролцогчдод анхааруулах зорилгоор өдрийн цагт дараахь тохиолдолд ойрын гэрлийг асаана:

а/цуваагаар яваа үед;

б/хүүхдийг зохион байгуулалттайгаар тээвэрлэж яваа үед;

в/хүнд буюу овор ихтэй, мөн аюултай ачаа тээвэрлэж яваа үед;

г/механикжсан тээврийн хэрэгслийг чирч яваа үед;

д/тусгай дуут болон гэрэл дохио ажиллуулсан тээврийн хэрэгслээр хамгаалуулж яваа үед.

**15.7.** Гэрэл шилжүүлэх дохиог өгөхдөө харанхуй буюу үзэгдэлт хангалтгүй үед хол, ойрын гэрлийг эзлэлэн шилжүүлэх, өдрийн цагт асааж, унтраах байдлаар үйлдэнэ. Энэ дохио нь урд болон өөдөөс яваа жолоочийг гялбуулахаар бол хэрэглэхийг хориглоно.

## 16. Хорооллын доторхи хөдөлгөөн

**16.1.** 5.30 тэмдгээр тэмдэглэгдсэн хорооллын доторхи хөдөлгөөнд явган зорчигч явган хүний зам буюу зорчих хэсэгээр ирж болно. Хорооллын дотор явган зорчигч давуу эрхтэй зорчих боловч тээврийн



хэрэгслийн хөдөлгөөнд санаатайгаар саад учруулахыг хориглоно.

**16.2.** Хорооллын доторхи хөдөлгөөнд тээврийн хэрэгслийн хурдыг цагт 20 км-ээс хэтрүүлэх, жолоодлогын дадлага явуулах, тээврийн хэрэгслийг удаан хугацаагаар асаалттай зогсоох, мөн нэмэлт тэмдгээр тусгайлан заасан зогсоолоос бусад хэсэгт бүх жин нь 3.5 тонноос их ачааны автомашиныг удаан зогсоохыг хориглоно.

**16.3.** Жолооч хорооллын доторхи хөдөлгөөнөөс гарч зам руу орохдоо бусад хөдөлгөөнд оролцогчдод зам тавьж өгнө.

## 17. Тууш замын хөдөлгөөн

**17.1.** Тууш замд хориглох зүйл:

а/явган зорчигч, ердийн хөсөг, унадаг дугуй, мопед болон трактор, өөрөө явдаг машин механизм мөн түүнчлэн техникийн дээд хурд нь цагт 40 км-ээс ихгүй тээврийн хэрэгслийн хөдөлгөөн;

б/Бүх жин нь 3.5 тонноос их ачааны автомашин зорчих хэсгийн баруун гар талын нэг буюу хоёр дахь эгнээнээс бусад аль ч эгнээгээр явах;

в/5, 15, 5.44 тэмдгээр заасан зориулалтын зогсоолын талбайгаас бусад хэсэгт түр зогсох;

г/ухрах буюу буцаж эргэх;

д/жолоодлогын дадлага явуулах.

**17.2.** Тууш замд жолооч зайлшгүй зогсолт хийвэл энэ дүрмийн 6.2-ын "б", 6.3-ын "б" заалтын дагуу анхааруулах дохио хэрэглэж, зорчих хэсгийг нэн даруй чөлөөлөх арга хэмжээ авна.

## 18. Цуваагаар явах

**18.1.** Цувааг томилогдсон ахлагч зохион байгуулан удирдаж явна.

**18.2.** Цуваанд яваа тээврийн хэрэгслийн хурд болон хоорондын зайг замын байдал, цаг агаарын нөхцөлд тохируулан цувааны ахлагч тогтоох бөгөөд хөдөлгөөний хурд нь энэ дүрмийн 9.3-т заасан хязгаараас хэтрэхгүй байвал зохино.

Цуваа нь гүйцэж түрүүлэх, тойрон гарах, зүүн гар тийш буюу буцаж эргэхийн тулд байр эзлэхээс бусад тохиолдолд зорчих хэсгийн хамгийн баруун гар талын эгнээгээр явна.

**18.3.** Бусад жолооч нар замын нарийн хэсэгт (тэмдгээр дараалал тогтоогоогүй бол) цуваанд зам тавьж өгнө.

**18.4.** Цувааг тусгай дуут болон гэрэл дохио ажиллуулсан тээврийн хэрэгсэл хамгаалан яваа бол тэр нь цувааг чиглүүлэн удирдаж явах бөгөөд энэ дүрмийн 2.4-т заасныг хэрэгжүүлж болно.

## 19. Жолоодлогын дадлага хийх

**19.1.** Жолоодлогын дадлагыг багшийн шууд удирдлагын дор хийнэ.

**19.2.** Жолоодлогын дадлагыг эхлээд тусгайлан бэлтгэсэн талбайд хийж, сурагчид аамын хөдөлгөөний дүрмийн мэдлэг, жолоодлогын зохих дадлагатай болсны дараа Замын цагдаагийн албанаас зөвшөөрсөн хугацаа, чиглэлийн дагуу замын хөдөлгөөнд хийнэ.

**19.3.** Жолоодлогын дадлага хийлгэх багш нь Замын цагдаагийн албанаас олгосон багшлах эрхийн үнэмлэх болон дадлага хийлгэж байгаа тээврийн хэрэгслийн ангилалд тохирох жолоодох эрхийн үнэмлэхтэй байна.

**19.4.** Жолоодлогын дадлагын тээврийн хэрэгсэл нь "Сургалтын тээврийн хэрэгсэл" танхиг тэмдэгтэй байна.

Жолоодлогын дадлагын автомашин, механизм нь багшд зориулсан тоормос болон авцуулах холбооны нэмэлт дөрвө, ар талыг харах нэмэлт тольтой байхаас гадна дадлага хийх үед тэвшний зүүн урд болон баруун хойд өнцөгт 250 x 250 мм хэмжээтэй улаан дарцагтай байна.

**19.5.** Жолоодлогын дадлага хийх үед аюулгүй байдлыг хангах үүргийг дадлагын багш хариуцна.

## 20. Механикжсан тээврийн хэрэгслийг чирэх

**20.1.** Механикжсан тээврийн хэрэгслийг зөөлөн буюу хатуу холбоогоор, мөн цоройлгон ачих байдлаар найдвартай холбож чирэх бөгөөд хөдөлгөөнд оролцохдоо ойрын гэрлээ асаана.

Чирэгдэж яваа механикжсан тээврийн хэрэгсэл нь энэ дүрмийн 6.2-ын "д", 6.3-ын "г" заалтын дагуу анхааруулах дохио хэрэглэнэ.

**20.2.** Хатуу холбоогоор чирэгдэж яваа тээврийн хэрэгсэл нь шулуун чигт чирч яваа тээврийн хэрэгслийнхээ дугуйн мөрийг дагахаар холбогдоогүй, түүнчлэн зөөлөн холбоо хэрэглэсэн бол чирэгдэж яваа тээврийн хэрэгслийг жолоодох эрхийн үнэмлэхтэй хүн холосдоно.

**20.3.** Хатуу холбоогоор чирэх үед тээврийн хэрэгслүүдийн хоорондын зай нь 4 метрээс илүүгүй байна. Хатуу холбоогоор чирэгдэх тээврийн хэрэгслийн жолооны механизм бүрэн ажиллагаатай байвал зохино.

**20.4.** Зөөлөн холбоогоор чирэх үед тээврийн хэрэгслүүдийн хоорондын зай нь 4-6 метр байх бөгөөд зөөлөн холбооны нэг метр тутамд улаан дарцаг байна. Зөөлөн холбоогоор чирэгдэх тээврийн хэрэгслийн тоормосны систем, жолооны механизм, дуут дохио бүрэн ажиллагаатай байвал зохино.

**20.5.** Механикжсан тээврийн хэрэгслийг чирэх үед чирч яваа автобус, троллейбусанд буюу ачааны автомашины тэвшинд, мөн чирэгдэж яваа тээврийн хэрэгсэлд хүн тээвэрлэхийг хориглоно.

**20.6.** Механикжсан тээврийн хэрэгслийг чирэхийг хориглох тохиолдол:

а/чиргүүлтэй тээврийн хэрэгслээр;

б/хоёр буюу түүнээс олон механикжсан тээврийн хэрэгслийг;

в/хоёр дугуйтай мотоциклоор буюу хоёр дугуйтай мотоциклийг;

г/халтиргаатай зам буюу уулын замд зөвлөн холбоогоор;

д/чирэгдэж яваа тээврийн хэрэгслийн бодит жин нь чирч яваа тээврийн хэрэгслийнхээс илүү бол;

е/уулын замд зорчих хэсэг нь мөстсөн бол.

## 21. Хүн тээвэрлэх

**21.1.** Зорчигчдыг хүн тээвэрлэх зориулалт бүхий тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ. Жолооч хөдөлгөөн эхлэхийн өмнө зорчигчдыг тээвэрлэхэд шаардагдах аюулгүй байдал хангагдсан эсэхийг шалгаж үзсэн байвал зохино.

**21.2.** Жолооч нь тээврийн хэрэгслээ гүйцэд зогсоосны дараа зорчигчийг буулгах буюу суулгах, хаалгаа гүйцэд хаасны дараа хөдөлгөөнөө эхлэх үүрэгтэй.

**21.3.** Хүн тээвэрлэхэд зориулан тоногдсон ачааны автомашины тэвшинд зорчигч тээвэрлэх тохиолдолд жолооч нь тухайн ангиллын тээврийн хэрэгслийг гурваас дээш жил жолоодож дадлагажсан байвал зохих бөгөөд тээврийн хэрэгслийг доорхи шаардлагын дагуу тоногдсон байна:

а/тэвшин дотор суудал засаж бат бөх бэхлэсэн байх бөгөөд суудлын тавцан нь шалнаас 0.3-0.5 метр, хашлаганы дээд ирмэгээс 0.3 метрээс багагүй байх;

б/хүүхэд тээвэрлэх тохиолдолд хашлаганы өндөр 0.8 метрээс багагүй байх;

в/тэвшний хойд болон хажуу хашлаганы дагуу зассан суудал нь түшлэгтэй байх;

г/зорчигчдыг буулгах, суулгах шаттай байх.

**21.4.** Жолооч хөдөлгөөн эхлэхийн өмнө зорчигчдод буух, суух, зорчих журмын тухай зааварчилж, хөдөлгөөний үед тэвшин дээр зогсож явахыг хориглох тухай анхааруулбал зохино.

**21.5.** Хүүхдийг зохион байгуулалттайгаар тээвэрлэх үед, түүнчлэн хот хоорондын буюу аялал жуулчлалын автобусанд болон хүн тээвэрлэхэд зориулан тоногдсон ачааны автомашины тэвшинд тээвэрлэх зорчигчдын тоо нь үйлдвэрээс тавьсан буюу зориулан тоногдсон суудлын тооноос илүүгүй байна.

**Тайлбар:** Ачааны автомашины тэвшинд тоногдсон суудлын тоог тогтооходоо тавцангийн 0.4-0.5 метрийн үрттэй хэсгийг 1 нэгжид тооцно.

**21.6.** Хүүхдийг зохион байгуулалттайгаар тээвэрлэхдээ автобус буюу хүн тээвэрлэхэд зориулсан тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ. Зайлшгүй тохиолдолд ачааны автомашин (хүн тээвэрлэхэд зориулан тоногдсон)-аар тээвэрлэхийг зөвшөөрөх бөгөөд ингэхдээ насанд хүрсэн хоёроос доошгүй хүнийг тэвшний урд болон арын хэсэгт суулгаж харгалзуулан явбал зохино.

**21.7.** Хүн тээвэрлэхэд зориулан тоногдоогүй ачааны автомашины тэвшинд зөвхөн тухайн ачааг дагалдан буюу хүлээж авахаар яваа хүмүүсийг (тэвшний дээд ирмэгээс нам зассан суудалд) суулгаж явахыг зөвшөөрнө.

**21.8.** Хүн тээвэрлэхийг хориглох тохиолдол:

а/тээврийн хэрэгслийн техникийн тодорхойлолтоор тогтоосон тооноос олон хүн;  
*Тайлбар:* Энэ тоонд 12 нас хүрээгүй хүүхдийг тооцохгүй бөгөөд харин уг тээврийн хэрэгслийн бодит жин нь бүх жингээс хэтрэхгүй байвал зохино.

б/тээврийн хэрэгслийн хүн тээхэд зориулаагүй хэсэгт;

в/чиргүүлтэй тээврийн хэрэгслийн тэвшинд;

г/ачааны мотоциклийн тэвшинд;

д/12 нас хүрээгүй хүүхдийг мотоциклийн арын суудалд тусгай бэхлэлт хийлгүүгүйгээр;

е/3 хүртэлх насны хүүхдийг (харгалзах хүнгүй тохиолдолд) зориулалтын нэмэгдэл суудал, бөхлэгээ хийлгүүгүйгээр;

ж/согтуу хүнийг мотоциклоор буюу тээврийн хэрэгслийн задгай тэвшинд.

## 22. Ачаа тээвэрлэх

**22.1.** Ачааны жин болон тэнхлэгт ногдох ачааллын хэмжээ нь тухайн тээврийн хэрэгслийн техникийн тодорхойлолтоор тогтоосон хэмжээнээс хэтрэхгүй байвал зохино.

**22.2.** Ачааг дор дурдсан шаардлагыг хангахаар байрлуулж бэхлэсэн байна:

а/унаж чирэгдэхгүй, хөдөлгөөнд оролцогчдод саад, аюул учруулахгүй байх;

б/жолоочийн харах боломжийг хязгаарлахгүй байх;

в/тээврийн хэрэгслийн тогтворжилтыг алдагдуулахгүй, жолоодлагыг хүндрүүлэхгүй байх;

г/тээврийн хэрэгслийн гадна талын гэрэлтүүлэх хэрэгсэл, гэрэл ойлгуур, эргэх чиг заадаг гэрэл буюу гараар өгөх дохио, улсын дугаар, таних тэмдгийг халхлахгүй байх;

д/их хэмжээний дуу чимээ, загуй үнэр гаргахгүй, тоос шороо босгохгүй, зам ба орчныг бохирдуулахгүй байх.

**22.3.** Суурин газарт 22 цагаас 06 цагийн хооронд дуу чимээ гаргаж ачих, буулгахыг хориглоно.

**22.4.** Хүнд буюу овор ихтэй мөн аюултай ачаа тээвэрлэх автомашины жолооч нь тухайн ангиллын тээврийн хэрэгслийг гурваас дээш жил жолоодож дадлагажсан хүн байх бөгөөд хөдөлгөөнд оролцоходоо ойрын гэрлээ асааж явна.

**22.5.** Хүнд ачаа тээвэрлэх, мөн тээврийн хэрэгслийн ачаатой буюу ачаагүй өндөр нь 4 метр, өргөн нь 2.5 метр, урт нь 20 метр, ачаа нь тээврийн хэрэгслийн овроос арагшаа 2 метрээс илүү түүнчлэн хоёр буюу түүнээс олон чиргүүлтэй бол хөдөлгөөнд оролцоходоо Замын цагдаагийн албанаас зөвшөөрөл авна.

**22.6.** Тээврийн хэрэгслийн овроос уртаашаа 1 метр, өргөшөө 0.4 метрээс илүү гарсан ачааг тээвэрлэхдээ түүний илүү гарсан хэсэгт "Овор ихтэй ачаа" таних тэмдэг, харанхуй буюу үзэгдэлт хангалтгүй үед урд нь цагаан, ард нь улаан өнгийн гэрэл буюу гэрэл ойлгуур байрлуулна.

**22.7.** Аюултай ачаа, тэдгээрийн ариутгаагүй сав, багнаа, боодлыг тусгай журам, стандартын дагуу тээвэрлэх бөгөөд тээврийн хэрэгслийн урд болон ард "Аюултай ачаа" таних тэмдгийг байрлуулна.

**22.8.** Суудлын автомашин, мотоциклоор түүний овроос урт буюу өргөнөөрөө 0.5 м-ээрээс илүү гарсан ачаа тээвэрлэхийг хориглоно.

## 23. Унадаг дугуй, мопед, ердийн хөсгөөр зорчих, мал туухад тавих нэмэлт шаардлага

**23.1.** Унадаг дугуй буюу ердийн хөсгийг 14-өөс дээш, мопедыг 16-гаас дээш насны хүн жолоодож замын хөдөлгөөнд оролцохыг зөвшөөрнө.

**23.2.** Унадаг дугуйн тоормос, жолооч, конх нь бүрэн ажиллагаатай байхын дээр харанхуй буюу үзэгдэлт хангалтгүй үед хөдөлгөөнд оролцоходоо урд талдаа цагаан, ард талдаа улаан гэрэл буюу гэрэл ойлгуур, хоёр хажуу талдаа улаан буюу улбар шар өнгийн гэрэл ойлгууртай байвал зохино.

**23.3.** Ердийн хөсгийн тоног таталга нь бат бөх байхаас гадна харанхуй буюу үзэгдэлт хангалтгүй үед хөдөлгөөнд оролцоходоо урд талдаа цагаан, ард

талдаа улаан гэрэл ойлгуур (тус бүр хоёр ширхэг)-тай байвал зохино.

**23.4.** Унадаг дугуй, мопед нь (унадаг дугуйн зам байхгүй тохиолдолд) нэг эгнээнд хоёроос илүүгүйгээр зэрэгцэж, харин ердийн хөсөг зөвхөн нэг эгнээгээр гүйцэж түрүүлэх, тойрон гарах, зүүн гар тийш буюу буцаж эргэхийн тулд байр эзлэхээс бусад тохиолдолд зорчих хэсгийн хамгийн баруун гар талын эгнээгээр явна.

**23.5.** Унадаг дугуй, мопедын жолооч нь уулзвараас өөр хэсэгт унадаг дугуйн замаар зорчих хэсэгт нийлэхдээ тухайн замаар яваа тээврийн хэрэгсэл зам тавьж өгнө.

**23.6.** Унадаг дугуй, мопедын жолоочид дор дурдсан зүйлийг хориглоно:

а/жолооны гарыг сул тавих, дөрөөнд гишгэхгүй явах;

б/ачаа нь урт буюу өргөнөөрөө тээврийн хэрэгслийн овроос 0.5 метрээс илүү гарах, өндөр нь газраас 1.5 метрээс илүү байх;

в/зорчигчид зориулсан гишгүүр, суудалгүй тохиолдолд (түүнчлэн ачааны зориулалттай бол тэвшинд) хүн тээвэрлэх;

г/тэвс хүрээгүй хүүхдийг тусгай бэхлэгээ хийлгүйгээр тээвэрлэх;

д/согтуу хүн тээвэрлэх;

е/тээврийн хэрэгслийг чирэх, тээврийн хэрэгслээр чирүүлэх.

**23.7.** Суурин газрын гаднахь засмал, замаар малыг зорчих хэсгийн дагуу тууж явахыг хориглоно. Засмал замд 50 метрээс дотогш хариулгагүй мал байлгахыг хориглоно. Малыг зам хөндлөн буюу гүүрээр аль болох түргэн, бөөнөөр нь гаргах бөгөөд энэ үед ойртон ирж яваа тээврийн хэрэгсэл зам тавьж өгнө.

**23.8.** Төмөр замын гармаар ердийн хөсгийг гурваас илүүгүйгээр цувуулж гаргана. Мал тууж гаргахдаа аюулгүй байдлыг хангаж, богино хугацаанд амжиж гарахуйц тоогоор хэсэг хэсгээр цувуулж гаргана.

**23.9.** Ердийн хөсгөөр зорчих, мал туухад хориглох зүйл:

а/ердийн хөсгийн овроос урт буюу өргөнөөрөө 0.5 метрээс илүү гарсан ачаа тээвэрлэх;

б/зам дээр ердийн хөсөг буюу малаа хараа хяналтгүй орших;

в/согтуу байх.

## Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрмийн 1 дүгээр хавсралт

### ЗАМЫН ТЭМДЭГ, ТЭМДЭГЛЭЛ

#### Нэг. Анхааруулах тэмдэг

1. Анхааруулах тэмдэг нь замын аюул бүхий хэсэгт ойртож байгааг болон түүнд зохицсон арга хэмжээ авахыг жолоочид урьдчилан анхааруулна:

1.1 "Төмөр замын хаалтгүй гарам";

1.2 "Төмөр замын хаалтгүй гарам";

1.3.а,б "Төмөр замын гарам" -1.3.а тэмдэг нь нэг төмөр замтай, 1.3.б тэмдэг нь хоёр буюу түүнээс олон төмөр замтай хаалтгүй гарам байгааг;

- 1.4.а,б,в,г,д,е "Төмөр замын гарамд ойртоно" - төмөр замын гарам ойртож байгааг (суурин газрын гаднахь замд);
- 1.5 "Адил замын уулзвар";
- 1.6 "Тойрох хөдөлгөөнтэй уулзвар";
- 1.7 "Гэрэл дохионы зохицуулга" -хөдөлгөөн нь гэрэл дохиогоор зохицуулагддаг уулзвар буюу явган хүний гарц ойртож байгааг;
- 1.8.а,б "Огцом эргэлт" -замын эргэх радиус багатай буюу үзэгдэлт хязгаарлагдмал хэсэгт эргэх чиг ойртож байгааг;
- 1.9.а,б "Тахир зам" -замын огцом тахирласан хэсгүүд байгааг;
- 1.10 "Эгц уруу";
- 1.11 "Огцом өгсүүр";
- 1.12 "Халтиргаатай зам";
- 1.13 "Тэгш бие зам";
- 1.14 "Хайрга үсэрнэ" -тээврийн хэрэгсэл явахад дугуйн доороос нь хайрга, чулуу үсэрч болзошгүй замын хэсэг байгааг;
- 1.15.а,б,в "Зам нарийсна" -1.15.а тэмдэг нь зам хоёр талаас, 1.15.б тэмдэг нь зам баруун гар талаас, 1.15.в тэмдэг нь зам зүүн гар талаас нарийсахыг;
- 1.16 "Эсрэг хөдөлгөөн" -эсрэг хөдөлгөөнтэй зам (зорчих хэсэг)-д шилжихийг;
- 1.17 "Явган хүний гарц";
- 1.18 "Хүүхэд" -зорчих хэсэг дээр хүүхэд гэнэт гарч ирж болзошгүй замын хэсэг (сургууль, цэцэрлэгийн орчим гэх мэт) байгааг;
- 1.19 "Унадаг дугуйн зам нийлнэ";
- 1.20 "Засварын ажил" -хумүүс зам дээр ажил хийж байгааг;
- 1.21 "Мал тууж гарах газар";
- 1.22 "Ан амьтан" -мал, ан амьтан гарч ирж болзошгүй замын хэсэг байгааг;
- 1.23 "Чулууны нурангитай" -дээрээс шороо, чулуу нурж болзошгүй замын хэсэг байгааг;
- 1.24 "Хажуугийн салхитай";
- 1.25 "Оngoц доогуур ниснэ";
- 1.26 "Хонгил" -гэрэлтүүлэггүй хонгил буюу замын үзэгдэлт хязгаарлагдмал хэсэгт хонгил ойртож байгааг;
- 1.27 "Бусад аюултай газар" -энэ хэвсрэлтэд заасан тэмдгээр анхааруулаагүй бусад аюул бүхий замын хэсэг байгааг;
- 1.28.а,б,в "Эргэх чиг" -замын үзэгдэлт хязгаарлагдмал хэсэг дэх огцом эргэх чийг;
2. 1.1, 1.2, 1.5-1.27 тэмдгийг хөдөлгөөнд аюул учруулж болзошгүй замын хэсэг эхлэх газраас суурин газрын доторхи замд 50-100 метр, суурин газрын гаднахь замд 150-300 метрийн өмнө байрлуулна. Шаардлагатай тохиолдолд 6.1.а тэмдгийн хамт өөр зайд байрлуулж, үг нэмэлт

тэмдгээр аюул бүхий хэсгийн эхлэл хүртэлх зайг тодруулна.

Замын өгсүүр, уруу хэсгүүд залган үргэлжилж байгаа бол 1.10, 1.11 тэмдгийг аюул бүхий хэсгийн шууд өмнө байрлуулж болно.

Зорчих хэсэг дээр түр хугацааны ажил хийх тохиолдолд 1.20 тэмдгийг уг хэсгээс 10-15 метрийн өмнө байрлуулж болно.

3. 1.3.а,б тэмдгийг төмөр замын гармын шууд өмнө байрлуулна.

4. 1.4.а,б,в тэмдгийг зорчих хэсгийн баруун гар талд, 1.4.г,д,е тэмдгийг зүүн гар талд байрлуулах бөгөөд төмөр замын гармаас хамгийн их алслагдсан 1.1, 1.2 тэмдгийн доор 1.4.а, 1.4.г тэмдгийг, хамгийн ойр байрласан 1.1, 1.2 тэмдгийн доор 1.4.в, 1.4.е тэмдгийг, тэдгээрийн хооронд ижил зайд 1.4.б, 1.4.д тэмдгийг тус тус байрлуулна.

5. 1.28.а,б,в тэмдгийг аюул бүхий газар дээр байрлуулна.

## Хоёр. Хориглох тэмдэг

6. Хориглох тэмдэг нь замын хөдөлгөөнд тодорхой хязгаарлалт тогтоохоос гадна хязгаарлалтыг өөрчилнэ:

- 2.1 "Орох хориотой" - тээврийн хэрэгсэл тэмдгээс цааш орохыг хориглоно;
- 2.2 "Хөдөлгөөн хориотой" - тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хориглоно;
- 2.3 "Механикжсан тээврийн хэрэгслийн хөдөлгөөн хориотой";
- 2.4 "Ачааны автомашины хөдөлгөөн хориотой" - бүх жин нь 3.5 тонноос илүү (тэмдэгт бүх жинг заасан бол түүнээс илүү) ачааны автомашин, мөн трактор, өөрөө явдаг машин, механизмын хөдөлгөөнийг хориглоно. Энэ тэмдэг нь хүн тээвэрлэхэд зориулан тоногдсон ачааны автомашинд хамаарахгүй;
- 2.5 "Мотоциклийн хөдөлгөөн хориотой";
- 2.6 "Тракторын хөдөлгөөн хориотой" - бүх төрлийн трактор, өөрөө явдаг машин, механизмын хөдөлгөөнийг хориглоно;
- 2.7 "Чиргүүлтэй тээврийн хэрэгслийн хөдөлгөөн хориотой" - чиргүүл чирч яваа ачааны автомашин буюу трактор, мөн механикжсан тээврийн хэрэгсэл чирч яваа тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хориглоно;
- 2.8 "Ердийн хөсгөөр хөдөлгөөн хориотой" - ердийн хөсгөөр явах, мал туух буюу хөтөлж явахыг хориглоно;
- 2.9 "Унадаг дугуйн хөдөлгөөн хориотой" - унадаг дугуй болон мопедын хөдөлгөөнийг хориглоно;
- 2.10 "Явган зорчигчийн хөдөлгөөн хориотой";



- 2.11 "Жингийн хязгаарлал" - бодит жин нь тэмдэгт зааснаас илүү тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хориглоно;
- 2.12 "Тэнхлэгийн ачааллын хязгаарлал" - аль нэг тэнхлэгт ногдож буй ачааллын хэмжээ нь тэмдэгт зааснаас илүү тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хориглоно;
- 2.13 "Өндрийн хязгаарлал" - ачаатай буюу ачаагүй өндрийн хэмжээ нь тэмдэгт зааснаас илүү тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хориглоно;
- 2.14 "Өргөний хязгаарлал" - ачаатай буюу ачаагүй өргөний хэмжээ нь тэмдэгт зааснаас илүү тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хориглоно;
- 2.15 "Уртын хязгаарлал" - ачаатай буюу ачаагүй нийт бүрэлдэхүүний уртын хэмжээ нь тэмдэгт зааснаас илүү тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хориглоно;
- 2.16 "Хоорондын зайн доод хязгаарлал" - тээврийн хэрэгслүүдийн хоорондын зай нь тэмдэгт зааснаас бага явахыг хориглоно;
- 2.17 "Гааль" - гаалийн хяналтын бүсээр хяналт шалгалтад орохгүйгээр нэвтрэхийг хориглоно;
- 2.18.а "Баруун гар тийш эргэх хориотой";
- 2.18.б "Зүүн гар тийш эргэх хориотой";
- 2.19 "Буцаж эргэх хориотой";
- 2.20 "Түйцэж түрүүлэх хориотой" - цагт 30 км-ээс бага хурдтай яваагаас бусад тээврийн хэрэгслийг гүйцэж түрүүлэхийг хориглоно;
- 2.21 "Түйцэж түрүүлэх хорионы төгсгөл" - 2.20 тэмдгийн хүчинтэй хүрээ дууссаныг заана;
- 2.22 "Ачааны автомашинаар гүйцэж түрүүлэх хориотой" - бүх жин нь 3.5 тонноос их ачааны автомашинаар цагт 30 км-ээс бага хурдтай яваагаас бусад тээврийн хэрэгслийг гүйцэж түрүүлэхийг хориглоно. Мөн трактороор унадаг дугуй, ердийн хөсгөөс бусад тээврийн хэрэгслийг гүйцэж түрүүлэхийг хориглоно;
- 2.23 "Ачааны автомашинаар гүйцэж түрүүлэх хорионы төгсгөл" - 2.22 тэмдгийн хүчинтэй хүрээ дууссаныг заана;
- 2.24 "Хурдны дээд хязгаарлал" - хөдөлгөөний хурдыг (км/цаг) тэмдэгт зааснаас хэтрүүлэхийг хориглоно;
- 2.25 "Хурдны дээд хязгаарлалын төгсгөл" - 2.24 тэмдгийн хүчинтэй хүрээ дууссаныг заана;
- 2.26 "Дуут дохио хориотой" - зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэхээс бусад тохиолдолд дуут дохио өгөхийг хориглоно;
- 2.27 "Түр зогсох хориотой" - тээврийн хэрэгсэл түр буюу удаан зогсохыг хориглоно;
- 2.28 "Удаан зогсох хориотой" - тээврийн хэрэгсэл удаан зогсохыг хориглоно;
- 2.29 "Бүх хорионы төгсгөл" - 2.16, 2.20, 2.22, 2.24, 2.26-2.28 тэмдгүүдийн хүчинтэй хүрээ дууссаныг заана.
7. 2.2-2.9 тэмдгүүд нь уулзвар, гарцын өмнө байрласан бол тэдгээрийн хүчинтэй чигийг 6.3 а,б,в тэмдгээр тодорхойлно. Харин уулзвар, гарцын цаана байрласан бол тухайн зам (зорчих хэсэг)-д хамаарна.
8. 2.2, 2.3, 2.18.а,б, 2.19, 2.27 тэмдгүүд нь чиглэлийн тээврийн хэрэгсэлд хамаарахгүй.
9. 2.18.а,б тэмдэгт нь зорчих хэсгүүдийн зөвхөн эхний огтлолцолд хамаарна.
10. 2.16, 2.20, 2.22, 2.24, 2.26-2.28 тэмдгүүдийн үйлчлэх хүрээ нь байрласан газраасаа эхний уулзвар хүртэл, уулзваргүй замд суурин газраас гарах хүртэл хүчинтэй байна.
- 2.20, 2.22, 2.24 тэмдгүүдийн үйлчлэх хүрээг 2.21, 2.23, 2.25 харгалзах тэмдгүүдээр, 2.16, 2.20, 2.22, 2.24, 2.26 тэмдгүүдийн үйлчлэх хүрээг 6.2.а тэмдгийг хамт хэрэглэснээр, 2.24 тэмдгийн үйлчлэх хүрээг хурдны өөр хязгаарлал бүхий 2.24 тэмдгээр тус тус багасгаж болно. Мөн 2.27, 2.28 тэмдгүүдийн үйлчлэх хүрээг 6.2.б,д,е тэмдгийг хамт хэрэглэснээр буюу 6.2.в тэмдэгтэй хамт тавигдсан 2.27, 2.28 харгалзах тэмдгүүдээр, 2.27, 2.28 тэмдгүүдийн үйлчлэх хүрээг 7.4, 7.9 харгалзах тэмдэглэлүүдтэй хамт хэрэглэснээр (энэ тохиолдолд тэмдгийн үйлчлэх хүрээ нь тэмдэглэлийн уртаар тодорхойлогдоно), 2.16, 2.20, 2.22, 2.24, 2.26-2.28 тэмдгүүдийн үйлчлэх хүрээг 2.29 тэмдгээр тус тус багасгаж болно.
11. 2.10, 2.27, 2.28 тэмдгүүд нь замын байрласан талдаа хүчинтэй.

## Гурав. Дарааллын тэмдэг

12 Дарааллын тэмдэг нь уулзвар, зорчих хэсгийн огтлолцол буюу замын нарийссан хэсгээр нэвтрэх дарааллыг тогтоно:

- 3.1 "Гол зам" - зохицуулдаггүй уулзвар нэвтрэхэд давуу эрх олгоно;
- 3.2 "Гол замын төгсгөл" - 3.1 тэмдгийн хүчинтэй хүрээ дууссаныг заана;
- 3.3 а,б,в "Туслах зам нийлнэ";
- 3.3.а - туслах зам баруун болон зүүн гар талаас нийлнэ;
- 3.3.б - туслах зам баруун гар талаас нийлнэ;
- 3.3.в - туслах зам зүүн гар талаас нийлнэ;
- 3.4 "Зам тавьж өгнө" - хөдөлгөөний зохицуулгагүй үед жолооч хөндлөн замаар яваа (хэрэв 6,12 тэмдэгтэй хамт тавигдсан бол гол замаар яваа) тээврийн хэрэгсэлд зам тавьж өгнө;
- 3.5 "Зогсохгүй явах хориотой" - хөдөлгөөний зохицуулгагүй үед "Зогс-шугам" тэмдэглэлийн



өмнө буюу тэмдэглэлгүй бол зорчих хэсгийн огтлолцлын өмнө зогсолт хийхгүйгээр явахыг хориглоно. Жолооч хөндлөн замаар яваа (хэрэв 6.12 тэмдэгтэй хамт тавигдсан бол гол замаар яваа) тээврийн хэрэгсэлд зам тавьж өгнө.

Энэ тэмдгийг төмөр замын хаалтгүй гарам буюу замын зарим шаардлагатай хэсгийн өмнө байрлуулж болох бөгөөд энэ тохиолдолд жолооч "Зогс-шугам" тэмдэглэлийн өмнө буюу тэмдэглэлгүй үед уг тэмдгийн өмнө зогсолт хийнэ.

3.6 "Сөрөг хөдөлгөөнд зам тавьж өгнө" - өөдөөс яваа тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд саад болохоор байвал замын нарийссан хэсэгт орохыг хориглоно;

3.7 "Сөрөг хөдөлгөөнд давуу эрхтэй" - замын нарийссан хэсэгт эсрэг талаас яваа тээврийн хэрэгслээс түрүүлж нэвтрэх эрхтэй.

13. 3.1, 3.3.а,б,в тэмдэг бүхий замтай огтлолцсон туслах чанарын замд 3.4 буюу 3.5 тэмдгийг, мөн 3.7 тэмдэг байрласан нарийссан хэсгийн эсрэг талд 3.6 тэмдгийг тус тус байрлуулна.

## Дөрөв. Заах тэмдэг

14. Заах тэмдэг нь хөдөлгөөний зөвшөөрсөн чиг, хурдны зөвшөөрөгдөх доод хязгаар, мөн явган зорчигч болон тээврийн хэрэгслийн тодорхой төрлүүд явахыг зөвшөөрсөн замыг заана:

4.1.а,б,в,г,д,е - зөвхөн сум заасан чигт явахыг зөвшөөрнө. Зүүн гар тийш эргэхийг зөвшөөрсөн тэмдэг нь буцаж эргэхийг зөвшөөрнө;

4.2.а,б,в "Саадыг тойрч гарах чиг" - саадыг сум заасан талаар тойрч гарна. Энэ тэмдэг нь зөвхөн тухайн саадын орчинд хамаарна;

4.3 "Тойрох хөдөлгөөн" - сум заасан чигт хөдөлгөөнийг зөвшөөрнө;

4.4 "Суудлын автомашин явна" - суудлын автомашин, бүх жин нь 3.5 тонноос илүүгүй ачааны автомашин, автобус, мотоцикл болон чиглэлийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг зөвшөөрнө;

4.5 "Унадаг дугуйн зам" - зөвхөн унадаг дугуй болон мопедын хөдөлгөөнийг зөвшөөрнө, Явган хүний зам байхгүй бол явган зорчигч явахыг зөвшөөрнө;

4.6 "Явган хүний зам" - зөвхөн явган зорчигчийн хөдөлгөөнийг зөвшөөрнө;

4.7 "Хурдны доод хязгаарлал" - зөвхөн тэмдэгт заасан болон түүнээс илүү хурдтай (км/цаг) явахыг зөвшөөрнө;

4.8 "Хурдны доод хязгаарлалын төгсгөл" - 4.7 тэмдгийн хүчинтэй хүрээ дууссаныг заана.

15. Уулзвар, гарц буюу замын хэсгийн шууд өмнө байрласан 4.1.а-4.1.е тэмдэг нь зөвхөн тэр хэсэгтээ хамаарна.

4.1.а тэмдэг нь замын хэсгийн эхэнд (уулзварын цаана) байрласан бол эхний уулзвар хүртэл хүчинтэй байх бөгөөд гарцаар баруун гар тийш эргэхийг зөвшөөрнө.

16. 4.4 тэмдэг уулзвар, гарцын өмнө байрласан бол түүний хүчинтэй чигийг 6.3.а,б,в тэмдгээр тодорхойлно. Харин уулзвар, гарцын цаана байрласан бол тухайн зам (зорчих хэсэг)-д хамаарна.

## Тав. Мэдээлэх тэмдэг

17. Мэдээлэх тэмдэг нь замын нөхцөл байдлын онцлог, суурин газар болон бусад объектын байрлалыг харуулна:

5.1 "Тууш зам" - тууш замын хөдөлгөөний журмыг баримтлан явах зам;

5.2 "Тууш замын төгсгөл" - 5.1 тэмдгийн хүчинтэй хүрээ дууссаныг мэдээлнэ;

5.3 "Суурин газрын эхлэл" - суурин газрын доторхи хөдөлгөөний журмыг баримтлах суурин газрын эхлэл болон нэрийг мэдээлнэ;

5.4 "Суурин газрын төгсгөл" - 5.3 тэмдгээр тэмдэглэгдсэн суурин газраас гарч байгааг мэдээлнэ;

5.5 "Суурин газрын эхлэл" - суурин газрын доторхи хөдөлгөөний журмыг тухайн замд баримтлах шаардлагагүй суурин газрын эхлэл болон нэрийг мэдээлнэ;

5.6 "Суурин газрын төгсгөл" - 5.5 тэмдгээр тэмдэглэгдсэн суурин газраас гарч байгааг мэдээлнэ;

5.7 "Нэг чигийн хөдөлгөөн" - хөдөлгөөн нь нэг чигт зохион байгуулагдсан зам буюу зорчих хэсэг;

5.8 "Нэг чигийн хөдөлгөөний төгсгөл" - 5.7 тэмдгийн хүчинтэй хүрээ дууссаныг мэдээлнэ;

5.9.а "Зүүнээс баруун гар тийш нэг чигийн хөдөлгөөнтэй" - хөндлөн нийлсэн зам буюу зорчих хэсэг баруун гар тийш нэг чигийн хөдөлгөөнтэй;

5.9.б "Баруунаас зүүн гар тийш нэг чигийн хөдөлгөөнтэй" - хөндлөн нийлсэн зам буюу зорчих хэсэг зүүн гар тийш нэг чигийн хөдөлгөөнтэй;

5.10.а,б "Эгнээнээс явах хөдөлгөөний чиг" - 5.10.а тэмдэг нь уулзварын өмнө зорчих хэсгийн дээр буюу замын баруун гар талд байрлаж хөдөлгөөний тухайн чиг дэх эгнээний

тоог мэдээлэх бөгөөд эгнээ тус бүрээс уг уулзвараар нэвтрэх зөвшөөрсөн чигийг заана.

- 5.10.6 тэмдэг нь эгнээний харалдаа зорчих хэсгийн дээр байрлаж уг эгнээнээс тухайн уулзвараар нэвтрэх зөвшөөрсөн чигийг заана.
- 5.10.а,б тэмдгийн зүүн гар тийш эргэхийг зөвшөөрсөн сум бүхий захын (зүүн гар талын) эгнээнээс буцаж эргэхийг зөвшөөрнө.
- Тэмдгийг уулзварын шууд өмнө болон байр эзлэх боломж бүхий зайд байрлуулна.

Тэмдэг дэх сумны чигийг тухайн уулзвар дээрх хөдөлгөөний шаардлагатай чигт нийцүүлсэн байна;

- 5.11.а,б "Эгнээгээр явах хөдөлгөөний чиг" - тухайн зорчих хэсгийн эгнээний тоог болон эгнээ тус бүрийн хөдөлгөөний урсгалын чигийг мэдээлнэ. 5.11.а тэмдэгт аль нэг тэргийн хэрэгслийн хөдөлгөөнийг хориглосон тэмдэг дүрсэлсэн байвал тухайн эгнээгээр уг тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хориглоно.
- 5.11.а,б тэмдгийг уулзварын цаана буюу замын тухайн онцлог хэсгийн эхлэлд байрлуулна.

Тэмдэгт гурваас олон эгнээтэй (эсрэг хөдөлгөөнтэй) зорчих хэсгийн хөдөлгөөний чигийг заасан байж болно;

- 5.12.а,б "Эгнээний эхлэл" - нэг чигт яваа эгнээний тоо нэмэгдэж байгааг мэдээлнэ.
- 5.12.а тэмдэгт 4.7 "Хурдны доод хязгаарлал" тэмдгийг дүрсэлсэн байвал уг тэмдэгт зааснаас илүү хурдтай явах боломжгүй тээврийн хэрэгслийн жолооч хөдөлгөөнөө зөвхөн нэмэгдэж буй эгнээгээр үргэлжлүүлнэ;
- 5.13.а,б "Эгнээний төгсгөл" - нэг чигт яваа эгнээний тоо хасагдаж байгааг мэдээлнэ;
- 5.14 "Буцаж эргэх газар" - зүүн гар тийш эргэхийг хориглоно;
- 5.15 "Зогсоол";
- 5.16.а,б "Явган хүний гарц" - зорчих хэсгээр явган зорчигч хөндлөн гарах газрыг мэдээлнэ. Явган хүний гарц нь тэмдэглэлгүй бол 5.16.б тэмдгийг замын баруун гар талд гарцын шууд өмнө, 5.16.а тэмдгийг замын зүүн гар талд гарцын цаана байрлуулна;
- 5.17.а,б,в,г "Явган хүний гарам" - явган зорчигч зорчих хэсгийн доогуур ба дээгүүр хөндлөн гарах газрыг мэдээлнэ;
- 5.18 "Тохиромжтой хурд" - замын тухайн хэсэг дэх хөдөлгөөний хурдны тохиромжтой хэмжээг мэдээлэх бөгөөд үйлчлэх хүрээ нь дараагийн уулзвар хүртэл байна. Харин анхааруулах тэмдгийн хамт байрлуулсан бол

үйлчлэх хүрээ нь тухайн аюул бүхий хэсгийн үргэлжлэх зайгаар тодорхойлогдоно;

- 5.19.а,б,в "Мухар зам";
- 5.20.а,б,в "Ачааны автомашины хөдөлгөөний тохиромжтой чиг" - хөдөлгөөн нь аль нэг чигт хориглогдсон уулзвараар ачааны автомашин болон трактор, өөрөө явдаг машин, механизмын хөдөлгөөнөө үргэлжлүүлэхэд тохиромжтой чигийг мэдээлнэ;
- 5.21.а,б "Чигийн урьдчилсан заалт" - суурин газар буюу бусад объектод хүрэх чигийг урьдчилан мэдээлнэ. Тэмдэгт чиглэлийн дугаар (5.26.а тэмдгийн дүрс), тууш зам, нисэх буудлын болон тухайн объектын таних тэмдгийг дүрсэлсэн байж болно.
- 5.21.а тэмдгийн доод хэсэгт уг тэмдгээс тухайн уулзвар буюу хурд хасах эгнээний эхлэл хүртэлх зайг заана.
- 5.21.б тэмдэг нь хөдөлгөөний зөвхөн нэг чигийг мэдээлнэ;
- 5.22.а,б "Чигийн заалт" - суурин газар буюу бусад объектод хүрэх чигийг мэдээлнэ. Тэмдэгт тухайн суурин газар буюу объект хүртэлх зайг (километрээр) зааж болох бөгөөд тууш зам, нисэх буудлын болон тухайн объектын таних тэмдгийг дүрсэлсэн байж болно;
- 5.23 "Зайн заалт" - зам (чиглэл)-ын дагуухь суурин газар хүртэлх зайг (километрээр) мэдээлэх бөгөөд хамгийн ойр орших суурин газрын нэрийг дээд талд нь бичнэ;
- 5.24 "Объектын нэр" - гол мөрөн, нуур, түүхийн дурсгал газар зэрэг (суурин газраас бусад) объектын нэр;
- 5.25 "Километрийн заалт" - тухайн замын эхнээс тэмдэг хүртэлх зайг километрээр мэдээлнэ. Уг тэмдгийг километр бүрийн төгсгөлд байрлуулна;
- 5.26.а,б "Чиглэлийн дугаар" - 5.26.а тэмдэг нь зам (чиглэл)-ын дугаарыг мэдээлэх бөгөөд уг замд байрлана. 5.26.б тэмдэг нь зам (чиглэл)-ын дугаар болон чигийг урьдчилан мэдээлэх бөгөөд уулзварын өмнө байрлана;
- 5.27.а,б,в "Тойрч гарах бүдүүвч" - 5.27.а тэмдэг нь хөдөлгөөнд түр хориглолт тогтоосон замын хэсгийг тойрч гарах чиглэлийг мэдээлнэ.
- 5.27.б,в тэмдгүүд нь тусгаарлах зурвастай замын түр хориглолт тогтоосон зорчих хэсгийг тойрч гарах чиглэлийн эхлэл ба төгсгөлийг мэдээлнэ;
- 5.28.а,б,в "Тойрох чиг" - хөдөлгөөнд түр хориглолт тогтоосон замын хэсгийг тойрч гарах чигийг мэдээлнэ;

- 5.29 "Зогс-шугам" - гэрэл буюу зохицуулагчийн хориглосон дохиогоор тээврийн хэрэгслийн зогсох газрыг мэдээлнэ;
- 5.30 "Хөрөөлөл" - хөрөөллийн доторхи хөдөлгөөний журмыг баримтлах нутаг дэвсгэр;
- 5.31 "Хөрөөллийн төгсгөл" - 5.30 тэмдгээр тэмдэглэгдсэн нутаг дэвсгэрээс гэрч байгааг мэдээлнэ;
- 5.32 "Чиглэлийн тээврийн хэрэгслийн буудал";
- 5.33 "Таксийн зогсоол" - суудлын болон ахуй үйлчилгээний таксийн зогсоолын байршлыг мэдээлнэ;
- 5.34 "Хүн эмнэлэг";
- 5.35 "Шатахуун түгээгүүр";
- 5.36 "Техникийн үйлчилгээний газар";
- 5.37 "Автомашин угаалга";
- 5.38 "Телефон";
- 5.39 "Хоолны газар";
- 5.40 "Худаг ус";
- 5.41 "Зочид буудал";
- 5.42 "Жуулчны байр";
- 5.43 "Хот айл";
- 5.44 "Амрах газар";
- 5.45 "Замын цагдаагийн харуул".
18. Суурин газрын гадна байрласан 5.21.а,б, 5.22.а,б тэмдэгт тууш замаар явж хүрэх суурин газар буюу объектын нэрийг ногоон дэвсгэр дээр, бусад замаар явж хүрэх бол цэнхэр дэвсгэр дээр бичнэ. Суурин газрын дотор байрласан 5.21.а,б, 5.22.а,б тэмдэгт тууш замаар явж хүрэх суурин газар буюу объектын нэрийг ногоон дэвсгэр дээр, уг суурин газраас гэрч бусад замаар явж хүрэх бол цэнхэр дэвсгэр дээр, тухайн суурин газрын дотор орших объектын нэрийг цагаан дэвсгэр дээр тус тус бичнэ.
19. 5.5, 5.6, 5.23-5.26.б тэмдгүүд нь тууш замд байрласан бол ногоон, бусад замд байрласан бол цэнхэр өнгийн дэвсгэртэй байна.
20. 5.21.а, 5.27.а тэмдэгт хөдөлгөөний горим буюу чиглэлийн онцлогийг харуулах зорилгоор бусад тэмдгийн дүрсийг байрлуулсан байж болно.
- Зургаа. Нэмэлт тэмдэг**
21. Нэмэлт тэмдгийг бусад тэмдэгтэй хамт тавьж тэдгээрийн утгыг тодруулна:
- 6.1.а,б,в,г "Объект хүртэлх зай":
- 6.1.а - тэмдгээс замын дагуухь аюул бүхий хэсэг буюу хөдөлгөөнд хязгаарлалт тогтоосон хэсэг, эсвэл объект хүртэлх зайг заана,
- 6.1.б - суурин газрын гаднахь замд 3.5 тэмдгийг уулзварын шууд өмнө байрлуулсан үед 3.4 тэмдгээс уг уулзвар хүртэлх зайг заана.
- 6.1.в,г - замаас зайдуу байрласан объект хүртэлх зайг заана;
- 6.2.а,б,в,г,д,е "Үйлчлэх хүрээ" - 6.2.а тэмдэг нь 1.9-1.14, 1.18, 1.20-1.17 тэмдгээр анхааруулсан аюул бүхий хэсгийн үргэлжлэх зайг, 2.16, 2.20, 2.22, 2.24, 2.26 буюу мөн 5.15, 5.18 тэмдгүүдийн үйлчлэх хүрээг заана.
- 6.2.б,в,г,д,е тэмдэг нь 2.27, 2.28 тэмдгийн үйлчлэх хүрээг заана;
- 6.3.а,б,в "Үйлчлэх чиг" - уулзвар, гарцын өмнө байрласан тэмдгийн үйлчлэх чигийг заана;
- 6.4.а,б,в,г,д,е,ж "Тээврийн хэрэгслийн төрөл" - тухайн тэмдэг ямар төрлийн тээврийн хэрэгсэлд хамаарахыг заана:
- 6.4.а - бүх жин нь 3.5 тонноос их ачааны автомашин;
- 6.4.б - чиргүүлтэй бүх төрлийн тээврийн хэрэгсэл;
- 6.4.в - суудлын автомашин буюу бүх жин нь 3.5 тонноос илүүгүй ачааны автомашин;
- 6.4.г - жолоочоос гадна 8-аас илүү хүний суудалтай хүн тээвэрлэхэд зориулсан автомашин;
- 6.4.д - трактор, өөрөө явдаг машин, механизм;
- 6.4.е - мотоцикль;
- 6.4.ж - унадаг дугуй, мопед;
- 6.5.а,б,в,г,д,е,ж "Үйлчлэх хугацаа" - тэмдгийн хүчинтэй байх хугацааг заана:
- 6.5.а - бямба, ням гариг буюу баяр, амралтын өдөр;
- 6.5.б - ажлын өдөр;
- 6.5.в - гариг;
- 6.5.г - цаг;
- 6.5.д,е,ж - өдөр (гариг) ба цаг;
- 6.6.а,б,в,г,д,е,ж,з,и "Тээврийн хэрэгслийг зогсоолд тавих хэлбэр" - 6.6.а тэмдэг нь 5.15 тэмдэг бүхий зогсоолд бүх төрлийн тээврийн хэрэгслийг явган хүний замын хашлаганд шахаж зорчих хэсэг дээр зогсоохыг, 6.6.б - 6.6.и тэмдэг нь 5.15 тэмдэг бүхий зогсоолд суудлын автомашин, мотоциклийг зорчих хэсэгтэй хиллэсэн явган хүний зам дээр буюу түүний хашлагыг унуулж (шахаж) зогсоохыг заана;
- 6.7 "Хөдөлгүүрийг унтрааж зогсоох" - 5.15, 5.44 тэмдэг бүхий зогсоолд тээврийн хэрэгслийн хөдөлгүүрийг унтрааж зогсоохыг заана;
- 6.8 "Төлбөртэй үйлчилгээ" - үйлчилгээ нь зөвхөн бэлэн мөнгөөр тооцоо хийдэг болохыг заана;
- 6.9 "Удаан зогсохыг зөвшөөрөх хугацаа" - 5.15 тэмдэг бүхий зогсоолд тээврийн хэрэгслийн удаан зогсохыг зөвшөөрөх хугацааны дээд хэмжээг заана;

- 6.10 "Автомашинд үзлэг хийх газар" - 5.15, 5.44 тэмдэг бүхий зогсоолын талбай нь мөрдмөл тавцан буюу үзлэгийн сувагтай болохыг заана;
- 6.11 "Тахир дутуу хүн" - 5.15 тэмдэг бүхий зогсоол нь зөвхөн "Тахир дутуу хүн" таних тэмдэг бүхий тээврийн хэрэгсэлд хамаарахыг заана;
- 6.12 "Гол замын чиг" - уулзвар дээрх гол замын чигийг заана. 3.1, 3.4, 3.5 тэмдэгтэй хамт байрлуулна;
- 6.13 "Бүх жингийн хязгаарлал" - бүх жин нь тэмдэгт зааснаас илүү тээврийн хэрэгсэлд тухайн тэмдэгт хамаарахыг заана;
- 6.14 "Эгнээ" - гэрлэн дохио, тэмдгийн үйлчлэх эгнээг заана;
- 6.15 "Хараагүй хүн" - хараагүй хүмүүс зам хөндлөн гарах гарцыг заах бөгөөд 1.17, 5.16, а,б тэмдэгтэй хамт байрлуулна;
- 6.16, а,б "Зорчих хэсгийн гадаргуугийн байдал" - 6.16,а тэмдэг нь зорчих хэсгийн гадаргуу нойтон үед, 6.16,б тэмдэг нь цастай буюу мөстсөн үед тухайн тэмдэг хүчинтэй байхыг заана.
22. Замын нөхцөл, байдлыг илүү мэдэхэд нь жолоочид туслах зорилгоор ямар нэг хязгаарлалт тогтоогоогүй бусад мэдээлэх болон нэмэлт тэмдэг хэрэглэж болно. Ийм тэмдгийг цэнхэр дэвсгэр дээр цагаан өнгөөр хийнэ.
23. Байнгын тэмдгээс зөрүү утга бүхий түр тэмдэг байрлуулсан байвал түр тэмдгийг баримтална. Түр тэмдэг нь суурьтай (зөврийн) байна.
- Долоо. Хэвтээ тэмдэглэл**
24. Замын хөдөлгөөнд тодорхой горим, журам тогтоох зорилгоор зорчих хэсэг буюу түүний хашлага дээр хийсэн шугам, сум, бичлэг зэрэг нь хэвтээ тэмдэглэлд хамаарна. Хэвтээ тэмдэглэлийг дангаар нь буюу тэмдэг, гэрлэн дохиотой хослуулан хэрэглэнэ.
- Шар өнгийн 7.4, 7.9, 7.17 тэмдэглэлээс бусад хэвтээ тэмдэглэл нь цагаан өнгөтэй байна.
- 7.1 - хоёр буюу гурван эгнээгээр зорчдог замд хөдөлгөөний эсрэг урсгалыг тусгаарлах, мөн замын аюул бүхий хэсэгт эгнээний хилийг заах, түүнчлэн зорчих хэсгийн орохыг хориглосон хэсгийг хязгаарлах буюу тээврийн хэрэгслийн зогсоолын хилийг тэмдэглэнэ;
- 7.2 (үргэлжилсэн өргөн шугам) - зорчих хэсгийн захыг тэмдэглэнэ;
- 7.3 - дөрөв буюу түүнээс олон эгнээгээр зорчдог замд хөдөлгөөний эсрэг урсгалыг тусгаарлана;
- 7.4 - түр зогсохыг хориглосон газрыг тэмдэглэх бөгөөд дангаар нь буюу 2.27 тэмдэгтэй хамтруулан зорчих хэсгийн зах болон хашлага дээр хийнэ;
- 7.5 (тасархай шугамын нэг зураасын урт нь тэдгээрийн хоорондын зайнаас гурав дахин бага) - хоёр буюу гурван эгнээгээр зорчдог замд хөдөлгөөний эсрэг урсгалыг тусгаарлах, нэг чигт хоёр буюу түүнээс олон эгнээгээр зорчдог замд эгнээний хилийг заана;
- 7.6 (тасархай шугамын нэг зураасын урт нь тэдгээрийн хоорондын зайнаас гурав дахин их) - хөдөлгөөний дагуу буюу эсрэг урсгалыг тусгаарласан 7.1, 7.10 тэмдэглэлд ойртож байгааг анхааруулна;
- 7.7 (тасархай шугамын нэг зураасын урт нь тэдгээрийн хоорондын зайтай тэнцүү) - уулзвар дээрх хөдөлгөөний эгнээг тэмдэглэнэ;
- 7.8 ("Зорчих өргөн шугам" - хурд авах буюу хурд хасах эгнээний хилийг заана);
- 7.9 - удаан зогсохыг хориглосон газрыг тэмдэглэх бөгөөд дангаар нь буюу 2.28 тэмдэгтэй хамтруулан зорчих хэсгийн зах болон хашлага дээр хийнэ, . . . . .
- 7.10 - хөдөлгөөний дагуу буюу эсрэг урсгалыг тусгаарлана. Зөвхөн аль нэгээс нь байр эзлэхийг зөвшөөрсөн зэрэгцээ эгнээүүдийн хоорондох хил, зөвхөн аль нэг талын урсгалаас эсрэг тал руу ороход зориулсан газар, зөвхөн аль нэг талаас нь орох, гарахыг зөвшөөрсөн гарцыг тэмдэглэнэ;
- 7.11 "Зогс-шугам" - гэрэл буюу зохицуулагчийн хориглосон дохио эсвэл 3.5 тэмдгийн заалтыг биелүүлэхийн тулд тээврийн хэрэгсэл зогсох газрыг тэмдэглэнэ;
- 7.12 - хөндлөн замаар яваа тээврийн хэрэгсэлд зам тавьж өгөх (3.4 тэмдгийн заалтыг биелүүлэх)-ийн тулд зогсох газрыг тэмдэглэнэ;
- 7.13,а,б "Явган хүний гарц" - зорчих хэсгээр явган зорчигч хөндлөн гарах газрыг тэмдэглэнэ;
- 7.13,а - явган хүний зохицуулагчгүй гарцын тэмдэглэл (энэ тэмдэглэлд явган зорчигчийн хөдөлгөөний чигийг сумаар заасан байж болно)
- 7.13,б - явган хүний зохицуулагч гарцын тэмдэглэл;
- 7.14 "Аюулгүйн зурвас" - гэрэл буюу зохицуулагчийн дохио өөрчлөгдөх үед зорчих



хэсгийг хөндлөн гарч амжаагүй явган зорчигч дараагийн зөвшөөрөх дохиог хүлээх газрыг тэмдэглэнэ. 7.13.6 тэмдэглэлтэй хамт хэрэглэнэ;

7.15 - унадаг дугуйн зам зорчих хэсэгтэй огтлолцсон хэсгийг тэмдэглэнэ;

7.16.а,б,в - хөдөлгөөний урсгал нийлэх буюу салах газарт үлдэх зай, чигийг тэмдэглэнэ;

7.16 а - эсрэг урсгалыг тусгаарласан зай

7.16 б - нэг чигийн урсгал салж байгаа хэсгийг тусгаарласан зай

7.16 в - нэг чигийн урсгал нийлж байгаа хэсгийг тусгаарласан зай;

7.17 - чиглэлийн тээврийн хэрэгслийн буудал, таксийн зогсоолыг тэмдэглэнэ. 5.32 буюу 5.33 тэмдэгтэй хамт хэрэглэнэ;

7.18 "Чиг заагч сум" - тухайн эгнээнээс уугуувар нэвтрэх зөвшөөрсөн чигийг заана. Дангаар нь буюу 5.10 а,б тэмдэгтэй хамт хэрэглэнэ. Зүүн гар тийш эргэхийг зөвшөөрсөн сум бүхий захын (зүүн гар талын) эгнээнээс буцаж эргэхийг зөвшөөрнө;

7.19 "Чиглүүлэгч сум" - зорчих хэсэг нарийсаж (тухайн чигт эгнээний тоо цөөрч) байгааг буюу эсрэг урсгалыг тусгаарласан 7.1, 7.10 тэмдэглэлд ойртож байгааг анхааруулна. 1.15.а,б,в тэмдэгтэй хамт хэрэглэж болно;

7.20 - нь 7.12 тэмдэглэлд ойртож байгааг анхааруулна. Гурвалжны орой нь хөдөлгөөний урсгалын эсрэг чиглэсэн байна;

7.21 "Зогс-бичлэг" - 3.5 тэмдэгтэй хамт хэрэглэсэн 7.11 тэмдэглэлд ойртож байгааг анхааруулна;

7.22 - зам (чиглэл)-ын дугаарыг тэмдэглэх бөгөөд дангаар нь буюу 5.26.а,б тэмдэгтэй хамт хэрэглэнэ.

25. 7.2 тэмдэглэлийг жолооч зогсохын тулд давахаас бусад тохиолдолд 7.1-7.3, 7.14, 7.16.а,б,в тэмдэглэлүүдийг давахыг хориглоно.

7.5-7.8 тэмдэглэлийг аль ч талаас нь давахыг зөвшөөрөх бөгөөд харин дээгүүр нь унуулж явахыг хориглоно.

7.10 тэмдэглэлийг зөвхөн тасархай шугамтай талаас нь давахыг зөвшөөрнө. Харин гүйцэж түрүүлэх буюу тойрон гарах үйлдэл хийж дуусах үедээ үргэлжилсэн шугамтай талаас нь давахыг хориглохгүй

26. 7.4, 7.9 болон зогсоолын хилийг тэмдэглэсэн 7.1 тэмдэглэлийн үзэгдэлтийг сайжруулах (хэмжээг тодотгох) зорилгоор шугамын эхлэл, төгсгөлд хөндлөн богино зураас татаж болно.

27. Зорчих хэсэгт хөдөлгөөний нөхцөл, байдлыг баримжаалахад нь жолоочид туслах зорилгоор ямар нэг хязгаарлалт тогтоогоогүй тэмдэглэл хийж болно.

28. Замын тухайн хэсэгт байрлуулсан тэмдэг ба тэмдэглэлийн утга хоорондоо зөрж байвал тэмдгийн заалтыг баримтална.

## Найм. Босоо тэмдэглэл

29. Замын байгууламж болон элементүүдийн овор хэмжээг тодотгох, зорчих баримжаа олгох зорилгоор замын хашлага, шон, хашилт, бусад байгууламж дээр хийгдсэн хар ба цагаан хосолсон шугам, зураас зэрэг нь босоо тэмдэглэлд хамаарна.

8.1 - тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд аюул учруулж болзошгүй замын байгууламжийн босоо хэсэг (гүүрийн тулгуур, усны хоолой, хонгилын нүүрэн тал гэх мэт)-ийг тэмдэглэнэ;

8.2 - гүүр, хонгил зэрэг замын байгууламжийн доогуур гарах үед уг байгууламжид шүргэж болзошгүй хэсгийг тэмдэглэнэ;

8.3 - тусгаарлах зурвас буюу аюулгүйн арал дээр байрласан тэмдгийн дугуй суурийг тэмдэглэнэ;

8.4 - замын дагуу байрласан чиглүүлэгч шон, хашилтын тулгуур зэргийг тэмдэглэнэ;

8.5 - эргэх радиус багатай, эгц уруу, нурж болзошгүй зэрэг аюул бүхий хэсэг дэх замын хашилтын хажуу гадаргууг тэмдэглэнэ;

8.6 - замын бусад хэсэг дэх хашилтын хажуу гадаргууг тэмдэглэнэ;

8.7 - замын аюул бүхий хэсгийн хашлагыг тэмдэглэнэ.

## Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрмийн 2 дугаар хавсралт

### ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН АШИГЛАХЫГ ХОРИГЛОХ ЭВДРЭЛ, ГЭМТЭЛ, ТЕХНИКИЙН ЗӨРЧИЛ

Энэ хавсралтад заагдсан эвдрэл, гэмтэл, техникийн зөрчилтэй автомашин, чиргүүл, мотоцикл, мопед, трактор болон өөрөө явдаг машин, механизмыг ашиглахыг хориглоно:

#### 1.Тоормосны систем

1.1. Ажлын тоормосны системийн идэвхжил нь туршилтын үед доорхи шаардлагыг хангаж чадахгүй байх:



Тээврийн хэрэгслийн төрөл	Тоормосны зам (метр), ихгүй байх		Удаашралт (м/сек <sup>2</sup> ), багагүй байх	
	чиргүүлгүй	чиргүүлтэй	чиргүүлгүй	чиргүүлтэй
Суудлын автомашин буюу түүний ачаа тээвэрлэхэд зориулсан төрөл	12.2	13.6	6.8	5.9
Бүх жин нь 5 тонн хүртэлх автобус (5 тонн орно)	13.6	15.2	6.8	5.7
Бүх жин нь 5 тонноос их автобус	16.8	18.4	5.7	5.5
Бүх жин нь 3.5 тонн хүртэлх ачааны автомашин (3.5 тонн орно)	15.1	17.7	5.7	4.6
Бүх жин нь 3.5-12 тонн хүртэлх ачааны автомашин (12 тонн орно)	17.3	18.8	5.7	5.5
Бүх жин нь 12 тонноос их ачааны автомашин	16	18.4	6.2	5.5
Хоёр дугуйтай мотоцикль, мопед	7.5	-	5.5	-
Шаахайтай мотоцикль	8.2	-	5	-

**Тайлбар:** Туршилтыг тэгш, хуурай, хатуу хучилттай зам дээр автомашин, автобусыг цагт 40 км, мотоцикль, мопедыг цагт 30 км хурдтай яваа үед жолооч тоормосны дөрвөн дээр нэг удаа гишгэх замаар гүйцэтгэнэ. Туршилтын үед тээврийн хэрэгслийн бодит жин нь түүний бүх жингээс хэтрээгүй байвал зохино.

Тоормосны системийн идэвхжиллийг тусгай зориулалтын тоног төхөөрөмж дээр шалгаж болно.

1.2. Шингэн дамжуулгатай тоормосны системийн битүүмж алдагдсан;

1.3. Хийн буюу хий-шингэн дамжуулгатай тоормосны системийн даралт хэмжүүр ажиллахгүй болсон;

1.4. Хийн буюу хий-шингэн дамжуулгатай тоормосны системийн битүүмж алдагдсанаас (хөдөлгүүрийг унтраасны дараа) хийн бүрэн даралтын хэмжээ 15 минутын хугацаанд 0.05 МПа (0.5 кг/см<sup>2</sup>)-аар буюу түүнээс илүү хэмжээгээр буурсан;

Тээврийн хэрэгслийн төрөл	Жолооны хүрдний сул эргэлт (градус)
Суудлын автомашин буюу түүний явах ангид суурилуулсан төрөл	10
Автобус, троллейбус	20
Ачааны автомашин	25

2.4. Жолооны механизмын эд ангиудын хийцийг өөрчилсөн.

### 3. Дугуй

3.1. Дугуйн хээний гүн нь газарт тулах хэсгээрээ суудлын автомашинд 1.6 мм, ачааны автомашинд 1 мм, автобус, троллейбусанд 2 мм, мотоцикль, мопедонд 0.8 мм-ээс бага болсон;

1.5. Зогсоолын тоормос дор дурдсан өгсүүр буюу уруу газарт тээврийн хэрэгслийг тогтоон барьж чадахгүй болсон:

- 16 %-д бүрэн ачаалагдсан тээврийн хэрэгслийг;
- 23 %-д ачаагүй суудлын автомашин, автобусыг;
- 31 %-д ачаагүй ачааны автомашиныг.

**Тайлбар:** Зогсоолын тоормосны идэвхжиллийг шалгах үедээ хөдөлгүүрийн ачааллыг хүч дамжуулах ангиас салгасан байвал зохино.

1.6. Тоормосны системийн эд ангиудын хийцийг өөрчилсөн.

### 2. Жолооны механизм

2.1. Жолооны механизмын бэхлэлтээ задэрсэн, холбоосны сул хөдөлгөөн ихэссэн;

2.2. Үйлдвэрээс хийгдсэн хүчлүүр (мотоциклийн хувьд зөөллүүр) ажиллахгүй буюу байхгүй болсон;

2.3. Жолооны хүрдний сул эргэлтийн хэмжээ дор дурдсанаас илүү болсон;

**Тайлбар:** Чиргүүлийн дугуйн хээний гүн нь чирэгчийн дугуйн хээний тогтоосон хэмжээтэй адил байна.

3.2. Дугуй нэвт цоорсон, утаснууд нь тасарсан;

3.3. Дугуйн хэмжээ, даац нь тээврийн хэрэгслийн тухайн төрөлд тохироогүй;

3.4. Дугуйн булны бэхэлгээ сул, найдваргүй бэхлэгдсэн, дугуйн цоожлох цагираг гэмтсэн, буруу тавигдсан;

3.5. Нэг тэнхлэгт өөр марк, хээтэй дугуй тавьсан.

#### 4. Хөдөлгүүр, хүч дамжуулах анги

4.1. Хөдөлгүүрийн утаа, түүний найрлага дахь хорт кийн хэмжээ улсын стандартад заасан хязгаараас хэтэрсэн;

4.2. Тэжээлийн системийн битүүмж алдагдсан, шатах, тослох материал гоожсон;

4.3. Яндан, дуу намсгуур ажиллахгүй буюу байхгүй болсон;

4.4. Хурдны хайрцгийн араа хүндрэлтэй залгагддаг, өөрөө салдаг;

4.5. Кардан гол цавтай, савлагаатай.

#### 5. Гэрэлтүүлэх хэрэгсэл

5.1. Гэрлийн тоо, хэлбэр, өнгө, байрлал, ажиллах горим нь тухайн тээврийн хэрэгслийн хийцэд тохироогүй;

5.2. Хол, ойрын гэрлийн тусгалын тохироо алдагдсан;

5.3. Гадна талын гэрэлтүүлэх хэрэгсэл, эргэх дохио бохирдсон, асахгүй буюу бүдэг асдаг;

5.4. Үйлдвэрээс тавьсан гэрэл ойлгуур байхгүй буюу бохирдсон;

5.5. Гэрэлтүүлэг, дохиоллын системийн унтраалга, шилжүүлүүр гэмтсэн.

*Тайлбар: Тээврийн хэрэгслийн урд талд улаан, ар талд цагаан өнгийн гэрэл (ухрах арааны болон улсын дугаарын гэрлээс бусад) буюу гэрэл ойлгуур тавихыг хориглоно.*

#### 6. Бусад төхөөрөмж

6.1. Хурд хэмжүүр ажиллахгүй болсон;

6.2. Дуут дохио ажиллахгүй болсон;

6.3. Шил арчуур, цан үлээгүүр ажиллахгүй болсон;

6.4. Хаалга, тэвшний цоож түгжээ задэрсэн, гүйцэд хаагдаж, нээгдэхгүй болсон;

6.5. Ар талаа харах толь, салхины шил, нарны хаалтгүй болсон;

6.6. Үйлдвэрээс тавьсан хамгаалах бүс, суудлын дэр байхгүй буюу шаардлага хангахгүй болсон;

6.7. Мотоцикль, мопедод зориулалтын гишгүүр, зорчигчийн барих бариул байхгүй болсон;

6.8. Чиргүүлийн холбоос эвдэрсэн, хамгаалалтын гинжин таталга байхгүй буюу гэмтсэн;

6.9. Тэвшний шал цөмөрсөн, бүхээг, тэвшний гадна хэсэг их хэмжээгээр эвдэрсэн буюу өнгө үзэмж нь илт муудсан;

6.10. Автобус, троллейбус, суудлын буюу ачааны автомашин, дугуйт тракторт эмийн сан, гал унтраагуур, ослын зогсолтын тэмдэг байхгүй;

6.11. Шаарын хаалтгүй;

6.12. Бүхээгний шилэн дээр юм бичсэн, зураг наасан, хөшиг татсан, цацаг унжуулсан, салхины шил нь их хэмжээгээр цуурсан, бохирдсон зэргээс жолоочийн харах боломжийг хязгаарласан;

*Тайлбар: Салхины шилний дээд хэсэгт өнгөт, тунгалаг хальс нааж болно. Мөн гэрэл бууруулагчтай (толины хэсгээс бусад хэсэгт) шил ашиглаж болох бөгөөд шилний гэрэл нэвтрүүлэх чадвар нь салхины шилэнд 75%, урд хаалганы шилэнд 70%, бусад шилэнд 60%-иас багагүй байвал зохино.*

6.13. Автобус, троллейбусны хаалга нээх, хаах хэрэгсэл ажиллахгүй болсон, хаалгаа харах толигүй буюу толио буруу тавьсан;

6.14. Түлшний түвшин заагуур ажиллахгүй болсон;

6.15. Бүх жин нь 3.5 тонноос их ачааны автомашин буюу бүх жин нь 5 тонноос их автобусанд ивүүр байхгүй (хоёроос цөөнгүй).

#### Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрмийн 3 дугаар хавсралт

#### ИРГЭН, АЛБАН ТУШААЛТНЫ ҮҮРЭГ

1. Монгол Улсын нутаг дэвсгэрт ашиглагдаж байгаа механикжсан тээврийн хэрэгсэл (троллейбусаас бусад) болон чиргүүл нь Замын цагдаагийн албанаас олгосон улсын дугаарын тэмдэгтэй байхаас гадна улсын дугаарын тоо, үсгийг

ачааны автомашин, чиргүүл (суудлын автомашины чиргүүлээс бусад)-ийн хоёр хажуу болон ар талд, автобус (бага орын автобусаас бусад)-ны ар талд үндсэн өнгөөс ялгарах өнгөөр бичсэн байна.

Үсгийн өндөр нь 200 мм, өргөн нь 80 мм, зураасны өргөн нь 20 мм, тооны өндөр нь 300 мм, өргөн нь 120 мм, зураасны өргөн нь 30 мм байна.

2. Тээврийн хэрэгслийн таних тэмдгийг хэрэглэх тохиолдол:

"Чиргүүлтэй тээврийн хэрэгсэл" - хоорондоо 150-300 мм-ийн зайтай байрлах улбар шар өнгийн гурван гэрэл. Энэ таних тэмдгийг чиргүүлтэй ачааны автомашин, дугуйт трактор, угсраа автобус буюу троллейбусны бүхээг дээр хөндлөн байрлуулна;

"Хүүхэд тээвэрлэж яваа тээврийн хэрэгсэл" - улаан хүрээтэй, шар өнгийн дэвсгэр бүхий дөрвөлжин (нэг талын урт нь 250 мм-ээс багагүй, хүрээний өргөн нь нэг талын хэмжээний 1/10-тэй тэнцүү) дотор хар өнгөөр 1.18 тэмдгийн доторхи дүрсийг зурна. Хүүхдийг зохион байгуулалттайгаар тээвэрлэх автобус, ачааны автомашины урд болон ард энэ таних тэмдгийг байрлуулна;

"Сургалтын тээврийн хэрэгсэл" - улаан хүрээтэй, цагаан өнгийн дэвсгэр бүхий тэнцүү талт гурвалжин (нэг талын урт нь 200 мм-ээс багагүй, хүрээний өргөн нь гурвалжны талын 1/10-тэй тэнцүү) дотор "С" үсгийг хараар бичнэ. Жолоодлогын дадлага хийх тээврийн хэрэгслийн урд болон ард энэ таних тэмдгийг байрлуулна.

Жич: Ар, өвөр талдаа дүрслэгдсэн тэмдгийг суудлын автомашины бүхээг дээр байрлуулж болно;

"Хурдны хягаар" - улаан хүрээтэй, цагаан өнгийн дэвсгэр бүхий дугуй (голч нь 160 мм-ээс багагүй, хүрээний өргөн нь голчийн 1/10-тэй тэнцүү) дотор зөвшөөрөгдсөн хурдны дээд хэмжээг хараар бичнэ. Хүүхдийг зохион байгуулалттайгаар тээвэрлэх, хүнд буюу овор ихтэй, мөн аюултай ачаа тээвэрлэх, түүнчлэн техникийн дээд хурд нь замын хөдөлгөөний дүрмийн 9.3-т заасан хэмжээнд хүрэхгүй механикжсан тээврийн хэрэгслийн зүүн ард энэ таних тэмдгийг тавьж анхааруулж болно;

"Аюултай ачаа" - 700х300 мм хэмжээтэй (15 мм өргөн хар хүрээтэй) тэгш өнцөгтийн баруун талын 400 мм урттай хэсгийг улбар шараар, үлдсэн зүүн талын хэсгийг цагаанаар будна. Тэмдэгт тээвэрлэж яваа ачааны онцлогийг тодорхойлсон тэмдэглэл хийнэ.

"Овор ихтэй ачаа" - улаан, цагаан ташуу зураас хосолсон (зураасын өргөн нь 50 мм) 400х400 мм хэмжээтэй байна;

"Урт тээврийн хэрэгсэл" - улаан хүрээтэй (өргөн нь 40 мм), шар өнгийн дэвсгэр бүхий 1200х300 мм хэмжээтэй тэгш өнцөгт дотор тухайн тээврийн хэрэгслийн бүрэлдэхүүний нийт уртын хэмжээг хараар бичнэ. Ачаатай буюу ачаагүй нийт урт нь 20 метрээс илүү, мөн хоёр буюу түүнээс олон чиргүүлтэй тээврийн хэрэгслийн ард энэ таних тэмдгийг байрлуулна. Энэ хэмжээний тэмдгийг байрлуулах боломжгүй бол 600х300 мм хэмжээтэй

хоёр тэмдгийг тээврийн хэрэгслийн ард тэгш хэмтэйгээр байрлуулж болно;

"Тахир дутуу хүн" - шар дэвсгэр бүхий дөрвөлжин (нэг талын урт нь 150 мм) дотор хар өнгөөр 6.11 тэмдгийн доторхи дүрсийг зурна. Тахир дутуу хүн жолоодож явах буюу тахир дутуу хүн тээвэрлэж явах автомашины урд болон ард энэ таних тэмдгийг байрлуулна;

"Дүлий жолооч" - Шар өнгийн дэвсгэр бүхий дугуй (голч нь 160 мм) дотор 45 мм-ийн голчтой хар өнгийн гурван дугуй дүрсийг адил талт гурвалжин (орой нь доош харсан)-гийн оройнуудад харгалзах байдлаар байрлуулна. Сонгол муутай буюу дүлий хүн жолоодож явах механикжсан тээврийн хэрэгслийн урд болон ард энэ таних тэмдгийг байрлуулна;

"Хадаастай дугуй" - улаан хүрээтэй, цагаан өнгийн дэвсгэр бүхий тэнцүү талт гурвалжин (нэг талын урт нь 200 мм-ээс багагүй, хүрээний өргөн нь гурвалжны талын 1/10-тэй тэнцүү) дотор голч нь гурвалжны талын 1/3-тэй тэнцүү хар өнгийн дугуйг байрлуулж түүн дээр "Х" үсгийг цагаанаар бичнэ. Энэ тэмдгийг хадаастай дугуй бүхий механикжсан тээврийн хэрэгслийн ард байрлуулна.

3. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах талаар иргэн, албан тушаалтан дараахь үүргийг хүлээнэ:

а/стандартын шаардлага хангаагүй буюу замын хөдөлгөөний дүрмийн 2 дугаар хавсралтад заасан техникийн гэмтэлтэй, мөн тогтоосон журмын дагуу техникийн улсын үзлэг, тооллогод ороогүй, улсын дугааргүй тээврийн хэрэгслийг замын хөдөлгөөнд оролцуулахгүй байх;

б/тухайн тээврийн хэрэгслийн ангилалд тохирох жолоодох эрхийн үнэмлэхгүй (жолоодлогын дадлага хийхээс бусад тохиолдолд) буюу түүнчлэн согтууруулах ундаа, мансууруулах бодис, сэтгэгдэд нөлөөлөх эм, бэлдмэл хэрэглэсэн мөн хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж чадахааргүй өвчтэй буюу ядарсан хүнээр тээврийн хэрэгсэл жолоодуулахгүй байх;

в/гинж, ажлынхаа хэрэгслээр замын хэсэг, бусад элементийг эвдэж болзошгүй трактор, өөрөө явдаг машин, механизмыг хатуу хучилттай замаар явуулахгүй байх;

г/асмал замд 50 метрээс дотогш хариулгагүй мал, тэжээвэр амьтдыг оруулахгүй байх;

д/механикжсан тээврийн хэрэгслийг өмчилж авснаас хойш 72 цагийн дотор, ашиглалтаас хассанаас хойш 1 сарын дотор, тээврийн

хэрэгслийн марк, зориулалт, өнгө, хөдөлгүүр буюу арлын дугаар өөрчилсөн бол 7 хоногийн дотор Замын цагдаагийн албанд бүртгүүлэх.

**4.** Зам ашиглалт, хот төхжижлтийн асуудал эрхэлсэн байгууллагын ажилтан, албан тушаалтан нь зам, төмөр замын гарам буюу замын бусад байгууламж, хөдөлгөөн зохицуулах техник хэрэгслийг холбогдох норм, дүрэм, стандартын шаардлагын дагуу бүрэн бүтэн байлгах, хэрэв эдгээр нь эвдэрсэн буюу замын гадаргуу мөстсөн зэргээс хөдөлгөөнд аюул учирч болзошгүй үед түүнийг нэн даруй засах, цэвэрлүүлэх арга хэмжээ авна.

**5.** Зам дээр засварын ажил, үйлчилгээ эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллагын албан тушаалтан, иргэд дараахь үүргийг хүлээнэ:

а/засварын ажил, үйлчилгээ хийж байгаа үедээ хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, 1.20 тэмдэг тавьж анхааруулах, замын тухайн хэсгийг хашиж тусгаарлах, түүнийг тойрч гарах чиг заасан тэмдэг тавих;

б/барилгын материал, тоног төхөөрөмж, ажиллаагүй машин, механизмыг зорчих хэсгээс зайлуулах, хэрэв боломжгүй бол тойрч гарах чиг заасан тэмдэг, харанхуй буюу үзэгдэлт хангалтгүй үед нэмэгдэл улаан гэрэл тавьж анхааруулах;

в/засварын ажил, үйлчилгээг дуусгасны дараа тээврийн хэрэгсэл, явган зорчигчдын аюулгүй, хэвийн зорчих нөхцөлийг бүрдүүлэх.

**6.** Барилга, газар шорооны ажил эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллагын ажилтан, албан тушаалтан нь хатуу хучилттай зам, төмөр замын гармаар зорчих тээврийн хэрэгслийн дугуйн шавар шавхайг цэвэрлүүлэх, замын гадаргууг бохирдуулахгүй байх арга хэмжээ авна.

**7.** Дор дурдсан асуудлыг Замын цагдаагийн албатай тохиролцож зөвшөөрөл авна:

а/замын хөдөлгөөнийг зохион байгуулах, хөдөлгөөний чиг, урсгалыг өөрчлөх;

б/замын тэмдэг, тэмдэглэл, хөдөлгөөн зохицуулах техник хэрэгслийн байрлалыг өөрчлөх, шинээр тавих, хурааж авах;

в/зам, гүүр, талбай, барилга байгууламж барих, өргөтгөх, засварлах;

г/төмөр замын гарам байгуулах, өөрчлөх буюу хөдөлгөөн зогсоож түүнийг засварлах;

д/чиглэлийн тээврийн хэрэгслийн чиглэл, буудлыг шинээр тогтоох буюу өөрчлөх;

е/замын хөдөлгөөнд саад болох ажил хийх, гэрэл тавих, мод тарих, зүлэгжүүлэх;

ж/замын ойролцоо зурагт самбар, үзүүлэн чимэглэлийн зүйл байрлуулах;

з/зорчих хэсэг, явган хүний зам дээр үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах, үзвэр, үзэсгэлэнгийн зүйл байрлуулах;

и/зам дээр биеийн тамирын бэлтгэл, уралдаан тэмцээн, жагсаал, тоглолт зэрэг үйл ажиллагаа явуулах;

к/жолоодлогын дадлага хийх чиглэл, хугацааг тогтоох;

л/тээврийн хэрэгслийг тусгай дуут болон гэрлэн дохиогоор тоноглох.

**8.** Замын цагдаагийн албаны байцаагч, зохицуулагч нь дор дурдсан үүрэг хүлээнэ.

а/замын хөдөлгөөн зохицуулах дохиог ойлгогдохуйц тодорхой өгч, шуурхай зохицуулан хөдөлгөөний аюулгүй нөхцөлийг хангах;

б/хөдөлгөөнд оролцогчдоос замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон хууль, дүрэм, журам, стандартыг хэрхэн биелүүлж байгаад хяналт тавьж, илэрсэн зөрчлийг хууль тогтоомжид заасны дагуу шуурхай шийдвэрлэх;

в/замын байгууламж, зорчих хэсгийн гадаргуу, замын гэрэлтүүлэг, хөдөлгөөн зохицуулах техник хэрэгслийн бүрэн бүтэн байдалд хяналт тавьж, илэрсэн доголдыг холбогдох байгууллагын ажилтан, албан тушаалтанд мэдэгдэж хэвийн байдалд нь нэн даруй оруулах арга хэмжээ авах;

г/онцгой байдал, нэгдсэн хяналт шалгалт, шуурхай зохицуулалтын ажлаас бусад тохиолдолд тээврийн хэрэгслийг зогсоох бол очиж шалгаж байх;

д/хөдөлгөөнд оролцогчидтой зөв боловсон харьцах.

**9.** Замын цагдаагийн албаны байцаагч, зохицуулагчид дор дурдсан зүйлийг хориглоно:

а/хөдөлгөөнд оролцогчдыг үндэслэлгүйгээр саатуулах;

б/хөдөлгөөнд оролцогчдод хууль бус шаардлага, элдэв болзол тавих, хувийн ажилд тээврийн хэрэгсэл ашиглах.

## АНХААРУУЛАХ ТЭМДЭГ



1.1 Төмөр замын ажиллагаа



1.2 Төмөр замын ажиллагаа



1.3a



1.3b



1.4a



1.4b



1.4c



1.4d



1.4e



1.4f

1.4 Төмөр замын ажиллагаа



1.5 Агаар замын ажиллагаа



1.6 Төмөр замын ажиллагаа



1.7 Гэрэл замын ажиллагаа



1.8a



1.8b Ойгоор дамжуулах



1.9a



1.9 Төмөр замын ажиллагаа



1.10 Зургууль



1.11 Ойгоор дамжуулах



1.12 Хөдөлгөөнтэй ажиллагаа



1.13 Төмөр замын ажиллагаа



1.14 Хөдөлгөөнтэй ажиллагаа



1.15a



1.15b Төмөр замын ажиллагаа



1.15c



1.16 Эргэлт хийх газар



1.17 Өргөлтийн газар



1.18 Хүрээ



1.19 Үндэртэй дүүргийн ажиллагаа



1.20 Зам тасархай ажиллагаа



1.21 Мал гэрлэх газар



1.22 Агаар замын ажиллагаа



1.23 Хүрээний хурдтай ажиллагаа



1.24 Хажуу гүйдэлтэй ажиллагаа



1.25 Сөрөг дүрсүүр ажиллагаа



1.26 Хөдөлгөөнтэй ажиллагаа



1.27 Бусад ажиллагаа

1.26a



1.26b



1.26c



1.26 Бусад ажиллагаа



## ХОРИГЛОХ ТЭМДЭГ



2.1 Орш хориотой



2.2 Хэргийн хориотой



2.3 Механиктай тээврийн хэрэгсэлийн хэргийн хориотой



2.4 Автоны автомашинны хэргийн хориотой



2.5 Мотоциклын хэргийн хориотой



2.6 Тракторын хэргийн хориотой



2.7 Чаруутай тээврийн хэрэгсэлийн хэргийн хориотой



2.8 Эрдэйн усны хэргийн хориотой



2.9 Үндэст дүүрэн хэргийн хориотой



2.10 Педаан зорчигчийн хэргийн хориотой



2.11 Жингийн хязгарлалт



2.12 Тэнгэрийн ачаагийн хязгарлалт



2.13 Бүдрийн хязгарлалт



2.14 Өрмийн хязгарлалт



2.15 Урлын хязгарлалт



2.16 Хувиартай байр дотоо хязгарлалт



2.17 Газалт



2.18.а Баруун тал тийш зорх хориотой



2.18.б Зүүн тал тийш зорх хориотой



2.19 Өнцөг зорх хориотой



2.20 Гуйцжэ түүрүүл хориотой



2.21 Гуйцжэ түүрүүл хориотой төгсгөл



2.22 Автоны автомашинчид гуйцжэ түүрүүл хориотой



2.23 Автоны автомашинчид гуйцжэ түүрүүл хориотой төгсгөл



2.24 Хурим дүд хязгарлалт



2.25 Хурим дүд хязгарлалтын төгсгөл



2.26 Дуг дүд хориотой



2.27 Түр зогсоо хориотой




2.28 Удлан зогсоо хориотой



2.29 Бүх хориотой төгсгөл

БОСОО ТЭМДЭГЛЭЛ



## МЭДЭЭЛЭХ ТЭМДЭГ



5.1 Туус зам



5.2 Туус замыг тэгшитгэл

**ДАРХАН**

5.3 Суурин газрын эхлэл

**БАЯН**

5.5 Суурин газрын эхлэл

**ДАРХАН**

5.4 Суурин газрын төгсгөл

**БҮЛН**

5.6 Суурин газрын төгсгөл



5.7 Нэг чигийн эвдрэлтэй



5.8 Нэг чигийн эвдрэлтэйний төгсгөл



5.9 а Дундас баруун гар тийш нэг чигийн эвдрэлтэйгэй



5.9 б Баруундас зүүн гар тийш нэг чигийн эвдрэлтэйгэй



5.10 а



5.10 б

5.10 Эхлэлдээс хаяж эвдрэлтэйний чиг



5.11 а



5.11 Эхлэлдээс хаяж эвдрэлтэйний чиг



5.11 б



5.12 а



5.12 б Эцэстэйгээр хязгаар



5.12 в



5.13 а



5.13 б

5.13 Эцэстэйгээр тэгшитгэл



5.14 Буцаж орж галз



5.15 Зогсоол



5.16 а



5.16 б

5.16 Ялангуяа хуучир тэрэг



5.17 а



5.17 б



5.17 в



5.17 г

5.17 Ялангуяа хуучир тэрэг

## ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ТАНИХ ТЭМДЭГ



Мэргүүлтэй тээврийн хэрэгсэл




Хүүхэд тээвэрлэх өвчтэй тээврийн хэрэгсэл



Сургалтын тээврийн хэрэгсэл




Хурдны хязгаар



Дуусгай өнөг



Савар илгээх өнөг



Урт тээврийн хэрэгсэл



Төхөөр дутуу өчтэй



Дугуй жолооч




Хардагддаг дутуу

## НЭМЭЛТ ТЭМДЭГ




6.1 Объект хурган байх



6.2 Үйлэмтэй хурд



6.3 Үйлэмтэй чиг




6.4 Тээврийн хэрэгсэлд нэрлэл



6.5 Үйлэмтэй суудал



6.6 Тээврийн хэрэгсэлтэй илэрхийлэлтэй тээврийн хэрэгсэл



6.7 Илэрхийлэлгүйгээр зогсоол

6.8 Талбайтай зогсоол

6.9 Хэдэн минуттай зогсоол

6.10 Авто замыг үлгэр хийх газар

6.11 Төмөр дутуу хүн



6.12 Гол замын тал

6.13 Бүх хөдөлгөөн зогсоол

6.14 Зогсоо

6.15.1 Хүндтэй хүүхэд

6.15.а

6.15.б

6.15 Зогсоо хийхгүйгээр гадаргууны байдал





5.30 Хөрсонол



5.31 Хөрсонолын тусгагч



5.32 Чөлөөтэйгээр  
газарын хэрэгслийн  
буудал



5.33 Таксийн хэрэгсэл



5.34 Хүн эмнэлэг



5.35 Цагааруу газар



5.36 Төмнийн үйлчилгээний  
газар



5.37 Автомашины угаалга



5.38 Телефон



5.39 Хоолны газар



5.40 Худал ус



5.41 Эмчид буудал




5.42 Жуулчны бэлд



5.43 Хот айл



5.44 Аярын газар



5.45 Замын гэрээний  
хэрэгсэл

## ХЭВТЭЭ ТЭМДЭГЛЭЛ



7.1

7.2

7.3

7.4

7.5

7.6

7.7

7.8

7.9

7.10



7.11

Зүүс үзүүлэх



7.12



7.13a

Явган зүүмэл тусгах



7.13b

Явган зүүмэл тусгах



7.14

Аажуулах тусгах



7.15



7.16a



7.16b



7.16c



7.17



7.18

Тус тусгаж тусгах



7.19

Хатууруулах тусгах



7.20



7.21

Зүүс тусгах



7.22



## ДАРААЛЛЫН ТЭМДЭГ



3.1 Гол зам



3.2 Гол замын төгсгөл



3.3a



3.3b



3.3c

3.3 Тусгай зам тийшээ



3.4 Зам тавьж өгнө



3.5 Зогсолгүй явах хортой



3.6 Сэрэг хадгалууц  
зам тавьж өгнө



3.7 Сэрэг хадгалууц  
дагуу ярихтай



5.19 Тогцмолтай хурд



5.19a


 5.19b  
5.19b Муруй зам


5.19c



5.20a



5.20b



5.20c

5.20 Автоны эвэлгээг илгээх аргаар тодорхойлогдсон тээврийн хэрэгсэлтэй зам



5.21a




5.21 Чөлөөт үргэлжлэх замт



5.21c



5.22a



5.22b Чөлөөт замт

5.22b



5.23 Салхи замт



5.24 Объектын нэр



5.25 Кеймтгэлийн замт



5.26d

5.26e

5.26 Чөлөөтэй дугаар



5.27 Тэйж гарал бүрдүүн



5.27b



5.27c



5.28a



5.28b

5.28 Тойрох чөлөөт



5.28c



5.29 Зогсоулам

## ЗААХ ТЭМДЭГ



4.1.4 Чигэрхэд зөвхө



4.1.5 Баруун тал тийш зөвхө



4.1.6 Зүүн тал тийш зөвхө



4.1.7 Чигэрхэд буюу баруун тал тийш зөвхө



4.1.8 Чигэрхэд буюу зүүн тал тийш зөвхө



4.1.9 Баруун буюу зүүн тал тийш зөвхө



4.2.a



4.2.b



4.2.c

4.2.Саяаг тийш гаргахгүй



4.3 Тойрох хэдгээрэн



4.4 Суудлын зөвөлшөөн зөвхө



4.5 Үндэгд дугуйн зөв



4.6 Үеэсн хүний зөв



4.7 Хурдны дотоод хязгаарлалт



4.8 Хурдны дотоод хязгаарлалтын таслалт

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.  
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл.

Улсын Их Хурлын Тамгын газрын  
Хэвлэх хэсэгт хэвлэв.

Улаанбаатар- 12  
Төрийн ордон

☎ 329612  
Индекс: 14003

☎ 329487  
Хэвлэлийн хуудас 8